

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Хуваана, хуваахгүй


Модон алх барихын нууц

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2012. 06 сар. №11 (021)

www.mongolianeconomy.mn

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ӨГӨӨЖ БА ЭРХ ЗҮЙН ШИНЭТГЭЛ




АЧААНЫ ИХИЙГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИД ҮҮРНЭ АШГИЙН ДИЙЛЭНХИЙГ МОНГОЛЧУУД ХҮРТЭНЭ



Оюу Толгой төслийн үр ашгийг Монголчууд түрүүлж хүртэж байна. 2013 онд уурхай ашиглагдахаас өмнө 900 тэрбум төгрөгийн татвар, хураамж, төлбөрийг Монголын Засгийн газарт шилжүүлнэ.

Энэ хугацаанд хөрөнгө оруулагчид 7,8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийх бөгөөд төслийн нийт мөнгөн урсгалын 70 хүртэлх хувийг Монголын тал ямар ч эрсдэлгүйгээр хүлээн авахаар байна.





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

ТАНЫ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ
ТӨСЛИЙН ЗЭЭЛ,
ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН
ШИЛДЭГ БАНК



Монгол улсын
“ГАДААД ХУДАЛДААНЫ
САНХҮҮЖИЛТИЙН
ШИЛДЭГ БАНК”-аар
шалгарсан



ДЭЛХИЙГ ТАНТАЙ ХОЛБОХ
САНХҮҮГИЙН ГҮҮР

Хаяг: Жуулчны гудамж 7, Бага тойруу 12, Улаанбаатар хот, Монгол улс
Утас: +976 11 312362, 326289 Факс: +976 11 327028 www.tdbm.mn

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал /8800-6228/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Терэнс Эдвардс

ВЭБ РЕДАКТОР

Б.Энхмарт

ОРЧУУЛАГЧ:

Б.Үүрийнтуяа

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Б.Энхцэцэг

Э.Зоригт

Б.Ууганбаяр

Х.Хулан

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР:

Ш.Оюундарь

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ МЕНЕЖЕР:

Ж.Алтантуяа /9905-1914/

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав /8880-0825/

Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

С.Цэнд-Аюуш

“ECONOMY” ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ:

Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ:

Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН

Г.Буянбаатар

ХАЯГ:

Улаанбаатар, ЧД IV хороо,

Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

АЙВЭООӨАӨ ОҮА А:

"Интер ном"

"Цэцэг төв"

"Минж плаза"

"Алтантүлхүүр" номын дэлгүүр

"Номин" супермаркетин бүх салбар

"Макс" супермаркетин бүх салбар

"Преско" супермаркет

BTSI супермаркет

"Аз орчлон" номын дэлгүүр

"Билэг" их дэлгүүрийн номын тасаг

"Гранд Плаза" дахь супермаркет

"Мир" номын дэлгүүрийн

"Grand plaza"

"Metro mall"

"Sky" супермаркет

"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар

"Max mall"

MONGOLIAN ECONOMY

14 хоног тутамд
танг хурнэ

ЗАХИАЛГЫГ:

“Монгол шуудан”

“Түгээмэл шуудан”

“Sky” шуудан

“UB Post” шуудангийн салбарууд болон
сэтгүүлийн редакцид авч байна.

УТАС: 7011-5476
8880-0825

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn

Солонгын өнгөтэй эдийн засагт шилжих нь бидний чин хүсэл

“Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” олон улсын чуулган Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Financial times”-ийн сэтгүүлчид өгсөн ярилцлагаар эхэлсэн нь олны анхаарлыг ихэд татсан билээ. Иймээс манай сэтгүүл тус ярилцлагыг уншигчдадаа товчлон хүргэж байна...8



Хөрөнгө оруулалтын тухай хууль хөрөнгө оруулагчдын хөл тавихаар зэхэж байсан улаан хивсийг суга татах шиг боллоо

Сайн боловсрол сайхан хүмүүжлийн харгуйгаар үр хойчоо хөтлөн яваа нэгэн гэр бүлд манай сэтгүүлийн “Амьдрал” булан зочиллоо...16

Төвбанкны засаглал

Цаг үеийн нэмэлт, өөрчлөлтийг эс тооцвол Төвбанк хууль эрх зүйн хувьд шинэчлэгдэх цаг болсныг “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” чуулганы оролцогчид хэлж байв...36



Өөрчлөлт үгүйлсээр

Үндэсний бөхийн барилдаанд найраа орвол Улсын наадам сонирхолгүй боллоо гэлцдэг манайхан. Тиймээс бизнест ч спортод ч найрах, хуйвалдахыг таслан зогсоож, шударга өрсөлдөөнийг дэмжвэл хөгжил ирнэ..28

БИЗНЕС

- 8 Сайн, саарыг тэнцүүлэхийн учир
- 9 Солонгын өнгөтэй эдийн засагт шилжих нь бидний чин хүсэл
- 14 Монгол хөрөнгө оруулалтын таатай талбар мөн үү
- 16 Хөрсгүй газар цэцэг ургахгүй
- 19 Хөрөнгө оруулалтын тухай хууль хөрөнгө оруулагчдын хөл тавихаар зэхэж байсан улаан хивсийг суга татах шиг боллоо
- 22 Төвбанкны засаглал
- 24 Сайн түншлэлийн суурь
- 26 Хуваана, хуваахгүй
- 28 Өөрчлөлт үгүйлсээр
- 30 Модон алх барихын нууц
- 33 Хоёр төрийн эргэлтэд хэлмэгдсэн үнэт цаасны тухай хууль
- 34 Капитализм ба түүний тулгын гурван чулуу

Эдийн засаг

- 36 Азийн хөгжиж буй орнууд дахь өсөн нэмэгдэж байгаа тэгш бус байдалтай тэмцэх нь
- 38 Стандарт

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

Үндэсний аж ахуйн нэгжүүдэд “Эрдэнэс Тавантолгой” компанийн хувьцааг худалдах, иргэн бүрт хувьцаа эзэмшүүлэх, иргэдийн хувьцааг Засгийн газар худалдан авах үйл ажиллагааг зохицуулах журмыг Засгийн газрын энэ сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн баталлаа. Нэг сая төгрөгөө бэлнээр авсан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд хувьцаа эзэмших хүсэлтэй бол нэг сая төгрөгөө буцаан төлж, хувьцаатай болох боломжийг дээрх журмаар бүрдүүлсэн байна. Ийм хүсэлтэй иргэд тухайн сум, хорооны нийгмийн ажилтандаа хандах шаардлагатай аж.

Тавдугаар сарын 29-ний байдлаар улсын хэмжээнд 1.5 сая иргэн Засгийн газарт хувьцаагаа худалдах хүсэлт гаргаад байсан аж. Гэсэн ч хувьцааны талаарх ойлголт бага, мэдээлэл хангалтгүй, хугацаа богино байсан учир хүсэлт гаргаж амжилгүй хоцорсон иргэн цөөнгүй үлджээ. Мөн ашиг тусыг нь мэдэрсэн иргэд хувьцаагаа худалдах хүсэлтээ буцааж, хувьцаа авах өргөдөл ирүүлж эхэлсэн байна.

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

“Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд Хөгжлийн банкнаас 50 тэрбум төгрөгийн зээл олгохоор шийдвэрлээд байгаа. Үндсэн зээлийн хүү, Хөгжлийн банкнаас олгох зээлийн хүү, үйл

ажиллагааны зардал болон валютын ханшны зөрүүнээс болж зээлийн хүү жилийн 12-13.5 хувьд хүрэхээр өндөр тооцоо гараад байгаа юм. Энэ нь төрөөс жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг дэмжих чиглэлээр олгож байгаа зээлийн жилийн долоон хувийн хүүтэй байх бодлоготой нийцэхгүй байгаа аж. Иймээс Засгийн газар долоон хувийн хүүгээс давсан зөрүүг жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэж байхаар тогтжээ.

БИЗНЕС

Үндэсний хөгжил шинэтгэлийн хороо, МҮХАҮТ хамтран “Орон нутгийн бизнесийн орчны шалгуур үзүүлэлтийг боловсруулах, 2011 оны индексийг гаргах” бодлогын судалгааг анх удаа явуулжээ. Тус судалгаагаар 21 аймаг, Нийслэлийн 610 орчим бизнес эрхлэгч, аж ахуйн нэгжийг хамруулан бизнесийн орчны сайжруулах чиглэлээр төр засгийн бодлого, үр дүн болон цаашид сайжруулах чиглэлээр ямар арга хэмжээ авахыг



тодорхойлон гаргахыг зорьсан байна. Түүнчлэн орон нутгийн бизнесийн орчинд үнэлэлт өгч, индексийг нь гаргажээ. Ингэхдээ Дэлхийн банкны “Бизнес эрхлэлтийн индекс” тооцдог үндсэн аргачлалыг ашиглан, бизнес эрхлэх,

зөвшөөрөл лиценз, өмчийн бүртгэл, зээлийн боломж, татвар төлөлт, гадаад худалдаа, гэрээний хэрэгжилт гэсэн долоон үзүүлэлтээр шүүж үзсэн байна. Хөдөө орон нутагт бизнес шинээр эхлэхэд шат дамжлага ихтэй, зардал цаг хугацааны хувьд ихээхэн



чирэгдүүлдэг болохыг судалгаагаар тогтоожээ. Дээр нь татварын дарамт их, зээлийн хүү өндөр, барьцаа хөрөнгө их хэмжээгээр шаарддаг зэрэг бэрхшээл байгаа аж. Бизнесийн таатай орчинтой аймагт, Сүхбаатар, Дархан-Уул, Өвөрхангай, Баян-Өлгий, Архангай орсон бол Төв, Дундговь, Говь-Алтай, Ховд, Өмнөговь зэрэг аймаг судалгаанд бүдэрч, муу дүн авчээ.

ЭДИЙН ЗАСАГ

Сангийн яамнаас гаргасан энэ оны эдийн засгийн тоймд онцолжээ.

Уул уурхайн салбарын өсөлт, шинээр бий болох ажлын байр, гадаадын хөрөнгө оруулалт, хөдөө аж ахуйн салбарын өсөлтөөс шалтгаалан эдийн засгийн дундаж өсөлтийг ирэх онд 15 хувиас багагүй байхаар Сангийн яамнаас тооцжээ. Мөн эдийн засгийн уг өсөлтөд 2013 оноос эхлэх Оюу толгойн олборлолт онцгой нөлөөлнө гэсэн байна. Ирэх онд эдийн засаг өсөж байгаатай холбоотойгоор инфляцийг 13.1 хувьтай байхаар таамагласан аж. Түүнчлэн Засгийн газрын бодлого,

арга хэмжээ, эрэлтийг дэмжихгүй байж чадвал инфляцийн түвшин 2012-2015 онуудад нэг оронтой тоонд орох боломжтой гэж Сангийн яамнаас мэдэгдлээ. Мөн манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох алт, зэсийн дэлхийн зах зээл дээрх эрэлт болон үнэ өсөх хандлага ажиглагдаж байгаа учраас валютын ханш ирэх онуудад чангарахаар байгаа аж.

/Эх сурвалж: Сангийн яам/

АЖИЛГҮЙДЭЛ

Бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо өдөр ирэх тусам нэмэгдэж буйг Үндэсний статистикийн хорооны сар бүрийн судалгаанаас харж болно. Он гарснаас хойш энэ тоо хэрхэн нэмэгдэж буйг графикаас харна уу.

| Сар | Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо |
|-----|---------------------------------|
| I | 58200 |
| II | 58400 |
| III | 50100 |
| IV | 54000 |
| V | 58200 |

Эх сурвалж: YCX

ДЭД БҮТЭЦ

Дархан-Уул аймгийн Дархан өртөөнд 96 метр урт, гурван метр өргөн бүхий нүхэн гарц барьж эхэлжээ. Монголд анх удаа баригдаж буй энэхүү бүтээн байгуулалтад тэрбум орчим төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд уг нүхэн гарцад цагдаагийн хэлтэс, дэлгүүр гэх мэт төрөл бүрийн үйлчилгээний газар байрлахаар

төлөвлөжээ. Хоногт 32 галт тэрэг дамжин өнгөрдөг, сэлгээний галт тэрэг 24 цагаар ажилладаг уг өртөөний ачааллыг багасгах зорилгоор хийж буй нүхэн гарц ирэх есдүгээр сарын 1-нд ашиглалтад орох аж.

ХЯТАД

Манай урд хөрш хүнсний аюулгүй байдалд анхаарлаа улам илүү хандуулдаг болж байна. Учир нь, Хятадын Засгийн газрын Төрийн зөвлөлөөс хүнсний аюулгүй байдлыг сайжруулах журмыг зургадугаар сард боловсруулжээ. Энэхүү журмыг зөрчвөл хатуу шийтгэлтэй аж. БНХАУ-ын Ерөнхий сайд Вен Зябаогаар удирдуулсан Төрийн зөвлөлийн хурлын дараа “Хүнсний аюулгүй байдлыг сахих нь Засгийн газарт тулгарч байгаа хүндрэлтэй асуудлын нэг мөн” гэж хэвлэлийн мэдээнд гарсан байна. Мөн Хятадад энэ талын стандарт хангалтгүй байдаг учраас хүнсний аюулгүй байдалтай холбоотой эрсдэлтэй асуудал ихээхэн гардаг. Иймд төрийн зүгээс хуулийн хараа хяналтыг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг бүхэлд нь хамрах үр дүнтэй механизмыг хэрэгжүүлэх шаардлагатай байна гэж тус мэдээнд өгүүлжээ.

Хятадын Засгийн газар бизнес эрхлэгчдэд хоол хүнсний чанар, аюулгүй байдалтай холбоотой хариуцлагаа ухамсарлахыг сануулж байна. Мөн хүнсний аюулгүй байдлын иж бүрэн стандарт, чанарыг үнэлгээний

тогтолцоог сайжруулахад, төрийн байгууллагын агентлагуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, хүнстэй холбоотой онцгой байдалд хариу өгөх тал дээр анхаарахад илүү идэвх зүтгэл гаргахыг уриалжээ.

ОРОС

ОХУ нь 2013 онд учирч болзошгүй хямралыг даван туулахад зориулж тодорхой хэмжээний мөнгийг улсын төсөвтөө суулгахаар болжээ. Энэ талаар ОХУ-ын Сангийн сайд Антон Сулианов “ОХУ-ын засгийн газар нь 200 тэрбум рубль буюу зургаан тэрбум ам.долларыг хямралыг даван туулахад дотоодын компаниудаа дэмжих үүднээс ирэх онд төсөвлөхөөр төлөвлөж байна” гэж өнгөрсөн бямба гаригт мэдэгдсэн байна.

Энэ оны хувьд Орос улсын хямралыг давах гол механизм нь улсын батлан

даалт байсан. Түүнчлэн уг батлан даалтаас нийт 80 тэрбум рублийг гаргахаар төлөвлөсөн ч Засгийн газар 26 тэрбум рубль гаргахаар шийдвэрлэсэн байна. Харин 2013 оны хувьд Хойд хөршийн Засгийн газар хямралыг давах өөр механизмыг хэрэгжүүлэхээр болсон аж. Энэ талаар Антон Сулианов “Бид хямралын эсрэг 2012 онд авсан арга хэмжээг дахин давтана гэж бодохгүй байна. Гэхдээ энэ онд гаргасан хөрөнгөнөөс илүү их мөнгө төсөвлөх болно” гэжээ.

ЭНЭТХЭГ

Бүтээгдэхүүн үйлдвэрлэл 1.7 хувиар өснө гэх таамаглал талаар болсон тухай Энэтхэг улсын албаныхан мэдээлж байна. Дөнгөж 0.1 хувийн өсөлтийн үзүүлэлттэй гарсан үйдвэрлэлийн хэмжээ тус улс руу чиглэх гадаадын хөрөнгө

оруулалтад сөргөөр нөлөөлж болзошгүйг Энэтхэгийн Standard & Poor's үнэлгээний байгууллага мэдээлсэн байна. Шинжээчдийн хэлж буйгаар тус улсын Засгийн газар эдийн засгийн өсөлтөө хадгалахын тулд дорвитой алхам хийх цаг болсон аж. Учир нь, өнгөрсөн сард гаргасан Засгийн газрын албан мэдээлэлд Энэтхэг улсын эдийн засаг жилийн эхний хагаст дөнгөж 5.3 хувиар өссөн нь сүүлийн арав гаруй жил байгаагүй муу үзүүлэлт хэмээн тайлбарласан. Түүнчлэн баян, ядуугийн ялгаа улам ихсэж буй тус улсын мөнгөн тэмдэгтийн ам.доллартай харьцах ханш 25 хувиар буурсан. Мөн дотоодын улс төрийн тогтворгүй байдал улсын ДНБ-ий өсөлтийг сааруулж эдийг засгийн шинэ бодлого боловсруулахад саад учруулж байна хэмээн олон улсын шинжээчид үзэж байгаа юм.





ОНЦЛОХ СЭДЭВ

САЙН, СААРЫГ ТЭНЦҮҮЛЭХИЙН УЧИР

И.ОТГОН

“Mongolian Economy” сэтгүүл энэ удаагийн дугаартаа хууль эрх зүйн шинэтгэл гэдэг албархуухүндсэдвийг онцлон хүргэж байна. Саяхан /2012.05.29-30/ Ерөнхийлөгчийн Тамгийн газраас зохион байгуулсан “Эдийн засгийн өсөлт, эрх зүйн шинэтгэл” сэдэвт олон улсын чуулганы талаар эргэцүүлж суутал нэг ийм үг санаанд буув. “Хүмүүсийг араасаа дагуулахыг хүсэж байвал, өөрөө тэдний араас дага” гэж. Энэ үгийг “Суут хүмүүсийн хэлсэн сургаал үгс” номноос уншсан санагдаж байна.

Монгол Улс алт, зэс, нүүрс тэргүүтэй асар олон төрлийн ашигт малтмал газрын хэвлийдээ нуусан гэдгээрээ ертөнцийн сонирхлыг татаад багагүй хугацаа өнгөрлөө. Тиймээс уул уурхай монголчуудыг хэдэн үеэр нь тэжээнэ гэсэн том хүлээлт дэлхий нийтэд бий болсон.

Удаах Монгол орныг бөмбөрцгийн анхаарлын төвд аваачсан зүйл нь эдийн засгийн хурдацтай өсөлт. Өнгөрсөн жил Монголын эдийн засгийн өсөлт 17.5 хувьтай гарч, дэлхийг алмайруулсан. Харамсалтай нь дотоодод ядуурлын түвшин дорвитой буурахгүй, өдөр ирэх бүр баян, хоосны ялгаа бүр ч гаарч байгаа нь ойлгомжгүй. Гэтэл Монголын талаар “Төв Азийн Кувейт”, “Азийн бар”, “Чоно эдийн засаг”, “Нүүрсний Саудын Араб” зэрэг сайныг зөгнөсөн нэршил олон дуулдах нь таатай. Түүнчлэн Монгол орныг “Minegolia”, “Moncoalialia” гэж уурхай, нүүрстэй нь холбон хочлох нь ч бий.

Тэгвэл эдийн засгийн өсөлтийн үзүүлэлтээрээ дэлхийд тэргүүлж буй Монгол хоёр сар гаруйнхны өмнө дахин дэлхийн чихийг дэлдийлгэж, нүдийг бүлтийлгэв. Тэр нь, Хятадын төрийн өмчит “Чалко” компани Монголын уул уурхайн “Саус Гоби Сэндс” компанийн талаас илүү хувийг эзэмших тухай дуулиан байлаа. Уг асуудалтай холбоотой Монголын төр “Эзэн нь юмаа мэдэж, Эрэг нь усаа хашдаг”

гэдэг зүйр үгийг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлж, нүд ирмэхийн зуурт Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг баталсан. Сонгууль, сенсааци хоёроор жигүүрлэн “ногоон гэрлээр” батлагдсан тус хуулийг “Зайлшгүй байх ёстой зүйл” гэж олзуурхах нэгэн байхад, “Хэт нэг талыг барьсан, тэнцвэргүй хууль. Гадаадын хөрөнгө оруулагчдыг үргээж ч болзошгүй юм” хэмээн шүүмжлэх хүн ч цөөнгүй. Түүнчлэн эдийн засаг, уул уурхайн хөгжлөөс гадна хууль шүүхийн асуудлаараа ч Монгол орон олон улсын анхаарлыг татах болсон. Монгол Улсын гурав дахь Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг Авлигатай тэмцэх газраас сүр дуулиантай барвчилсан нь бас л дэлхий нийтэд сонирхолтой байв.

Ийнхүү Монгол Улс байн байн ертөнцийн анхаарлын төвд орох нь таатай ч баялгаасаа болж балрах уу, баяжих уу гэдэг нь тун бүрхэг байгаа нь санаа зовоосон асуудал болоод буй.

“Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” олон улсын хурлын үеэр хурдацтай хөгжиж буй Монголын эдийн засагт эрх зүйн шинэтгэл хэрэгтэй талаар ний нуугүй ярилцсан. 200 орчим оролцогчийн талаас илүү нь гадаадын зочид, төлөөлөгч байсан юм. Монгол нэгэнт дэлхийн анхаарлын төвд орсон хөгжиж буй улс учраас хөгжингүй орныхон биднийг ойлгох учиртай. Тийм ч учраас хурлын нээлтийн үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Financial times”-ийн сэтгүүлчид ярилцлага өгсөн. Хурлын төлөөлөгчид ч түүний ярилцлагыг бүтэн цаг шимтэн сонссон. Манай сэтгүүл уг арга хэмжээг дэмжин оролцсон учраас тус чуулганы үеэр хөндөгдсөн гол сэдвүүдийг нийтлэл, ярилцлага хэлбэрээр хүргэж байна. Хурал хөрөнгийн зах зээл, банк санхүү, өрсөлдөөн, гадаад худалдаа, хөрөнгө оруулалт зэрэг 10-аад сэдвээр болсон юм. ■

ЕРӨНХИЙЛӨГЧ ЯРЬЖ БАЙНА

СОЛОНГЫН ӨНГӨТЭЙ ЭДИЙН ЗАСАГТ ШИЛЖИХ НЬ БИДНИЙ ЧИН ХҮСЭЛ



“Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” олон улсын чуулган Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн “Financial times”-ийн сэтгүүлчид өгсөн ярилцлагаар эхэлсэн нь олны анхаарлыг ихэд татсан билээ. Иймээс манай сэтгүүл тус ярилцлагыг уншигчдадаа товчлон хүргэж байна.

-Ноён Ерөнхийлөгч өө, юун түрүүнд Монгол Улс тусгаар тогтнож, бие даасан орон болсон талаарх асуултаар ярилцлагаа эхэлье. Зөвлөлтийн их гүрэн задарч, Монгол Улс бусад коммунист орноос ялгаран тэр

даруй Ардчилсан орон болсон байдаг. Тэгвэл энэхүү хөдөлгөөний удирдагчдын нэг байсны хувьд Та өөрийн тайлбарыг өгөхгүй юу?

-Монгол Улс хуучин социалист системийн орон байхдаа тусгаар тогтносон улс байсан билээ. Эрх

чөлөө хүн ба улс орны аль алинд хэрэгтэй. Хувь хүн эрх чөлөөтэй байх ёстой. Ингэж чадвал тухайн ард түмэн эрх чөлөөтэй байна.

Угаас эрх чөлөөт сэтгэлгээ, бие даасан байдал монголчуудад өв уламжилж ирсэн чухал үнэт зүйл. ▶

Бидний охин ухаалаг, чадвар боловсрол өндөр тул айлын сайн эзэгтэй болно

▶ Энэ мэдрэмж Монгол Улсыг тусгаар тогтнолоо тунхаглаж, эрх чөлөөт орон болоход тэр дундаа 1990 оноос хойш их үүрэг гүйцэтгэсэн гэж бодож байгаа. Монгол дахь өөрчлөлтийн хувьд онцлог их бий. Нэгдүгээрт, Азийн орнуудад улс төр, эдийн засгийн шинэчлэлийг зэрэг хийх боломжгүй гэсэн ойлголт байдаг. Үүнийг монголчууд эвдэж 1990 оноос улс төр, эдийн засгийн шинэчлэлийг хамтад нь хийж хүн арддаа эрх, эрх чөлөөг олгох шинэчлэлийг давхар хэрэгжүүлсэн билээ. Мөн 1990 онд нийгмийн өөрчлөлтийг хийхдээ тайван замаар, яриа хэлэлцээрийн аргаар шийдэж чадсан нь бас нэг онцлог юм. Удаах нь 1990 оноос хойш 22 жилийн хугацаанд уг шинэчлэлийг үргэлжлүүлэх хүсэл эрмэлзлэлдээ монголчууд эргэлт буцалтгүй тууштай хандсан. Монгол Улс бүс нутагтаа эдийн засаг, улс төр, нийгмийн хувьд хамгийн чөлөөт тогтолцоотой орон болж хувирсанд бид бахархаж явдаг.

-Монгол Улс олж тогтоосон ба илрүүлээгүй асар их хэмжээний эрдэс баялаг дээр сууж буй нь өнөөдөр нэгэнтээ нууц биш. Байгалийн нөөцөөр баян орнуудын эрдэс баялаг зарим үед ерөөл бус хараал болж хувирдгийг Баруун Африкийн орнууд болоод тэдний газрын тос гэрчилнэ. Мэдээж бид Монгол Улсыг дараагийн Чили эсвэл Катар болоосой гэж хүсэж байна. Харин Монгол дээрх алдааг давтахгүйн тулд хэрхэн сэргийлэх вэ?

-Ер нь байгалийн баялаг ихтэй улс орны хувьд Монгол Улс буруу эсвэл зөв замын алинаар явах уу гэж асуулаа гэж ойлголоо. Баялаг ихтэй мөртлөө буруу зам руу явсан орнууд голдуу хаалттай улс байдаг. Харин зөв замаар явж байгаа нь нээлттэй улс байдгийн жишээ нь Норвеги Австрали, Канад зэрэг ардчилсан орнууд юм. Зөв замаар яваа бол гарч байгаа дутагдал, бэрхшээлүүдээ тухай бүр нь засч чадна. Яагаад гэвэл

ард түмэнд тэр мэдрэмж нь байдаг. Байгалийн баялаг, эдийн засгийн өсөлтийн өгөөж бидэнд ирэхгүй байна, нийгэмд баян, ядуугийн ялгаа нэмэгдэж байна гэдэг дуу хоолой, мэдрэмж эрх баригчдаас биш, ард түмнээс илүүтэй ирдэг. Тэгэхээр нэгэнт ард түмний хүсэл зоригоор улс орны хувь заяа шийдэгддэг, түүнийг удирдагч нь дагадаг учраас бид алдаагаа засаад явах боломжтой. Монголчууд баялагтаа эзэн сууж, ард

Авлига гэгч нь Монголыг их муухай харагдуулж байгаа зүйл. Чөлөөт нийгмийг хамгийн хүнд байдалд оруулж цаашдын өсөлтийг зогсоодог гол хүч бол авлига. Авлига засаглал, төрийн бүтэц болон түүний бодлоготой холбогддог. Ийм учраас миний одоогийн өмнөө тавьж, уриалж байгаа нэг зорилго бол ирэх дөрвөн жилийг төрөө засах он жилүүд болгоё гэдэг юм.

иргэдийн эрх ашигт нийцсэн хөгжингүй орон болох баталгаа нь Монгол Улсын нээлттэй байдал. Бид өөрийн сүүдэртэй талыг байнга шүүмжлэн ярьж чаддаг. Энэ тухай Монголын олон нийт бүрэн ойлголттой байх боломж байдаг. Учир нь, хүмүүсийн мэдээлэл авах боломжийг чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хангаж өгч байна. Үүнийг улам цаашаа нээж өгөх ёстой. Дээр нь бусдаас суралцах боломж байна. Ардчиллыг нэг үгээр тайлбарла гэвэл, өөрийн болон өрөөлийн алдаа ба амжилтаас суралцах боломж гэж ойлгодог. Суралцана гэдэг дэвшихийн нэр.

-Авлигын талаар асууя л даа. Мэдээж авлига нь улс орон болгоны санааг чилээсэн асуудал нь үнэн. “Транспаренси Интернэшнл” байгууллагын жагсаалтыг үзэхэд, Монгол Улс ил тод байдал, авлигын тал дээр тийм ч сайн үзүүлэлттэй биш байсан. Улстөрчид Парламентад орохын тулд хоёр сая орчим ам.долларыг зарцуулдаг гэсэн тооцоо байна. Гэтэл Парламентын гишүүний сарын цалин дөнгөж 800 орчим ам.доллар гэхээр Парламентад сонгогдох нь орлогын олон эх үүсвэрийг бий болгодог гэсэн хардлагыг иргэдэд төрүүлж байна. Та энд суугаа хүмүүст Монголын төр, засаг болон монголчуудад үүнтэй шийдвэртэй тэмцэх хүсэл зориг бий гэдгийг батлан хэлж чадах уу?

-Энэ асуудалд бид санаа зовж байгаа. Ялангуяа авлигатай холбоотой Монголын нэр төрийг сэвтүүлсэн мэдээллийг хараад бид ичдэг. Авлига гэгч нь Монголыг их муухай харагдуулж байгаа зүйл. Чөлөөт нийгмийг хамгийн хүнд байдалд оруулж цаашдын өсөлтийг зогсоодог гол хүч бол авлига. Авлига засаглал, төрийн бүтэц болон түүний бодлоготой холбогддог. Ийм учраас миний одоогийн өмнөө тавьж, уриалж байгаа нэг зорилго бол ирэх дөрвөн жилийг төрөө засах он жилүүд болгоё гэдэг юм. Монгол Улсад мөнгө, байгалийн баялаг байхгүйдээ бус шударга ёс, тэгш эрхэт боломж үгүй учраас ард иргэдийн амьдрал муу байна. Өнөөдрийн энэ “Их тэнгэр”-ийн чуулган үүнд чиглэж байгаа гэж бодож байгаа.

Энэ тухай 10, 20 жилийн өмнө битгий хэл, таван жилийн өмнө ярихад ч манай нийгэм хүлээж авах болоогүй байсан. Өнөөдөр эдийн засгийн өгөөжийг нийтэд хүртээлтэй болгох үндсийг яаж тавих вэ гэж сайн санаат нөхөд болох шинжээч судлаачид, ард иргэд, төрийн бус байгууллагатай ▶

Монголчууд очих газраа бодож морио барьж, эмээллэдэг

▸ бид нээлттэй ярьж эхэлж байгаа нь маш чухал. Би хувьдаа авлигатай тэмцэх улс төрийн хүсэл зориг эрэмгий байдал Монголын төр, засагт бүрэн байгаа гэдэгт итгэдэг. Бид энэ чиглэлд эрчимтэй ажиллаж чадна. Сая манай Парламент завсарлахынхаа өмнө шүүхтэй холбоотой миний санаачилсан зургаан хуулийг баталлаа. Нийтдээ шүүх, эрх мэдлийг өөрчлөхийн тулд 18 хуулийг өөрчлөх хэрэгтэй байгаа юм. Бид цаашдаа шилжилтийн шинжтэй олон алхмыг хийнэ.

-Ямар төрлийн эрдэс баялаг энэ оронд бий вэ. Нэг хүнд ногдох хэмжээг Та хэрхэн харж байна вэ. Нэг хүнд ногдох нөөц баялгийн хэмжээгээр Катар шиг болж чадах болов уу. Хэдий хэрийн хугацаа болоод түвшний талаар бид ярьж байна вэ?

-Өнгөрсөн жил Монгол Улс эдийн засгийн хувьд хамгийн өндөр өсөлттэй орон болж тооцогдсон. Зарим нэг судалгаа 17.5 хувийн өсөлтийг үзүүлээ ч гэж байсан. Гэхдээ нийгмийн сэтгэл зүйг харахад энэ өсөлтөд баярлахаас илүү болгоомжлох хандлага байна. Ер нь манай иргэд өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд саад бэрхшээлийг биеэрээ туулсан учир их хэрсүү болсон байгаа. Уул уурхайг даган орж ирж байгаа хөрөнгө оруулалт, экспортын нэмэгдлээс үүдэлтэй нэг талыг барьсан өсөлт болчихоод байгаа учир тэр л дээ.

Бусад салбарт өсөлт байна уу гэвэл бараг үгүй. Хоёр жилийн дотор дотоодын нийт бүтээгдэхүүн нь 100 хувиар өсч буй хурдыг хуучны дэд бүтэц, эдийн засгийн чадавх гүйцэх аргагүй байна. Тэгэхээр бид уул уурхайн орлогоороо өөр салбарт хөрөнгө оруулалт хийх замаар ухаалаг, тооцоотой бодлогын хүчээр энэ саадыг давж чадна. Энэ тухай хэлэлцүүлэг болж байгаа. Улсын Их Хурлын сонгууль бол нэг төрлийн санал асуулга гэж бодож байна. Энэ дээр хамгийн зөв, ухаалаг, тооцоотой

бодлого гаргаж чадах тэр л улс төрийн нам, нэр дэвшигч ард түмнээс дэмжлэг авах магадлалтай.

Энэ их баялаг дээр сууж байгаагийн хувьд нэн түрүүнд монголчууд болон гаднынханд баялгаа хэрхэн хуваах тал дээр шийдэмгий байх ёстой. Та бүхэнд тэд хэрэгтэй. Учир нь, гаднынханд туршлага, мөнгө, хуульчид гэх мэт одоогоор монголчуудад байхгүй хөрөнгө байна. Цаашлаад дотооддоо хуваах хэрэг гарна. Хамгийн эхэнд гадаадынхантай хэрхэн хуваалцах гэж байгаа асуудлаас эхэлье. Одоо хэлэлцэгдэж буй гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль нь дээрх асуудлыг зохицуулах суурь зарчмуудыг тодорхойлох оролдлого

Бид улс дотроо өөрийнхөө төрийн өмчид хязгаарлалт тавьдаг атлаа гадаадын төрийн өмч орж ирэхэд хязгаарлалт тавихгүй сууж болохгүй шүү дээ.

гэж харж байна.

Монголчууд бидэнд гадаадын хөрөнгө оруулалтыг татах шаардлага өөрчлөлтүүдийн тэргүүнд байсан. Энгийнээр хэлбэл, охиноо нөхөрт гаргахаар зэхэж буй айл шиг аль болох гоё хувцаслаж сайхан харагдуулахыг зорьж байлаа. Гэхдээ хүргэн болохоор боломжийн улсуудыг олж хараагүй. Өнөөдөр манай охиныг олж харсан гэж бодож байна. Бидний охин ухаалаг, чадвар боловсрол өндөр тул айлын сайн эзэгтэй болно. Тийм учраас бид өөрсдийн хэмжүүрээр сонголтынхоо мөн чанарт ханддаг байх ёстой. Эхлээд бид нээлттэй байх шаардлагатай байсан бол одоо Монгол Улс тэр дундаа уул уурхайн салбар гадаадын

хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд орсон байгаа. Бид өөрийнхөө үндэсний болон ард нийтийн эрх ашгийг нэн тэргүүнд гаргаж тавих ёстой. Үүнийг л баримталж байгаа. Өмнө нь бидэнд мөнгө санхүү чухал байлаа. Энэ хоёрын алтан тэнцвэр дээр бидний цаашдын бодлого явах хэрэгтэй. Саяхан гадаадын хөрөнгө оруулалт, төрийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, мөн зөвшөөрөлтэй холбогдсон асуудал Парламент дээр яригдсан. Энэ асуудлаар бараг гурван жилийн өмнө хуулийн төсөл өргөн барьж нээлттэй хэлэлцэж байгаад сая шийдлийг нь оллоо. Түүнээс биш, "Чалко"-гийн асуудал гарч ирэнгүүт бид энэ тухай ярьж эхэлсэн юм биш.

Энд нэг зүйлийг хэлмээр байна. 1990 оноос өмнө Монголын бүх өмч төрийнх байлаа. Бид 1990 оноос хойш хувийн өмчийн оролцоог аль болохоор дэмжихээр оролдож ирсэн. Төрийн өмч дээр хатуу хяналт тавин хязгаарлаж, хувийн санаачилгыг дэмжихээр оролдож ирсэн. Бид улс дотроо өөрийнхөө төрийн өмчид хязгаарлалт тавьдаг атлаа гадаадын төрийн өмч орж ирэхэд хязгаарлалт тавихгүй сууж болохгүй шүү дээ. Тэгэхээр ийм зохицуулалтыг зөвхөн Монгол Улс ч биш, нээлттэй эдийн засагтай, тэр дотроо маш хүчирхэг эдийн засагтай улс орнууд хийсэн байдаг.

Хамгийн сайн зохицуулалттай сайн хууль гаргалаа гэж би хэлж чадахгүй. Учир нь, энд шүүмжлэлтэй хандах зүйлүүд бий. Байнга нээлттэй байх хуулийг сайжруулах боломж бий. Түүний дотор бидэнтэй хамтран ажилладаг болон Монгол Улсад хөрөнгө оруулахыг сонирхож буй хүмүүсийн санаа бодлыг ч гэсэн цаашдаа нээлттэй сонсох болно. Анх удаагаа Монгол Улсад ийм зохицуулалтыг хийлээ.

-Та гаднын төрийн өмчийн компаниудаас болгоомжилж байна уу, эсвэл Хятадын төрийн өмчит компаниудаас болгоомжилж байна уу? ▸

► -Гадаадын төрийн өмчтэй компаниудын оролцооноос Монгол ч биш, бүх л улс орон болгоомжилдог шүү дээ. Бидэнд аль нэг орны төрийн өмчийн компанийн тухай хуульдаа тусгайлан заасан зүйл байхгүй. Энэ хуулийн заалт, зохицуулалт бол аж ахуйн нэгж, нийт төрийн өмчтэй компаниудад хамаарч байна.

-Би Монголд ирснийхээ дараахан гадаадын хэд хэдэн хөрөнгө оруулагч компанийнхантай уулзсан. Тэдний зүгээс 51 хувийн хяналтыг л авдаггүй юм бол сонирхохгүй байна. Учир нь эрсдэл хэтэрхий өндөр. Миний ойлгосноор шинэ хуульд хэрэв гаднын компани хяналтыг авахыг хүсч байгаа бол Парламентаар хэлэлцэж батална гэж заасан. Та үүнийг эцсийн шийд гэж үзэж байна уу. Та гаднын хөрөнгө оруулагчдын энэхүү яриаг хоосон сүрдүүлэг гэж үзэх үү?

-Ер нь 51 хувийн хяналт гэдэг бол бүх шалгуурын дээд тал биш. Энэ бол зөвхөн нэг нь. Хоёрт ийм шалгууртай холбогдсон асуудал гарч ирэх юм бол асуудлыг шийддэг механизмыг тодруулж өгсөн. Энэ бол Парламентын түвшинд ярих асуудал. Иймээс ямар асуудал Засгийн газрын түвшинд, ямар нь хөрөнгө оруулалтынхаа хуулийн хүрээнд аж ахуйн нэгжийн түвшинд шийдэгдэх, ямар асуудал Парламентын түвшинд яригдах вэ гэдэг үүднээс зохицуулалт хийж өгсөн. Түүнээс биш, огт яригдахгүй, шийдэгдэхгүй асуудал гэж байхгүй. Асуудал шийдэх механизмыг тодруулж л өгсөн гэж би хувьдаа ойлгож байгаа.

-Миний бодлоор зарим гадаадын хөрөнгө оруулагч үүнд удахгүй болох сонгуулийн нөлөө байна гэж үзэж байгаа. Тэд Парламентын сонгууль дууссаны дараа нөхцөл байдал харьцангуй тогтворжино хэмээн найдаж байгаа. Энэ хэр үндэслэлтэй горьдлого вэ?

-Сонгуульд санал өгсний дараа нар мандана гэдгийг монголчууд бүгдээрээ ойлгож байгаа. Анх удаа сонгуульд орж байгаа биш. Энэ бол зургаа дахь удаагийн Парламентын сонгууль. Ийм учраас энд санаа зовох зүйлгүй. Ер нь монгол хүн хол, ойрыг харж сонголтоо хийдэг. Монголчууд очих газраа бодож морио барьж



Фотог Б.Бямба-Очир

эмээллэдэг. Зөвхөн өнөөдрийг эсвэл нэг талыг харж асуудлыг шийддэг хүмүүс биш ээ. Тэд сонголтоороо эрх баригчиддаа тодорхой мессеж илгээж чадна гэж бодож байна. Төр, засгийн зүгээс ч ямар бодлогыг манай ард иргэд дэмжиж, ямар бодлогыг эсэргүүцэж байна гэдэг дээр тулгуурлаж шийдвэрээ гаргах боломж бий.

-Соёлын талаар нэг асуулт асууя. Хөгжлийн хурдацтай үе шатад хүрсэн үедээ үндэсний эрхэм зорилгыг бий болгосон Япон, Өмнөд Солонгос, Сингапур зэрэг Азийн зарим орон түүнчлэн Филиппин зэрэг үндэстний хэмжээнд нэгдэж чадаагүй орнууд ч бий. Таны бодлоор Монгол энэ дүр

зургийн хаана нь багтах бол. Өргөн уудам нутагтай нүүдэлчин соёл иргэншилтэйн хувьд монголчууд илүү бие даасан, тус тусын сайн сайхныг боддог мэт харагддаг. Гэвч энэ тайлбар төдийлэн оновчгүй байх талтай учир танд тавих зүй ёсны асуулт болов уу?

-Монгол Улс өнгөрсөн жил төр улсаа үүсгэснээс хойших 2220 жилийн ойг тэмдэглэсэн. Гэвч бид энд 20 жилийнх нь тухай ярьж байна. Монголчууд тухайн үедээ дэлхийн нийт хуурай газрын талыг эзэгнэсэн гүрэн байгуулж, 200-300 жил дэлхийн бодлогыг тодорхойлж явсан үндэстэн. Тэгэхээр тэр эзэнт гүрний шалгарсан уламжлал монголчуудад өнөөдөр ч бий. Би хувьдаа монголчуудынхаа ►

Эмэгтэй хүнд зовж зүдэрсэн хүмүүсийн асуудлыг бүрэн өнгөөр харж чаддаг онцгой мэдрэмж байдаг

▶ асуудалд маш зөв байрнаас ханддаг, аливаад дасан зохицох чадвартай, асуудлыг гаргаж ирээд шийдлийг хамтдаа олдог чадвар олон зуун, магадгүй олон мянган жил дамжин ирсэн уламжлалын үр дүн байх гэж боддог. Дээр нь тэр уудам газар нутгаасаа хамгийн сайхан хэсэг буюу голомтыг нь бид эзэмшиж байна. Нөгөө талаасаа нүүдлийн амьдрал бол өнөөдрийн ойлголтоор байгальд ээлтэй өндөр түвшний амьдрал юм. Нүүдэлчид хэзээ ч байгальдаа хог тарьж, усаа ширгээж бохирдуулдаггүй гайхамшигт уламжлал монголчуудад бий. Тиймээс манай ард иргэдийн зүгээс байгаль орчинтой холбоотой тавигддаг шаардлагууд байдаг. Төр, засгийн зүгээс тэдний гаргаж ирсэн асуудалд хэрхэн хариулж, хэрхэн шийдэл гаргах вэ гэдэг өнөөдрийн бодлого тодорхойлогчдын асуудал. Монголд асуудал байгаа бол бодлого тодорхойлогчдоос болохоос биш, ард иргэдээс шалтгаалсан зүйл байхгүй гэдэгт би итгэдэг.

-Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр, нэн ялангуяа гаднын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр хуучин Ерөнхийлөгч баривчлагдсан талаар, баривчлах үйл ажиллагааг тойрсон маш олон мэдээлэл тархсан. Та хэвлэл мэдээлэл гарсан мэдээллийг үнэн зөвөөр мэдээллэгдсэн гэж үзэж байна уу. Яг юу болсон талаар Та өөрийн байр суурийг хэлэхгүй юу?

-Улс төрийн амьдралдаа хэвлэл мэдээлэл олон нийтийн тухайд барьдаг хувийн зарчим бий. Би хэзээ ч хэвлэлийг буруутгадаггүй. Хэвлэл мэдээллээр сөрөг мэдээлэл гарсан бол би хувьдаа өөрийгөө л буруутгадаг. Учир нь, бид тийм шалтаг өгсөн, эсвэл тэр буруу ойлголтыг төрүүлсэн байж таарна. Иймд бид алдаагаа засахад байнга нээлттэй байгаа. Монгол Улсад авлигатай тэмцэхэд, хүний эрх, эрх чөлөө, хуулийн шударга хэрэгжилтийг хангахад бидэнтэй бүтээлчээр хамтарч ажиллах байгууллага, иргэд, олон улсын байгууллага, хэвлэл мэдээллийнхэнд

Монгол Улс нээлттэй. Авлига, мөнгө нь өөрөө том хүч. Тэр сүлжээ, мөнгөний хүч хаана ч хүрч чаддаг. Дээр нь авлигатай тэмцэнэ гэдэг амар зүйл бишийг манай ард иргэд нийтээрээ харж байгаа байх. Зүгээр яриад тунхаглаад орхихын оронд тодорхой үр дүн, хуулийн тэгш хэрэгжилтийг шаарддаг зүйл. Тийм учраас энэ үйл явцуудаас Монголын нийгэм бас л суралцаж байгаа. Эндээс зөв сургамж аваад бид цааш явах ёстой.

Миний баримталдаг нэг зарчим нь шүүхээр аливаа хүний асуудал шийдэгдээгүй байхад хэн нэгнийг гэм буруутай, муу сайн гэж хэлэх ёсгүй гэж бодож байгаа. Манайд ч гэсэн тэр зарчим байдаг. Нөгөө талаасаа хууль хяналтын байгууллага, хууль зөрчсөн гэж үзэж байгаа этгээд, ямар ч иргэнийг шалгах, хуулийн дагуу асуух, тэр хүнээс тодруулга авах, хуулиар тавигдаж байгаа шаардлагыг биелүүлэхгүй аваас хуулийн дагуу албадлага хэрэглэж, заасан арга хэмжээнүүдийг авах эрх нь нээлттэй. Ерөнхийлөгчийн хувьд тэр бүхэнд нөлөөлөх боломжгүй. Таны асуусан асуулт олон нийтийн анхаарал татсан байх.

Сүүлд нэг анхаарал татсан асуудлыг жишээлье. Тэр нь Монголоос олдсон байх магадлалтай гэх 80 сая жилийн өмнө амьдарч байсан динозаврын араг яс Америкт зарагдах гэж байгаа тухай шуугиан юм. Монголоос гарсан бол бид эргүүлж авчирч чадна. Өнөө цагт монголчууд дахиад нэг динозавртай нүүр тулсан нь авлига юм. Бид авлига гээч динозавраас үнэхээр улс орон, ард түмэн, тэдний эрх чөлөө, шинэ сонголтыг аварч чадах уу, үгүй юу. Нэг бол авлига гэдэг динозаврын атганд орж, айсан орон байх уу. Аль эсвэл энэ динозаврыг хуулийн гарт буулгаж авч чадсан улс орон байх уу. Ийм л хувь заяаны сонголтод бид тулчихаад байна.

-Сүүлийн асуулт сонин байж магадгүй. Энэ ороо бусгаа эдийн засаг, улс төр, нийгмийн хувьд ирэх жилүүдэд эрс өөрчлөгдөх гэж байна. Миний ажигласнаар монгол

эмэгтэйчүүд эрчүүдээ бодвол эдгээр өөрчлөлтүүдэд дасан зохицох чадвар илүү өндөр, бэлтгэгдсэн байх боломжтой мэт. Энэ нь нийгэмд хагарал, зөрчил гэх мэт асуудал үүсгэх магадлалтай. Та энэ талаар юу гэж бодож байна?

-Монголын нийгэмд эмэгтэйчүүдийн оруулж ирсэн хувь нэмэр үнэхээр онцгой. Монголчуудын эмэгтэй хүнд тодруулбал ээж, эмээ, охид бүсгүйчүүдээ хандах хандлага гайхамшигтай. Нэг үгээр, эмэгтэй хүний ачийг чандлан хадгалах гүн хүндэтгэл бий. Нөгөө талаас, түүнд нь манай эмэгтэйчүүд үеийн үед хүрч үйлчилж ирсэн хүмүүс гэж боддог. Эмэгтэй хүнд зовж зүдэрсэн хүмүүсийн асуудлыг бүрэн өнгөөр харж чаддаг онцгой мэдрэмж байдаг. Тийм учраас эмэгтэйчүүдийг төрийн ба олон нийтийн байгууллагын өндөр дээд түвшинд гарахад бид дэмжиж ажиллах ёстой. Улс төрийн шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо доогуур байгаа. Харин орон нутгийн түвшинд 30-40 хувьтай байна. Боловсрол, эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд зонхилдог.

Бид сая сонгуулийн хуульд өөрчлөлт оруулж, нэр дэвшигчдийн 20-иос доошгүй хувь нь буюу 76 гишүүний 15 нь эмэгтэйчүүд байхаар заасан. Энэ түвшнээс ахина. Авлигад идэгдсэн, авлигын сүлжээг бий болгосон эмэгтэй эсвэл эмэгтэй дарангуйлагч гэж сонсож байгаагүй. Нэг өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч эмэгтэй хүн болоосой гэж би хувьдаа боддог юм.

Эрх зүйн шинэтгэл нь өнөөдрийн жирийн иргэн хүний амьдралыг хөнддөг. Өдөр тутмын амьдралын бүрэлдэхүүн хэсэг гэж харвал бидний шийдэл зөв болох байх аа. Өнөөдөр Монголын эдийн засаг нэг өнгө давамгайлсан, уул уурхай, хөрөнгө мөнгө тэр дундаа нүүрсний оролцоог нь харвал хар өнгө зонхилсон байна. Нэг өнгийн эдийн засгаас солонгын долоон өнгөтэй эдийн засагт шилжих нь бидний чин хүсэл. ■

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

МОНГОЛ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТААТАЙ ТАЛБАР МӨН ҮҮ

Гаднын хөрөнгө оруулагчдын байр сууриа илэрхийлэх болсон шалтгаан нь шинээр баталсан Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуультай холбоотой юм.

Б.БАЯРТГОХ

Монголд гадаадын хөрөнгө оруулалт, тэр тусмаа гуравдагч орны хөрөнгө оруулалт орж ирэхийн тулд багагүй саад бэрхшээлтэй нүүр тулж мэдэх нь хэмээн гаднын хөрөнгө оруулагчид өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж эхэллээ. Тэд ийн байр сууриа хэлэх болсон шалтгаан нь шинээр баталсан Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуультай холбоотой юм. Тус хуулийг “эх оронч” хууль хэмээн өгөөдөх болсон ч хуулийн талаар гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлан, зохицуулах нэрээр гадуурхсан зүйл заалттай гэх чамлангүй үнэлэмжийг эдийн засагч Д.Жаргалсайхан өглөө. Харин манай улстөрчид гаргасан хуулийнхаа хэрэгжилт, чанар, үр дүн, зөв бурууг ч ялгах сөхөөгүй нийтээрээ сонгуульд “хөл алджээ”.

Уг нь Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг “ногоон гэрлээр” баталсан боловч амьдрал түүнийг тоохгүй нь бололтой. Нэг үгээр хэлбэл, Монголын хөрсөнд буухгүй, хэт нэг талыг барьсан, тэнцвэргүй хууль гэж Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал Н.Алгаа дүгнэсэн юм. Гэхдээ гадаадын хөрөнгө оруулалтыг хянаж, зохицуулах үндэсний эрх ашгийг тэргүүнд эрэмбэлсэн аж. Монгол хөрөнгө оруулалтын таатай талбар мөн үү. Хөрөнгө оруулагчдыг дайжуулахгүй байх тэнцвэртэй бодлого бий юу.

Хууль хөрөнгө оруулагчдыг үргээнэ гэв үү

Тус хуулиас хамаарч Монголын дээрээс мөнгөөр бороо орох нь татрах уу гэсэн болгоомжлол тээсэн асуулт, бухимдал, халаглал сонгуулийн сүрэнд дарагдаад үл анзаарагдана. Хөрөнгө оруулагчдын ингэж тэвдэх болсон шалтгаан нь ердөө л голлох гурван салбарт гадаадын хөрөнгө оруулалтын хязгаарлалт тогтоон зохицуулахаар болсон явдал аж. Үүнд нь, уул уурхай, банк санхүү, мэдээлэл, харилцаа холбооны салбар багтсан нь гаднын

хөрөнгө оруулагчид сэтгэл дундуур үлдэх нэг дэх шалтгаан болж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” олон улсын чуулганы халуун сэдвийн нэг нь гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах хууль эрх зүйн орчин байв. Тус чуулганд оролцсон төлөөлөгчид гаднын хөрөнгө оруулалтыг зохицуулахаар баталсан дээрх хуулийн зарим зүйл заалтыг эргэн харах шаардлагатайг сануулж байлаа. Уг нь хуулийн төслийг 2009, 2010 онд УИХ-ын нэр бүхий гишүүд санаачилж, 2011 онд өргөн барьсан ч дэмжлэг авалгүй буцсан юм билээ. Харин сонгуулийн өмнө шуурхайлан баталсан нь “Бушуу туулай борвиндоо баастай” гэдэг нэрийг зүүхэд хүргэв. Тэгвэл гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийн зорилтоос нь хуулийн мөн чанарыг сонжжээ.

“Үндэсний аюулгүй байдлыг хангахад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулагч, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд болон гуравдагч этгээдийн хөрөнгө оруулалтыг зохицуулах, тэдгээрт зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлжээ. “Өмнө нь гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж, түүнийг зохицуулах хууль эрх зүйн орчин тодорхой байсангүй. Харин Стратегийн ач холбогдол бүхий аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг баталсан нь, хөрөнгө оруулалтыг хязгаарлах, зохицуулах баримт бичигтэй болсон нь шинэ зүйл.

Бид урагшаа нэг алхлаа” хэмээн Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга Н.Энхтайван тэмдэглэсэн. Хуульд тусгагдсан стратегийн ач холбогдол бүхий салбарт тооцсон гурван салбарт гадаадын хөрөнгө оруулалт орж ирлээ гэж үзэхэд нийт хөрөнгийн 49 хувиас хэтрэхгүй. Өөрөөр хэлбэл, 51 хувиас давсан хөрөнгө оруулалт Монголын босгыг давахад ээдрээтэй болж байгаа юм. Хэтэрсэн тохиолдолд Монгол Улсын Засгийн газартай хэлэлцээрийн ширээнд сууна. ▶



► Ийн гадаадын хөрөнгө оруулалтын салбарт төр, засаг дээр өгүүлсэн гурван салбарынхан эрс шүүмжлэлтэй хандах болсон. Гаднын хөрөнгө оруулалтыг татаж түүгээр дамжуулан зах зээлээ өргөжүүлэх, үндэсний компани үйл ажиллагаагаа тэлэх эрх зүйн орчин бүрхэг болж байгааг тайлбарласан ч галт тэрэг хөдөлчихлөө. “Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах асуудлыг Засгийн газрын түвшинд авч үзэхээр болсон нь захиргааны хүнд суртал, авлигыг өөгшүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урьдын зогсонги байдалд аваачих эрсдэлтэй” гэж Н.Алгаа хэлсэн.

Нэг талаасаа, Засгийн газрын оролцоо гадаадын хөрөнгө оруулалтад нэмэгдэж, түүнд гараа дүрэхийг тус хуулиар нэгэнт хуульчилсан болохоор сөрөхөд хэцүү. Уг хуулийн төслийн хүрээнд холбогдох гурван салбараас санал хүсэлт сонссон хэмээн мэдэгдсэн ч байдал эсрэгээрээ байсныг Монголын банкуудын холбооны ерөнхийлөгч М.Болд тэмдэглэж байна. Тэрбээр “Гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хууль оновчтой болсон гэдэгт итгэл төгс биш байна. Бидэнд өнөөдөр оновчтой хууль эрх зүйн зохицуулалт л чухал байна” гэлээ. Мөн Засгийн газар шаардлагатай гэж үзвэл стратегийн ач холбогдолтой салбарт хамааруулах асуудлыг тухай бүрт нь УИХ шийдвэрлэнэ гэсэн заалт хөрөнгө оруулагчдын тэсвэрийг шалгах бололтой. Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж болох компанийн хувьцааны 1/3 буюу түүнээс дээш хувийг худалдаж авахын тулд Засгийн газартай хэлцэл байгуулж, зөвшөөрөл авна.

Ийм байдлаар асуудал цаашид үргэлжилвэл санхүүгийн зах зээл гэрлийн хурдаар хөгжинэ гэдэгт тус салбарынхан эргэлзэж сууна. Харин Гадаадын хөрөнгө оруулалтын газрынхан шинэ хууль гаднын хөрөнгө оруулалтад шууд нөлөөлөхгүй гэсэн байр суурьтай байна.

“Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хэмжээ 49 хувиас илүү гарах бөгөөд тухайн үед оруулах хөрөнгө оруулалтын хэмжээ нь 100 тэрбум төгрөгөөс давах тохиолдолд Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. Бусад тохиолдолд зөвшөөрөл олгох

асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ” гэсэн заалтын мөрөөр гаднын хөрөнгө оруулалтыг зохицуулахаар болсон. УИХ, Засгийн газар гадаадын хөрөнгө оруулалтад шууд болон шууд бусаар нөлөөлж, улстөрчдийн үүрэг оролцоо мөн л энэ хэрээр нэмэгдэнэ гэсэн үг. Цаашдаа төр, хувийн хэвшлийн салбарт цутгах хөрөнгө оруулалт, тэдний есөлт хөгжлийг ч “харцаараа шийдэх” сайн дурын эрх зүйн орчин бүрдэж байгааг гадаадынхан ил далд учирлаж байна. Гадаадын хөрөнгө оруулагчдын төлөөлөл болох “Хоган Ловэллс” компанийн захирал Майкл Олдрич “Тоглоомын дүрмээ тодорхой болгохгүйгээр богино хугацаанд хууль баталсан нь асуудал үүсгэж байна. Мөн хуульдаа судалгаа, тооцоотой хандах учиртай. Шинэ хуулиас хамаарч гадаадын хөрөнгө оруулалт саарах үзэгдэл гарч магадгүй” гэв. Харин тус хуулийн төсөлд оролцсон УИХ-ын гишүүн Р.Гончигдорж “Гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаагүй. Нэг үгээр хэлбэл, 100 хувь гадаадын хөрөнгө оруулалттай компанийн манай улсын стратегийн салбарт үйл ажиллагаа явуулах боломж нээлттэй” гэлээ.

Чамд хөрөнгө оруулалт хэрэгтэй юу

Дээрх асуултад бүгд л “Тиймээ” гэж хариулах ийм цаг үед Монгол Улс хөгжиж байна. Хөрөнгө оруулж болох бүхий л замыг нээн бизнесээ өргөжүүлэх сонирхол нийтэд бий. Зөвхөн улс оронд төдийгүй хувийн салбарт ч гаднын хөрөнгө оруулалт ус агаар мэт дутагдалтай байгааг бизнес эрхлэгчид хүлээн зөвшөөрч ирсэн. “Монголд гадаадын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Ядуурлаас ангижрах, эдийн засгаа өгөөжтэй хөгжүүлэх, ажлын байр бий болгох үйлдвэрлэлийн салбараа хөгжүүлэхийн тулд гаднаас капитал хөрөнгө татаж, түүнийгээ монголчууд өөрсдөө удирдан улс орноо хөгжүүлэх учиртай. Хуулийн зохицуулалтыг илүү нарийсгаж, төгөлдөр болгох шаардлага бий” хэмээн М.Болд тайлбарласан юм.


Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Бид улс дотроо өөрийнхөө төрийн өмчид хязгаарлалт тавьдаг атлаа гадаадын төрийн өмч орж ирэхэд хязгаарлалт тавихгүй сууж болохгүй шүү дээ. Тэгэхээр ийм зохицуулалтыг зөвхөн Монгол Улс ч биш, нээлттэй эдийн засагтай, тэр дотроо маш хүчирхэг эдийн засагтай улс орнууд хийсэн байдаг. Бид бас энэ зүйлүүдийг харж байгаад зохицуулалтаа хийсэн. Хамгийн сайн зохицуулалт, хамгийн сайн хууль гаргалаа гэж би хувьдаа хэлж чадахгүй. Эхлээд бид нээлттэй байх шаардлагатай байсан. Одоо бол Монгол Улс, ялангуяа уул уурхайн салбар гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлын төвд орсон байгаа. Миний баримталдаг бодлогод бол Монголын ард иргэдийн нийтлэг эрх ашиг хамгийн түрүүнд тавигдана. Өмнө нь бидэнд мөнгө санхүү, үнэхээр гадаадын хөрөнгө оруулалт маш чухал байсан. Энэ хоёрын алтан тэнцвэр дээр бидний цаашдын бодлого явах хэрэгтэй” хэмээн онцлов.

“Монголын дэлхий харж байгаа” хэмээн Ерөнхийлөгчийн хэлсэнчлэн гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж зохицуулах тухай хуульд буй олон асуудлыг баллуурдаж, засаж, сайжруулахгүй бол гаднын хөрөнгө оруулалт ч үгүй, хөгжил ч үгүй хоцорч мэдэхэд ойрхон байна. Гэхдээ улс үндэсний эдийн засгийн аюулгүй байдал тэргүүнд байхыг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж сануулсан. ■

ГАДААД ХУДАЛДАА

ХӨРСГҮЙ ГАЗАР ЦЭЦЭГ УРГАХГҮЙ

Эдийн засагт хэзээ ч алга болохгүй ойлголт бол ашиг ба алдагдал. Харин хэн ч хэзээ ч алдагдалд орохыг хүсэхгүй. Гэтэл манайхыг улсын дайтай явахад гол нөлөө үзүүлдэг салбарт гадаад худалдааны алдагдал гэдэг том асуудал биднийг айлгаж байна.



Э.ЗОРИГТ

Хүнийг хүн болгосон зүйл нь худалдаа наймаа байсан гэдэг. Өөрт байхгүйгээ өөр хэн нэгэнтэй солилцох замаар л анх нийгмийн харилцаа бий болсноос улбаатай овог аймаг үүссэн ч гэдэг. Овог аймгийн зохион байгуулалтаас өргөжиж улс үндэстэн болох үед ч мөн худалдаа зарим талаар дагаж, дагуулж хөгжсөөр өдгөө эдийн засгийн хамгийн том ойлголт болсон байна. Өнөөдөр Монгол Улсыг улсын дайтай авч яваа зүйлүүдийн нэг нь гадаад худалдаа. 1990 оныг хүртэл манай улс гаднын 20 гаруй оронтой 200 гаруй сая ам.долларын худалдаа хийдэг байсан бол өнөөдөр дэлхийн 130 гаруй оронтой худалдааны тал дээр харилцаж, 11.4 тэрбум ам.доллартай тэнцэх гадаад худалдаа хийдэг болжээ.

Алдагдал ба ашиг

Эдийн засагт хэзээ ч алга болохгүй ойлголт бол ашиг ба алдагдал. Харин хэн ч хэзээ ч алдагдалд орохыг хүсэхгүй. Гэтэл манайхыг улсын дайтай явахад гол нөлөө үзүүлдэг салбарт гадаад худалдааны алдагдал гэдэг том асуудал биднийг айлгаж байна. Тухайлбал, манай гадаад худалдааны алдагдал өнгөрөгч онд 2.7 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 35 хувьтай тэнцсэн. Уул уурхайг дагаад Монгол Улсын дээрээс мөнгөөр бороо орж байгаа боловч олсноосоо илүүг импорт гэх хаалгаар алдчихдаг нь бидний том дутагдал юм. Тиймээс орж ирсэн мөнгө буцаад гарчихдаг тэр хаалгыг хаах учиртай. Гэхдээ бид ширхэг зүү, сиймхий хадгаа ч дотооддоо үйлдвэрлэж чаддаггүй.

Өнөөдөр талхныхаа исгэгчийг хүртэл урд хөршөөс импортолдог шүү дээ. Уранхай цоорхойгоо оёх утсаа ч гаднаас авдаг. Хамаг учир үүнд л байгаа юм. Товчхондоо бид үйлдвэрлэгч биш хэрэглэгч орон. Тухайлбал, манай улсын гадаад худалдааны хамаарлыг авч үзвэл импортын хувьд хоёр хөрш тус бүр 30 орчим хувийг эзэлдэг тухай ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дэд захирал С.Жавхланбаатар жилийн өмнө манай сэтгүүлд өгсөн ярилцлагадаа тэмдэглэж хэлжээ. Харин барилгын материал болон ахуйн хэрэглээний барааныхаа 70-90 гаруй хувийг зөвхөн урд хөршөөсөө дангаар нь авч байх жишээтэй.

2011 оны байдлаар Монгол Улсын нийт экспортын 89 хувь нь зөвхөн ашигт малтмалаас бүрдсэн байна. Үүний 92 хувь нь Хятад хэмээх ганцхан зах зээлд гарчээ. Оюутолгой, Тавантолгой ашиглалтад орох үед энэ хэмжээ улам өсөх нь тодорхой. Гэвч дэлхийн зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний түүхий эдийн үнэ унавал яах вэ, Хятад нэг өдөр нүүрс авахгүй гэвэл яах вэ гэх болгоомжлолыг дагуулж байна. Гэлээ гээд гадаад худалдааг боомилж болохгүй. Учир нь, Монгол Улсад мөнгө олж хөгжих зайлшгүй шаардлага бий. Тиймээс бид гадаад худалдааны бизнесийн таатай орчинг улам сайжруулж, гаднаас орж ирсэн хөрөнгө мөнгөөр үйлдвэр барих хэрэгтэй гэдгийг бүгд хэлдэг. Гэхдээ энэ тал дээр чанар буюу үр дүн ярих хэрэгтэй байх. Тухайлбал, манайд үйлдвэр барих аль эсвэл ямар нэг бүтээн байгуулалтад хөрөнгө оруулах гэсэн гаднын хөрөнгө оруулагчдад ▶

► бизнесийн таатай орчинг бий болгож өгөх учиртай. Түүнээс биш, айлд ашгаа өгсөн өнөөгийн гадаад худалдааг өөгшүүлэх талаар ярьсангүй. Харин манай улсын дэлхийд танигдах бизнесийн нэр хүндийг хойш татдаг муу зүйл бол гадаад худалдаатай холбоотой асуудал гэдгийг дараах судалгаанаас харж болно. Тухайлбал, энэ онд Дэлхийн банкнаас гаргасан индексээр хил дамнасан худалдаагаар манай улс 183 орноос 159 дүгээр байрт жагсчээ.

Хөгжих шинэ арга

Оффшоринг /Томоохон компаниуд үйлдвэрлэл үйлчилгээнийхээ нэг хэсгийг бизнесийн таатай орчин татвар, ажлын хөлс багатай, газар зүйн хувьд ашигтай байрлалтай улс орон руу шилжүүлэх процесс юм./

Хятад улс энэ аргыг хэрэглэж хөгжсөн гэдэг. Нэг тэрбум хүнтэй зах зээлийг үндэстэн дамнасан томоохон компаниуд сонирхож, тэдэнтэй гадаад худалдаа хийхийг хүссэн байна. Харин үүнийг нь Хятадын төр ашиглаж гаднын хөрөнгө оруулагчдыг татах бизнесийн таатай орчинг бүрдүүлж, “Тавтай морил” гээд хаалгаа нээжээ. Хариуд нь Хятад улс өөрийн оронд тухайн орны бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх үйлдвэр бариулсан гэдэг. Тухайлбал, BMW машиныг хятадууд Германаас авах биш өөрсдөө үйлдвэрлэх явдал юм. Энэ нь Хятадын талд импорт гэх хаалгыг хаах ажлын байр бий болгох эерэг үр дагаврыг авчирсан төдийгүй өөрийн оронд үйлдвэрлэсэн BMW машиныг хөрш зэргэлдээ орнууд руу экспортолж эхэлжээ. Энэ нь нэг талаар Германы талд логистикийн хүндрэлтэй асуудлыг шийдэж, хүрэхгүй байсан зах зээлдээ Хятадаар дамжуулж, үйл ажиллагаа явуулж, ашиг олох хялбар арга юм. Хятад улс хөрөнгө оруулагчид, үйлдвэрлэгчдийг энэ аргаар өөртөө татаж эхэлмэгц урьд нь Малайз, Тайланд, Ирланд, Мексик, Бразил, Вьетнам зэрэг улс оффшорингийг яаж татах вэ гэдгээр өрсөлдөж эхэлсэн байна. Учир нь, оффшорингт зориулагдсан мөнгө болгон нутагтаа хэд дахин илүү үржиж, нүүж очсон орондоо ч импорт гэх гадаад худалдааны алдагдлын хаалгыг хаах ашиг тустай аж. Манай улс ч энэ аргыг хэрэглэж болох ажээ.

Юманд учир суманд занги

“Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” сэдэвт олон улсын хурлын үеэр Канад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Грегори Гоулдхоук “Худалдааны үр ашгийг тооцох хүндрэлтэй байдаг. Энэ хүндрэлийг алга болгохын тулд дэд бүтэц хэрэгтэй. Харин Монгол Улсад энэ дэд бүтэц алга. Дэд бүтцийг дотор нь хатуу ба зөөлөн гэж хоёр хуваадаг. Зөөлөн дэд бүтэц хөгжөөгүй бол хатуу дэд бүтэц хөгжихгүй. Учир нь, бизнесийн салбарынхан ил тод засаглал, хууль эрх зүйн тодорхой байдал зэргийг хамгийн түрүүнд харж үйл ажиллагаа явуулдаг” гэв.

Хатуу дэд бүтэц гэдэг нь бидний яриад байгаа төмөр зам, авто зам зэрэг ордог бол зөөлөн дэд бүтцэд сайн засаглал, ил тод үйл ажиллагаа, нийгмийн хариуцлага, хууль эрх зүйн орчин зэрэг нь багтдаг байна. Зарим нь

Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллараар/

| Нэр төрөл | Эхний гурван сар | | | | Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар/ |
|---|----------------------|------------|----------------------|------------|----------------------------------|
| | 2011 | | 2012 | | |
| | Хэмжээ /тн, баррель/ | Мөнгөн дүн | Хэмжээ /тн, баррель/ | Мөнгөн дүн | |
| 1 Чулуун нүүрс | 2,918,515 | 201.7 | 3,279,224 | 358.8 | 77.9% ↑ |
| 2 Зэсийн баяжмал | 138,149 | 241.7 | 140,134 | 198.6 | -17.8% ↓ |
| 3 Төмрийн хүдэр ба баяжмал | 909,895 | 75.3 | 1,478,607 | 107.7 | 43.1% ↑ |
| 4 Боловсруулаагүй нефть | 498,986 | 46.3 | 750,247 | 75.4 | 62.9% ↑ |
| 5 Цайрын хүдэр ба баяжмал | 40,049 | 48.2 | 31,453 | 30.3 | -37.2% ↓ |
| 6 Мөнгөжөөгүй алт | 832 | 32.8 | 472 | 20.8 | 36.6% ↓ |
| 7 Жонш, лейцит, нефелинт ба нефелинт сиенит | 89,479 | 17.3 | 88,747 | 19.2 | 10.6% ↑ |
| 8 Молибдений хүдэр ба баяжмал | 1,010 | 12.4 | 1,063 | 10.1 | -18.7% ↓ |
| 9 Ямааны угаасан ноолуур | 38 | 2.2 | 24 | 0.9 | -57.3 ↓ |
| 10 Ямааны самнасан ноолуур | 16 | 1.5 | 89.5 | 8.1 | 431.4% ↑ |
| Бусад | | 62.7 | | 153.8 | -14.2% ↑ |
| Нийт экспорт | | 742.1 | | 883.8 | 19.1% ↑ |

Гадаад худалдааны эргэлт /сая.ам доллараар/

| | Эхний гурван сар | | % |
|-------------------------------------|------------------|----------------|--------------|
| | 2011 | 2012 | |
| Гадаад худалдааны нийт бараа эргэлт | 1,830.0 | 2,341.7 | 28.0% |
| Валютын төлбөртэй бараа | 1,601.5 | 2,097.6 | 31.0% |
| Экспорт | 742.1 | 883.8 | 19.1% |
| Валютын төлбөртэй бараа | 729.0 | 882.6 | 21.1% |
| Импорт | 1,087.8 | 1,457.9 | 34.0% |
| Валютын төлбөртэй бараа | 872.5 | 1,215.1 | 39.3% |
| Гадаад худалдааны тэнцэл | -345.7 | -574.1 | 1.7x |
| Валютын төлбөртэй б араа | -143.5 | -332.5 | 2.3x |

Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллараар/

| Нэр төрөл | Эхний гурван сар | | Өөрчлөлт /хувиар/ |
|--|------------------|---------|-------------------|
| | 2011 | 2012 | |
| 1 Нефтийн бүтээгдэхүүн | 183.1 | 352.4 | 92.4% ↑ |
| 2 Тээврийн хэрэгсэл | 214.1 | 224.1 | 4.6% ↑ |
| 3 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл | 200.3 | 241.3 | 20.4% ↑ |
| 4 Хүнсний бүтээгдэхүүн | 35.8 | 41.9 | 17.3% ↑ |
| 6 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл | 34.5 | 46.8 | 35.6% ↑ |
| 7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо | 14.8 | 24.4 | 64.3% ↑ |
| 5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн | 2.5 | 6.5 | 159.1% ↑ |
| 8 Төрөл бүрийн даавуу | 0.3 | 0.2 | -12.0% ↓ |
| 9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн | 38.7 | 47.9 | 23.5% ↑ |
| Бусад | 363.6 | 1472.5 | 29.9% ↑ |
| Нийт импорт | 1,087.8 | 1,457.9 | 34.0% ↑ |

Эх сурвалж: ГЕГ

үүнийг бизнес хийх замын зураглал ч гэдэг. Энэ хоёр дэд бүтэц зэрэг хөгжиж гэмээнэ худалдаа хөгжих гол үндэс буюу бизнесийн таатай орчин бүрддэг аж. Харин манайд ►

► аль аль нь байхгүй. Тиймээс дээр дурдсанчлан гаднын ямар нэг хөрөнгө оруулагч манайд бүтээн байгуулалт хийх, хөрөнгө оруулахаар ороод иртэл бизнесийн замын зураг нь тодорхойгүй зөөлөн дэд бүтэц нь хөгжөөгүй бол яах вэ. Ийм асуудалтай орныг бизнесийн салбарынхан нэг нүдээрээ ч харахгүй. Ирсэн нэг нь халшраад зугтдаг гэх. Энэ үед юу болох вэ. Гаднаас орж ирж байгаа хөрөнгө оруулалтын хаалга хаагдана. Ухаж байгаа нүүрс дууслаа л бол Монголд ирсэн гаднынхан орхиод одно. Юун оффшоринг хөгжүүлэх. Тэр үед нөгөө л олсон хэдээрээ хэрэгцээгээ хангахын тулд импортоор бараа бүтээгдэхүүн авдаг сул талаа гээгээгүй бол бид хэн нэгний дагуул улс болж магадгүй гэдгийг эдийн засагчид анхааруулсаар.

Эдийн засгийн өсөлтөд юу нөлөөлсөн бэ

Хувьсан өөрчлөгдөж буй нийгэмд, зарим нэг замбараагүй байдлыг хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлага бий. Гэтэл гадаад худалдаа манай улсад хөгжөөд 91 жил, зах зээлд ороод 20 гаруй жилийг үдээд байгаа ч энэ талын зохицуулалт, хууль байхгүй нь ичмээр. ГХЯ-ны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын дарга Н.Энхтайван “Гадаад худалдаа өргөжихийн хэрээр бидэнд хууль эрх зүйн зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна. Гэвч энэ талын тусгайлсан хууль санаачилдаг, санаачилсан нэгийг нь дэмждэг улстөрч, төр засаг сүүлийн 20 гаруй жил байсангүй. Гадаад худалдаанд суурилсан эдийн засагтай орон мөртлөө энэ тал дээр санаа зовдог хүн ховор” гэсэн юм.

Өнөөдөр манай улсын эдийн засаг дэлхий нийтийг гайхшруулж, улс төрчид эдийн засгийн өндөр өсөлт гэдэг үгийг тогтмол давтдаг болсон. Гэхдээ эдийн засгийн өсөлтөд юу голлон нөлөөлсөн бэ. Зөвхөн газар ухаж, нүүрс олборлосон нь нөлөөлсөн үү. Эсвэл улстөрчдийн амлалт өндөр өсөлт гарахад хүргэв үү. Уг нь олборлосноо худалдаалж л хөгжсөн баймаар. Гэтэл үүнийг манай төрийн түшээд ойлгодоггүй эсвэл ойлгохыг ч хүсдэггүй байх. Ёстой нөгөө “Хүүг нь хаанд өргөмжилчихөөд ээжийг нь шивэгчин болгов гэдэг шиг” юм болоод байгаа юм биш үү. Хэрвээ ойлгодог байсан бол ядаж хуулиа батлах байсан байх.

Харин одоо тусгайлсан хуульгүй бол юунд хүрэх вэ. Нэгдүгээрт, замбараагүй байдал үүсдэг аж. Үүнээс улбаалаад хүнд суртал хувь хүний ашиг сонирхол давамгайлж, үндэстний ашиг хөсөр хаягдана. Тухайлбал, МҮХАҮТ-аас гаргасан “Хүнд сурталын индекс-2011” гэх судалгаанд дурдсанаар хамгийн их хүнд сурталтай газраар гааль, татварынхан шалгарсан байна. МҮХАҮТ-ын Нэгдсэн бодлого, төлөвлөлт зохицуулалтын газрын дарга Ч.Нэргүй “Өнөөдөр манай гадаад худалдаа явуулдаг ганц том хилийн боомт бол Замын-Үүд. Гэтэл тус газар нь хамгийн их хүнд сурталтай байхад гадаад худалдаа яаж хөгжих вэ” гэлээ. Өөр бусад судалгаанаас ч манай бизнес, худалдааны орчин улам л муудсаар байгаа нь тодорхой харагдана. Тухайлбал, Монгол Улсаас тодорхой хэмжээний барааг экспортолж, импортлоход 2006 оны байдлаар 30 орчим хоног зарцуулагддаг байжээ. Гэтэл

өнгөрөгч онд дээрх хоног нэмэгдэж 47 болж уртассан байх жишээтэй. Цаг хугацаатай уралдаж мөнгө олдог бизнесийн салбарт энэ мэт хоног өдөр алдах нь байж боломгүй хэрэг. Монголын гадаад худалдааны үйл явцыг дэлхийн бусад оронтой харьцуулж үзэхэд Гүрж улс гадаад худалдаанд дөрвөн төрлийн бичиг баримт шаарддаг бөгөөд уг баримтыг бүрдүүлэхэд дөрөв хоног хангалттай гэнэ. Мөн Франц, Япон, БНСУ, Швед зэрэг улс гурван төрлийн бичиг баримтыг 2-4 хоногийн дотор л бүрдүүлдэг аж. Энэ мэтээр дэлхийн өндөр хөгжилтэй оронд гадаад худалдаа явуулахад 2-4 төрлийн бичиг баримт шаардаж, бүрдүүлэх хугацаа нь 1-4 хоногт хэлбэлзэж байна. Энэ нь зөөлөн дэд бүтэц буюу хууль эрх зүйн орчин тодорхой байгаагийн тод жишээ. Өөр баримт ч дурдаж болох юм. Дэлхийн банкны 2011-2012 оны судалгаагаар Монгол Улс бизнес эрхлэх дэд индексээр 183 орноос 97 дугаар байрт оржээ. Уг үзүүлэлтийг гаргахад тухайн нэг компани үйл ажиллагаа явуулж эхлэхээс өмнөх төрийн байгууллагын шат дамжлагыг түлхүү тооцсон байна. Тухайлбал, шинээр бизнес эхэлж байгаа хүмүүс долоон шат дамжлага дамжин 13 хоног зарцуулж, нэг хүнд ногдох орлогын 2.9 хувьтай тэнцэх хэмжээний зардал гаргадаг аж.

Гадаад худалдаа гэх улс орны тэр байтугай үндэстэн дамнанас дэлхийн хэмжээний асуудалд ГХЯ-ны 10 гаруйхан мэргэжилтэн санаа зовж суудаг байна. Н.Энхтайван “Манай яаманд 10 хүнтэй баг байдаг. Ийм хүн хүчний дутагдалтай болохоор яаж гадаад эдийн засгийн бодлого боловсруулах юм бэ. Дараагийн Засгийн газар энэ тал дээр анхаарч бүхэл бүтэн институтын хэмжээнд авч үзэж, дэмжих хэрэгтэй байна” хэмээн ярьсан. Гэхдээ цөөн хүнтэй чадуу хүчтэй гадаад худалдаа хариуцсан энэ баг Гадаад худалдааны тухай хууль, Гадаад худалдаанд төрөөс баримтлах бодлого, Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр зэргийг боловсруулаад Засгийн газар, УИХ-ын Байнгын хороонд өргөн барьсан аж. Гадаад худалдааны хууль батлагдвал хамгийн түрүүнд тодорхой байдал үүснэ. Бичиг цаастай холбоотой хүнд суртлын асуудал ч нэлээд цэгцлэгдэнэ гэдэгт Энхтайван дарга итгэлтэй байв. Мөн тэрбээр “Хууль бол хөрс юм. Хөрсийг нь сайн тавиад өгвөл цэцэг сайхан ургана шүү дээ” гэлээ.

Дээрх хууль, дүрэм журам батлагдвал гадаад худалдааны хөгжлийг хойш татсан хүнд суртал бага ч гэсэн арилж, зөөлөн дэд бүтцийн энхэл донхол багасч ногоон гэрэл цагаан шугамтай болох аж. Эх нь булингартай бол адаг нь булингартай гэх үг байдаг шүү дээ. Тиймээс эхлэлийг нь зөв тавих нь чухал юм. Гэхдээ төгс төгөлдөр гэж хорвоо дээр байхгүй. Хайр сэтгэл, бурхан шашин гээд бүгд сайн муугийн хослол. Энэ нь магадгүй амьдрал утгатай болох, бид өдөр тутам хийх ажилтай байх хорвоогийн хөдөлшгүй философи, жам ёс байх. Тэр ч утгаараа бидэнд аливаа зүйлийг тодорхой хугацаанд зайлшгүй засаж, залруулах хэрэг гарна. Тиймээс төгс хууль, төгс эдийн засаг гэж байх боломжгүй. Гэхдээ бидэнд бусдын манлайд явах, төгс төгөлдөр гэх нэр томъёонд ойртох зайлшгүй шаардлага бол бий. Энэ шаардлагад хүрэхийн тулд нийгмийн баялгаа нэмэгдүүлж, бага зардлаар ихийг бүтээж, өндөр үнээр худалдаж, ашиг олох эдийн засгийн ухаанд суралцах хэрэгтэй аж. ■

ЯРИЛЦЛАГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ХӨЛ ТАВИХААР ЗЭХЭЖ БАЙСАН УЛААН ХИВСИЙГ СУГА ТАТАХ ШИГ БОЛЛОО



Эдийн засгийн утгаараа Хятад улс Монголыг өөртөө уусгах оролдлого хийж байгаа гэдэгтэй санал нийлнэ.

шийдвэрлэх арга замыг олоход туслах үүднээс хэрхэн хөндлөнгийн шүүхтэй зохицож хуулиа өөрчилж болох вэ гэх мэт илүү бизнесийн үйл ажиллагаанд чиглэсэн чуулган болсон гэж хэлж болох юм.

Чуулганы зүгээс бизнесийнхэнд анхаарлаа илүү хандуулж байгаа нь илт байсан. Шүүх засаглал, шударга ёс, хууль эрх зүйн өндөр дээд асуудал гэхээсээ илүү прагматик тал руу нь харж байна. Эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд бизнесийн салбарыг хэрхэн хуулиар дэмжих вэ гэдэг дээр илүүтэй төвлөрч байгаа юм.

-Монголын эрх зүйн орчны өнөөгийн байдлын талаар Та ямар бодолтой байна вэ?

-Би Монголын эрх зүйн орчныг бараан өнгөөр хардаг хүмүүстэй санал нэгддэггүй. Хууль руу үнэнчээр өнгийвөл гэрээ хэлцлийн түвшинд илүү нээлттэй эрх чөлөөг олгосон эрх зүйн орчинг харж болно. Үндсэндээ, хууль эрх зүйн орчны суурь нь Хятад, Вьетнам болон Индонези улсыг бодвол илүү барууны хэв маягтай ойрхон.

Үүний зэрэгцээ хүмүүсийн дунд бид хуулийг чандлан мөрдөөд л эхэлчихвэл бүх асуудал шийдэгдэнэ гэсэн хандлага байна. Миний бодлоор энэ нь зарим талаар монголчуудын уламжлалт сэтгэлгээнээс үүдэлтэй юм болов уу. Монгол хүмүүс тогтсон заншлын шинжтэй зарчмуудыг хадгалж ирсэн онцлогтой. Хэрвээ Та нэг шинэ зарчмыг хэвшүүлж чадвал хүмүүс түүнийг дагах жишээтэй. Тухайлбал, цахилгаан, дулааны станц байгуулах ажлыг аваад ▶

-Энэ удаагийн эрх зүйн шинэтгэлийн чуулганы талаарх сэтгэгдлээс хуваалцана уу?

-Өнгөрсөн жилийн чуулган энэ удаагийнхыг бодвол илүү олон сэдвийн хүрээнд ярилцаж, оролцогчдын хувьд ч илүү олон хүнийг хамарсан. Гэсэн ч энэ удаагийн чуулганы гол ялгаа нь төвлөрч буй сэдэв нь байлаа. Нэг талаас бид Монгол Улсад олон улсын жишигт нийцсэн бизнесийн тогтвортой үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд тохиолддог хүндрэлүүд ба бизнесийн аливаа үйл ажиллагааг нэвтрүүлэхэд хэрхэн тус дөхөм үзүүлж болох вэ гэх мэт асуудлаар ярилцлаа. Банкны салбарыг хэрхэн илүү үр ашигтай болгох вэ, олон төрлийн маргааныг богино хугацаанд

Б.ЦЭЦЭЭ

“Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” сэдэвт хуралдааныг Ерөнхийлөгчийн Тамгын газартай хамтран зохион байгуулагч олон улсын хуулийн фирм болох “Хоган Ловэллс”-ийн Монгол дахь салбарын захирал Майкл Олдричтэй дээрх хуралдааны үеэр Монголын эрх зүйн орчны талаар ярилцлаа.

► үзвэл нэлээд цогц шинжтэй байгаа юм. Бид яах вэ гэхээр тухайн санаа сэдлүүдийг дэмжиж, ойлголтуудыг эмхлэн цэгцэлж ажил хэрэг болгох явдал юм.

Нэг ёсондоо танд хэчнээн аугаа эрх зүйн үзэл баримтлал байвч хуулийг ойлгохгүй мөн түүнийгээ хүн бүхэн ухан ойлгох хэмжээнд хуультай авцалдуулж чадахгүй бол тэнд ямар нэг шинэлэг дэвшилттэй тал алга гэж хэлж болно.

-Тэгвэл иргэдээ хуулиа мөрддөг болгохын тулд хуулийн хэрэгжилт ямар байх ёстой вэ ?

-Парламентийг зөвхөн хууль гэхээсээ илүү түүнийг хэрэгжүүлэхэд хэрэглэгддэг гэрээ хэлцлүүдийг бодож тооцон шийдвэр гаргахад нь зөвлөх нь чухал юм. Тухайлбал, хоёр жилийн өмнөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Концессийн тухай хууль байна. Хууль батлахын өмнө бид энэ хуулийг хэрхэн боловсруулж яаж хийх вэ гэдэг асуудал дээр төвлөрч ажиллаж байсан бол нэгэнт хуулиа өлгийдөөд авангуут хэн ч түүнийг хэрхэн ашиглахаа мэдэхгүй байв. За яахав Парламентийн түвшинд хуулиа яриад сууж болно. Гэхдээ яагаад Монголын хуульд төдийгүй олон улсын стандартад нийцсэн Монгол болон гадаадынхны аль алинд хэрэглэхэд хялбар ойлгомжтой Концессийн хуулийг боловсруулах тал дээр анхаарч ажиллах тодорхой хүмүүсийг томилж болоогүй вэ гэдэг юм. Ихэнх тохиолдолд энэ асуудал орхигддог. Гэрээг бичиж боловсруулна гэдэг мэдээж хэрэг уйтгартай төвөгтэй ажил. Гэхдээ тухайн хуулийн жинхэнэ ухагдахууныг амьдрал дээр хэрэгжүүлж улс орны эдийн засийг хөгжүүлэх чадавхтай байхын тулд өнөөх уйтгартай хэсэгт л хэрэглээний мөн чанар буюу зүрх нь оршиж байгаа юм.

-Монгол шиг хөгжиж буй жижиг орнуудад хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангадаг вэ?

-Энэ улсын системийг би хувьдаа аугаа хүч бололцоо ба цаг үеийн сул дорой байдлын хосолмол тусгал гэж боддог. Монгол нь ардчиллын зам руу эргэлт буцалтгүй орсон улс. Тиймдээ ч Парламент олны анхаарал татсан цаг үеийн асуудалд тэр дор нь хариу үйлдэл үзүүлэх гээд байдаг

талтай. Нэг талаар энэ нь зөв зүйл. Учир нь тэр бол ардчиллын онцлог шинжүүдийн нэг нь яах аргагүй мөн. Гэвч зарим үед энэ нь Парламентийг тухайн үйл явдалд хурдан хугацаанд хариу үзүүлж, ар дахь үр дагавруудыг сайтар бодолцож үзэлгүйгээр хууль гаргахад түлхэж байна. Бусад оронд ихэнх тохиолдолд тодорхой Ажлын хэсэг ажиллуулдгаараа онцлог. Харин Ажлын хэсгийн нэг асуудал нь хүн бүр тухайн асуудалд хариуцлага үүрэх ба тодорхой хэн нэгэн хариуцлага хүлээдэггүй явдал юм. Өөрөөр хэлбэл, та өөрийн эх оронч хүсэл зоригоор хуулийг боловсруулах юм. Ингэхээр хуулийн эцэслэсэн хувилбарт хэн нэгэн эсвэл хэдэн хүн хариуцлага үүрдэггүй гэсэн үг.

Бидний хувьд цахилгаан станц эсвэл хууль боловсруулах аль ч хуулийн төслийн үйл ажиллагааг доош нь татдаг Ажлын хэсгийн үндсэн зарчмаас татгалзмаар байгаа юм. Үүнийг зүйрлэж хэлбэл олон хүний гар оролцсон хоолны амт сайхан болдоггүйтэй л адил. Товчхондоо хууль боловсруулах, тогтоох үйл явцыг илүү сайжруулах нарийвчлах хэрэгтэй байгаа юм. Энэ нь илүү тодорхой тогтсон нэг хэлбэртэй болно гэсэн үг.

Хуульч гэрээ бичихдээ хуулийн дагуу хүсэлт гаргагч талуудын хүсэл сонирхлыг ижил түвшинд хангах гол асуудлуудыг тусгаж өгөөгүй нөхцөлд маргаан гарвал гэрээ үүргээ гүйцэтгэхээ больдог. Ингээд Та ч үүнийгээ гэрээ гэж хэлж чадахгүйд хүрнэ. Хууль боловсруулах ч үүнтэй адил үйл явцыг шаарддаг. Тогтсон тодорхой нэг зарчмын дагуу тусгайлсан нарийн тайлбар бүхий ойлгомжтой хууль боловсруулахыг хичээнэ. Парламент эргээд хамгаалах арга хэрэгслээ гэж үзэж байгаа уг хуулиа эдийн засаг нийгмийн тухайн асуудлыг нарийн зохицуулж өгсөн эсэхэд сайтар хянаж шалгах ёстой юм.

Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хууль бол маш өргөн хүрээтэй бичиг баримт. Гэвч энэ удаад Парламент дээрх өргөн хүрээтэй асуудлыг зөвхөн нэг үйл явдал дээр тогтож, онцлох хэрэгтэй байсан эсэхэд эргэлзэж байна. Тиймээс ч өнөөдөр ойлгомжгүй байдал үүсчихээд байна.

Бусад оронд Та илүү нарийн аргаар хууль боловсруулдаг болохыг

харж болно. Ихэнхдээ тийм олон хүн нэг дор суугаад хууль боловсруулаад байгааг олохгүй. Харин нэгээс хоёр хүн тодорхой нэг хууль эрх зүйн асуудлыг шийдвэрлэхийн тулд хууль боловсруулах үүргийг биелүүлдэг. Энэ нөхцөлд хувь хүн, олон нийт, бизнесийн салбар зарим үед эрдэмтэд гэх мэт нийгмийн хэсэг бүлгүүдийн дунд тухайн хуулийг хэлэлцүүлэх үйл явц өрнөдөг.

Арилжааны зорилго бүхий хууль нь бизнесэрхлэгчдийн шийдвэргаргалтад бүх анхаарлаа төвлөрүүлсэн байдаг. Учир нь, бизнесмэнүүд тодорхой нэг ажлын төлөвлөгөөгөө хуультай тулгаж хараад “хэрхэн яаж үйл ажиллагаагаа явуулах вэ” гэдэг асуултад хариулахыг хичээдэг. Хэрэв хуулиа сайтар ухан ойлгож чадвал тухайн бизнесийн үйл ажиллагаагаа цааш нь аваад явах уу, үгүй юу гэдэг шийдвэрээ гаргадаг. Энэ нь хуулийн үндсэн зорилго шүү дээ. Зохих ёсны дагуу сайн боловсруулсан хуулийн хийх ажил энэ л байдаг. Тухайн хуулийн зорилго алдагдах тохиолдолд энд ч тэр, бусад оронд ч гарах тохиолдол бий.

-Та Монголын хууль тогтоогчид өөрсдийн хүсэл сонирхолд нийцсэн хууль гаргаж, хувийн бизнесээ нүднээс далдуур эрхэлдэг талаар юу гэж бодож байна вэ?

-Ашиг сонирхлын тухай хууль батлагдсаныг санаж байна. Би хувьдаа энэ хуулийг нарийн нямбай боловсруулсан чанга хууль гэж үзэхгүй. Энгийнээр хэлэхэд хүмүүст олон нийтийн төлөөг гэхээсээ илүү өөрийн гэр бүл, хувийн ашиг сонирхол, амжилтын төлөө хуулийг харж, боловсруулдаг хандлага буй нь харамсалтай байна. Энэ бол нийгмээрээ хатуу эсрэг байр сууринаас хандаж, яагаад ч хүлээн зөвшөөрч болохгүй асуудал. Улс-төрч болохоор зорьсон хэн ч бай энэ төрлийн ёс суртахуунгүй зан авираас өөрийгөө бүрэн чөлөөлсөн байх ёстой. Үүний тулд нэн түрүүнд хүмүүсийн нийтлэг сэтгэлгээнд өөрчлөлт хэрэгтэй бол нөгөө талаар илүү чанга хууль журам шаардлагатай. Өнөөгийн Ашиг сонирхлын зөрчилдөөний тухай хуульд зөвхөн хувь хүний тухай заасан байдаг. Хэрэв Та хэн нэгэн эсвэл аливаа нэг гэр бүлийн гишүүдийг авч хэлэлцээгүй харин ч хөхүүлэн дэмжсэн хууль баталсан байвал яах вэ. Энэ бол ►►

► угаасаа хуулинд хамаарахгүй асуудал болчихсон байгаа. Тэгээд үүнийг хүмүүс ашигладаг.

-Энэ удаагийн хөрөнгө оруулалтын тухай хуулийг Та хэрхэн хүлээж авч байна вэ?

-Монголын Парламентад байдаг нэг хэцүү зүйл нь асуудлыг тосон хариу үзүүлдэг байдал. Өнөөх дээр үед батлагдсан байгаль орчны хууль байна. Үнэхээр өргөн цар хүрээтэй хууль. Хөрөнгө оруулалтын тухай хууль дээр ч адилхан нөхцөл байдал ажиглагдлаа. “Чалкод” барьсан хариу үүний жишээ. Амдаж хариулна гэдэг яагаад ч хуулийн хэрэгжилтийг хангах сайхан арга биш. Үүнээс илүүтэй сайтар бодож тоцоолсон, цаг хугацааны хувьд амь бөхтэй хууль гаргахыг зорих нь дээр юм. Олон хүмүүс Хөрөнгө оруулалтын тухай хуулийг саяхнаас бус хоёр, гурван жилийн өмнөөс ярьж хэлэлцэж ирсэн гэж хэлж байна. Гэхдээ бид бүгдээрээ л чухам юу ингэж өдөөн хатгах болсныг мэдэж л байгаа шүү дээ. “Чалкод” барьсан хариу үйлдэл байсан. Эдийн засгийн утгаараа Хятад улс Монголыг өөртөө уусгах оролдлого хийж байгаа гэдэгтэй санал нийлнэ. Би Хятад улсад 18 жил амьдарсан учир дээрх бодит хандлагыг ойлгож байна. Гэвч тэр тусмаа ач холбогдол өндөртэй хуулийг зүгээр нэг гэнэт гарч ирсэн асуудлын хүрээнд бус илүү өргөн цар хүрээтэй бодлогоор шийддэг зарчимтай байж хэрэгжилтийн талыг нь нарийн тооцоолдог байх нь дээр юм.

Тус хууль нь нэг талаар ихээхэн эргэлзээтэй мессежийг хөрөнгө оруулагчдад өгч байна л даа. “Манайд хөрөнгө оруулаач ээ гэхчээд нөгөө талд тодорхой бус хөрөнгө оруулалтын хуулиа дагаж мөрд үгүй бол хэцүүхэн шийтгэл амсана шүү” гэж байгаа юм. Санаа нь зөв боловч хөрөнгө оруулалтын орчин нь өөрөө тус хуулийг засаж залруулж, дутуу хөтүү ойлгомжгүй байдлыг нь цэвэрлэхийг шаардаж байна. Хэрэв хуулийн гол зорилго нь Хятадын хөрөнгө оруулалтаас сэргийлэх юм бол хуулийг өнгөн талдаа дундыг баримталсан авч Хятадын хөрөнгө оруулалтын эрчийг сулруулах хандлагатай болгох өөр бусад аргыг хэрэглэх бүрэн бололцоотой. Жишээлбэл, Монгол дахь хөрөнгө оруулалтын төслүүдэд

Хятадын засгийн газраас зөвшөөрсөн батламжийг шаарддаг байж болох юм. Учир нь, Хятадын хуульд тийм зүйл заалт байхгүй. Хүмүүс энд өөрийн орноос зөвшөөрөл авалгүйгээр төсөл төлөвлөгөөгөө хэрэгжүүлээд явчихаж байна. Хэрэв дээрх төрлийн зөвшөөрөл шаардвал гадаадын хөрөнгө оруулалтын урсгал татарна.

-Хэдийгээр манай улс уул уурхайн томоохон бүс нутгуудын нэг болоод байгаа ч одоогоор жижиг хөрөнгө оруулагчтай тоглосоор л байна уу эсвэл томоохон хөрөнгө оруулагчид Монгол руу орж

Олон хүмүүс Хөрөнгө оруулалтын тухай хуулийг саяхнаас бус хоёр, гурван жилийн өмнөөс ярьж хэлэлцэж ирсэн гэж хэлж байна. Гэхдээ бид бүгдээрээ л чухам юу ингэж өдөөн хатгах болсныг мэдэж л байгаа шүү дээ. “Чалкод” барьсан хариу үйлдэл байсан. Эдийн засгийн утгаараа Хятад улс Монголыг өөртөө уусгах оролдлого хийж байгаа гэдэгтэй санал нийлнэ. Би Хятад улсад 18 жил амьдарсан учир дээрх бодит хандлагыг ойлгож байна.

ирэх эсэхдээ эргэлзээд биднийг харзнаад, хүлээгээд байна уу ?

-Өнгөрсөн хугацаанд жижиг хөрөнгө оруулагчид л энэ зүгт татагдаж ирсэн. Саяхнаас бид томоохон хөрөнгө оруулагчдыг орж ирж байгааг харж байна. “Рио Тинто”, “Айванхоу” гэх мэт тод жишээг нэрлэж болох юм. Харин бусад хөрөнгө оруулагчдын хувьд Монголын зах зээлийг хараа салгахгүй харж байгаа. Зөвхөн уул уурхайн компаниуд гэлтгүй тус салбарыг дэмжиж ажилладаг бусад компани тухайлбал цахилгаан, дулааны станц

барилга, зам тээврийн гэх мэт. Миний үйлчлүүлэгчдийн жагсаалтад томоохон хэмжээний гэж хэлж болох 20-иод компани байна. Гэвч саяхан батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хууль хөрөнгө оруулагчдын хөл тавихаар зэхэж байсан улаан хивсийг суга татах шиг л боллоо. Тус хуульд тодорхойгүй ойлгомжгүй зүйл их байна. Ямар ч хөрөнгө оруулагч тодорхой бус байдалд дургүй.

-Та өнөөгийн Авлигын хуулийг юу гэж боддог вэ

-Миний хувьд Авлигын эсрэг хууль ихээхэн хангалтгүй санагддаг. Хууль нь өөрөө чанга байлаа ч гэсэн хэрэгжих тал дээр асуудалтай. Хэрэгжилт ярихаас өмнө авлигыг нийгэм дэх согог гэж хүлээж авах сэтгэлгээний асуудлыг нэн тэргүүнд тавих нь чухал юм. Хууль боловсруулж, хэрэгжүүлэх гол механизмыг бүтээхийн тулд нийгэм дэх хандлага нь өөрөө авлига авсан хүмүүсийг ичээдэг жигшдэг байх хэрэгтэй.

Зарим талаар энэ бол ёс зүй, шударга байдлыг нийгэмд бий болгох асуудалтай илүү холбогддог. Үүний тулд сургалтын системтэй нягт холбож өгч хүмүүсийг боловсрол соёл хүмүүжлээс нь эхлэн төлөвшүүлэх ёстой. Засаглалын зүгээс авлигалын эсрэг хуулийг хэрэгжүүлэх хүсэл зоригийг биелүүлэхийн тулд нийгэмд авлигалыг жигших ухамсар, ёс зүйг бий болгох хэрэгтэй юм.

-Хуульч хүний хувьд нэн түрүүнд ямар хуульд өөрчлөлт оруулмаар санагддаг вэ ?

-Үйлчлүүлэгчдийн минь эрх ашигт нөлөөлсөн олон нарийн зүйл заалтууд бий л дээ. Гэхдээ Компаний тухай хуульд хэд хэдэн тодорхойгүй хоёрдмол утгатай зүйлийг засаж янзалмаар санагддаг. Мөн тодорхой хэдэн хэрэгжилтийн тал нь дутмаг захиргааны журмууд байна. Тухайлбал, бүртгэлтэй холбогдсон хөндлөнгийн хуулийн заалтууд бий. Төрийн албууд дээрх хуулийн заалтуудыг төдийлэн сайн хэрэгжүүлж эхлээгүй байна. Хэрэгжүүлж эхэлснээр Монголын компаниудад зээл олгох зээлдэгчийн хувьд ихээхэн амар хялбар олж ирэх талтай л даа. Бизнесийн үйл ажиллагаатай л холбоотой зүйлс л нэн тэргүүнд миний санаанд орж ирж байна даа. ■

БАНК

ТӨВБАНКНЫ ЗАСАГЛАЛ

Цаг үеийн нэмэлт, өөрчлөлтийг эс тооцвол Төвбанк хууль эрх зүйн хувьд шинэчлэгдэх цаг болсныг “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” чуулганы оролцогчид хэлж байв.

Б.ТОГТОХ

Монгол Улс ганцхан ашгийн төлөө бус банктай. Тэр нь Монголбанк. Бие даасан бодлоготой, өөрийн гэсэн хууль эрх зүйн орчинтой “Вант улс”. Ямар нэгэн улс төрийн хүчний атганд багтах жижиг гар ч биш ээ, уг нь бусад орны Төвбанкны жишгээр бол шүү дээ. Харин Монголбанкны засаглал, хууль эрх зүйн орчин хааяа ганхах үе байна. Тэр нь улсын төсвийг хэлэлцэн батлах үеэр буюу оны төгсгөлд. Ийм үед Монголбанк төвбанкны үүргээ гүйцэтгэж чадсангүй гэж шүүмжлүүлэх нь бий. Гэтэл Төвбанкны хараат бус бие даасан байдал засаглалын түвшиндээ хангалтгүй байгаа талаар “Голомт” банкны гүйцэтгэх захирал Жон Финиган “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” олон улсын чуулганы үеэр хэлж байсан. Товчхондоо, Монголбанк хагас засаглал буюу Засгийн газрын бодлогоос шууд хамааралтай байна гэж мэдэгдсэн юм.

Мөн эдийн засгийн хөгжлийн тухай хэлэлцэж буй урт хугацааны стратегиуд улс төржилт ерөөсөө байж болохгүй хэмээн МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш доктор, профессор Л.Оюун хэлсэн удаатай. Төвбанкны удирдлага буюу ерөнхийлөгч, тэргүүн дэд, дэд ерөнхийлөгч нь Засгийн газар, шинэ УИХ-тай хамт ирж, буцдаг. Монголбанкны ерөнхийлөгчийг зургаан жилийн хугацаатай томилдог. Харин улс төрийн сонгууль дөрвөн жилд нэг удаа болдог. Гэтэл зургаан жилээ гүйцээсэн Төвбанкны тэргүүн манайд ховорхон байгаа нь Монголбанкны бие даасан засаглал удирдлагын түвшин уруудаж байгааг гэрчлэх буй за.

Манай улсын санхүүгийн зах зээл гаднаасаа маш энгийн бүтэцтэй харагдах хэдий ч тэнцвэргүй болохыг эдийн засагчид хэлдэг. Энэ нь зах зээлийн 95 хувийг арилжааны банкны систем дангаар эзэлж, үлдсэн таван хувийг хөрөнгийн зах зээл бүрдүүлж байгаатай холбоотой хэмээн тайлбарладаг. Ном ёсоороо бол санхүүгийн зах зээлд банк 50, хөрөнгийн зах зээл мөн адил хувийг эзлэх ёстой ч манайд эрүүл бус тэнцвэргүй тогтолцоо “хөгжиж” байгааг Компанийн засаглалын хөгжлийн төвийн захирал Ж.Үнэнбат онцлон тэмдэглэсэн билээ.

Хорин нэгэн жилийн өмнө Монголын банк санхүүгийн салбарт хоёр шатлалт банкны систем бүрэлдэн тогтож, санхүүгийн зах зээлийн гараа 100 хувь банкны системээр эхэлж байсан. Харин энэ хугацаанд арилжааны банкны



салбар цэцэглэн хөгжсөн ч Төвбанкны засаглал, хууль эрх зүйн орчинд дорвитой өөрчлөлт гараагүй болохыг Улсын дээд шүүхийн шүүгч А.Доржготов өгүүлсэн юм. Монголын банкны хууль тогтоомжийг аваад үзэхэд, 1991 оноос үүдэлтэй хоёр шатлал банкны тогтолцоо өнөөдрийн суурь хөрс нь гэж үзэж болох талтай. Учир нь, 1990-1996 оныг банкны салбарын анхан шатны хөгжлийн үе гэж онцолдог юм байна. Энэ үеэс л арилжааны банкууд бий болж, үйл ажиллагааны хүндрэлтэй учирч, зарим нь хаалгаа барих хүртэл асуудалтай тулгарч байсан нь тэртээд хоцорчээ.

Дараагийн үе нь 1996 оны шинэ УИХ-ын анхны чуулганаас эхтэй. Энэ үед банкны салбарт салхи эргэж, хоёр төрлийн хууль эрх зүйн шинэчлэл өрнүүлсэн нь Төвбанк, арилжааны банкны үйл ажиллагаа, эрх зүйн орчинг хуулийн хүрээнд ялгаж заагласан явдал юм. Төвбанкны тухай хуульд 1996 оноос хойш өнөөг хүртэл бараг л салхи ороогүй хэлж болохоор. Харин 2010 оны Банкны тухай хууль арилжааны банкинд хандсан зохион байгуулалтын нэлээд өөрчлөлтийг хийсэн аж. Монголбанкны хувьд 1996 оны УИХ-ын чуулганаар хэлэлцэн баталсан хууль эрх зүйн орчинтойгоо өнөөг хүртэл явж байна. Цаг үеийн нэмэлт, өөрчлөлтийг эс тооцвол Төвбанк хууль эрх зүйн хувьд шинэчлэгдэх цаг болсныг “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” чуулганы оролцогчид хэлж байв. Төвбанкны хувьд зээлийн мэдээллийн тухай хуулийг батлахад ихэд анхаарал хандуулжээ. Цаашид банкны салбарт буй дэд бүтцийн чанартай хууль тогтоомжийг сайжруулахаас гадна 2010 оны Банкны тухай хуулийг баталснаас хойших дотоод дүрэм журмаа шинэ хуультай нийцүүлэн шинэчилж байгаа хэмээн Монголбанк өөрийн байр сууриа илэрхийллээ. Мөнгөн тэмдэгт гүйлгээнд гаргадаг, мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлдэг, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулдаг, төрөөс үүсгэн байгуулсан хуулийн этгээд бол Төвбанк. Шаардлагатай тохиолдолд арилжааны банкууд болон Засгийн газарт зээл олгодог эдийн засгийн ганцхан хөшүүрэг бий. Энэ нь Монголбанк буюу Төвбанк билээ. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

-Банкны салбарт ямар хууль эрх зүйн зохицуулалт шаардлагатай байна вэ?



М.БОЛД

/Монголын банкуудын холбооны тэргүүн/

-Банкуудын эдийн засгийн өсөлтийг бий болгох, өсөлтийг хурдасгах ганцхан үүрэгтэй байгууллага. Иргэдэд харагдах өнцөг нь хадгаламж аваад, хүмүүст зээл өгч байгаа боловч банкны байгууллагын үйл ажиллагааны агуулга, цар хүрээ өргөн. Эдийн засгийн өсөлтийн хурдыг нэмэх, үйл ажиллагааг сайжуулах, үр өгөөжөө дээшлүүлэхэд дутагдаж байгаа зүйлийн нэг нь хууль эрх зүйн сайн орчин үгүйлэгдэж байна. Одоогоор банкны салбарын хууль тогтоомж ерөнхийдөө хангалттай гэх боловч засаж сайжруулах олон зүйл бий. Тухайлбал, банкны

үйлчилгээг зөвхөн банк үзүүлэхгүй. Тухайн банкны үйл ажиллагааг тойрсон дагуул хуулиуд олон байдаг. Үүний нэг нь, Зээлийн батлан даалтын сангийн тухай хууль саяхан гарсан ч зээлийн баталгааны үйлчилгээ хангалтгүй байгаа. Хоёрдугаарт, үл хөдлөх хөрөнгийг барьцаалах хууль эрх зүйн орчин алга. Хөдлөх хөрөнгөд хүний унах машин, хөдөлдөг тоног төхөөрөмж, бусдаас авах дансны авлага хүртэл ордог. Мөн үнэт цаас, гэрээ хэлцэл ч орно. Хөгжилтэй улс оронд бол энэ бүхнийг барьцаалдаг бүхэл бүтэн систем байдаг. Тогтолцоогоо зөв бүрдүүлбэл олон хүн зээл авах боломжтой. Энэ нуугдмал бололцоогоо бид ашиглах шаардлагатай. Нуугдмал хөрөнгөө ил болгоё.



С.ОРГОДОЛ

/Худалдаа хөгжлийн банкны гүйцэтгэх захирлын орлогч/

-Санхүүгийн салбарын 90 гаруй хувийг банкны салбарынхан үүрч явна. Банкны салбарын нийт зээлийн өрийн үлдэгдэл 5.7 тэрбум төгрөг байна. Үндсэндээ банкны салбарын 5.7 тэрбум төгрөгөөр л ахуйн хэрэглээ, эдийн засгийн хэрэгцээг хангаад явж байна. Гэтэл энэ хэмжээний төгрөг 2010 он гэхэд 2.7 их наяд төгрөгийн өсөлттэй байсан. Банкны салбарын өсөлт жилдээ 50-60 хувь байна. Зээлийн өрийн үлдэгдлийг дотор нь аваад үзэхэд хувь хүмүүсийн зээлийн өрийн үлдэгдэл 55-60 хувийг эзлээд, үлдсэн хувийг нь аж ахуйн нэгжийн зээл эзэлж байна. Аж ахуйн нэгжийн зээлийн өрийг аваад үзэх юм бол том

аж ахуйн нэгжийн зээл нэлээд жин дарж, жижиг, дунд зээлийн үлдэгдэл бага хувийг нь эзэлж байна. Нэг үгээр хэлбэл, том компаниуд жижиг компанийнхаа орон зайг хязгаарлаж байна. Ийм учраас олон салбараас эдийн засгийн өсөлт нь хамаарсан тогтвортой хөгжилтэй байх нь чухал. Банкны салбар бол тогтвортой хөгжлийн төлөө ажилладаг, хүлээсэн үүргээ ч тодорхой хэмжээнд биелүүлж яваа. Гэхдээ асуудал олон байна. 2010 оны Банкны тухай хуулийн шинэчлэл банкны бүтэц зохион байгуулалттай холбоотой асуудлыг зохицуулж өгсөн. Банкны засаглал, бүтэц зохион байгуулалт, ТУЗ -ийн хараат бус гишүүн гээд олон асуудлыг шийдсэн. Ерөнхийдөө зохион байгуулалт талдаа шинэчлэлт хийсэн. Харин үйл ажиллагааны талын олон асуудал үлдсэн. Зарим нь бие даасан хуулиар зохицуулахаар байх жишээтэй.



Д.МОЛОМЖАМЦ

/Сангийн сайд, Монголбанкны Ерөнхийлөгч асан, эдийн засгийн шинжлэх ухааны доктор/

Банкуудын үйл ажиллагаа өргөжихийн хэрээр Төвбанкны хяналтыг боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна. Төвбанкны хяналтыг эрсдэлийн удирдлагатай холбон хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй байж болох юм. Манай эдийн засаг өнөөдөр зөвхөн банкны богино хугацаатай зээл дээр тулгуурлан хөгжиж байна. Инфляцийн түвшин өндөр тэгээд ч богино хугацаатай зээлийн

хүү их байдаг учраас бизнес эрхлэгчид олсон орлогоо банкны зээлийн хүүдээ төлөөд, үйлдвэрлэлээ өргөтгөх өөрийн гэсэн ямар ч хөрөнгийг эх үүсвэртэй болох боломж хомс байна. Эдийн засгийн хөгжлийн энэ загвараас аль болох богино хугацаанд гарч, урт хугацаатай, өртөг хямдтай хөрөнгийн эх үүсвэр дээр эдийн засаг тулгуурлан хөгжих хөгжлийн загварт шилжих нь чухал байна. Урт хугацаатай хөрөнгийн эх үүсвэрийг бий болгох зах зээлийн арга, механизм бий болоогүй байна. Энэ зорилтыг төсвийн болон мөнгөний бодлогод тусгаж, Монголбанк болон Засгийн газрын зүгээс тодорхой арга хэмжээ авах нь зүйтэй санагдана. ■

ТӨР БА ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛ

САЙН ТҮНШЛЭЛИЙН СУУРЬ

Саяхныг хүртэл зам харгүй тавьж, цахилгаан станц, эмнэлэг үйлчилгээний газруудыг барих нь зуун хувь төрийн хийдэг ажил байв. Харин одоо төр, хувийн хэвшил түншилснээр хувийн хэвшлийн хөрөнгийг эргэлтэд оруулах боломж гарч байна. Зөв хэрэгжүүлж чадвал оролцогч хоёр талын аль алинд нь ашигтай.

Х.ХУЛАН

Концесс хэмээх үг Монгол хэлэнд нэвтэрч, өргөнөөр хэрэглэгдэх боллоо. Одоогоос хоёр жилийн өмнө УИХ-аар баталсан Концессын тухай хууль төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийг Монголд өргөн утгаар нь ашигладаг болох найдварыг төрүүлж байна. Энэ чиглэлээр хөрөнгө оруулж, хэрэгжүүлж эхэлсэн төсөл одоогоор харахан байхгүй ч цаашдын боломжууд нээлттэй. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас 2011 онд “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги”-ийг баталсан. Энэхүү стратегид хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа болон түншлэлийг хөгжүүлэхэд төрийн зүгээс дэмжихийг албан ёсоор тунхагласан. Энэ нь эдийн засгийн өсөлтийн хандлага ба хариуцлага хувийн хэвшлийн нуруун дээр бууж буйг тод томруунаар илтгэж байна. Жишээ дурдахад, Сайшандын аж үйлдвэрийн цогцолбор, Дорнодын нефть боловсруулах үйлдвэрийг ТХХТ-ээр хэрэгжүүлэхээр болжээ.

Францын нийслэл Парис хотын билгэ тэмдэг болсон Эйфелийн цамхагийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар 1889 онд барьсан түүхтэй. Өмнөд Солонгосын Инчоны онгоцны буудлын 20 гаруй км хурдны замыг ч мөн ийм маягаар байгуулжээ. Ийнхүү ТХХТ-ээр хэрэгжсэн төслийн жишээ олон улсын хэмжээнд үй олон бий.

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр урт хугацааны хамтын ажиллагааны төслийг оролцогч талууд гэрээний дагуу гүйцэтгэдэг. Өөрөөр хэлбэл, нэг талаас төр, нөгөө талаас хувийн хэвшил хамтарч дэд бүтэц болон нийгмийн суурь үйлчилгээг олон нийтэд үзүүлэхийг хэлнэ. Саяхныг хүртэл зам харгүй тавьж, цахилгаан станц, эмнэлэг үйлчилгээний газруудыг барих нь зуун хувь төрийн хийдэг ажил байв. Харин одоо төр, хувийн хэвшил түншилснээр хувийн хэвшлийн хөрөнгийг эргэлтэд оруулах боломж гарч байна. Зөв хэрэгжүүлж чадвал оролцогч хоёр талын аль алинд нь ашигтай. Гэхдээ сайн түншийн хамтын ажиллагааны зам урт хийгээд шийдвэрлэх асуудал олон.

Улсын хэмжээнд концессоор хэрэгжүүлэх нийт 86 төслийн жагсаалтыг Төрийн өмчийн хороо цахим



хуудсандаа нийтэлжээ. Төслийн чиглэлийг доорх графикаас харна уу. Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нэн даруй хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төмөр зам, V цахилгаан станц, Могойн голын цахилгаан станц, мөн замын томоохон төслүүдэд нийт долоогоос найман тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай аж. Эдгээр төслийн заримынх нь гэрээг үзэглэх шатандаа явж байна. Концессын гэрээ байгуулсан төсөл өнөөдөр дөрөв байна. Тухайлбал, Могойн голын цахилгаан станц, Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн автозам, Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг болон Ухаахудаг-Гашуун сухайтын чиглэлийн төмөр замын суурь бүтцийн төслүүд юм.

Төр хувийн хэвшлийн үүргийг тодорхой, ойлгомжтой болгох хэрэгтэй

Их тэнгэрийн “Хан-Уул” харшид чуулсан “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” чуулга уулзалтаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудлаар нухацтай ярилцсан.

Төртэй хамтарч ажиллана гэдэг нь хувийн хэвшлийн өдөр тутмын бизнесийн эрх зүйн зохицуулалтаас ялгаатай. Иймд төр, хувийн хэвшлийн түншлэлд нарийн ▶

► зохицуулалт зайлшгүй хэрэгтэйг Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал хурлын үеэр онцоллоо. Мөн тэрбээр түншлэлээр чанартай, цөөн төсөл хэрэгжүүлэхийг дэмжиж буйгаа илэрхийлэв. Хуралд оролцогсад төр, хувийн хэвшлийн үүргийг тодорхой, ойлгомжтой байлгах хэрэгтэй гэдэг дээр санал нэгдсэн. Учир нь, өнөөг хүртэл олон нийтийн дунд энэ талаарх ойлголт зөрөөтэй байсаар. Төрийн зүгээс ТХХТ-ийн төсөлд чанарын стандартыг тогтоож, түүнийгээ хатуу чанд хянах үүрэгтэй. Хувийн хэвшил харин шилдэг техник технологи, ноу-хау, хүний нөөц, хөрөнгийн эх үүсвэрийг гаргана. Түүнчлэн түншлэл өрсөлдөөнтэй байх ёстойг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун сануулав. Мөн тэрбээр Монголын хувийн хэвшлийн эрчимтэй хөгжиж байгаа нууц бол төрийн захиалга гэж тодорхойлов. Герман улс XIX зуунд яг ийм загвараар хөгжсөн түүхтэй аж. Улс орноо аж үйлдвэржүүлэх, төмөр зам тавих ажилд хувийн хэвшлийн түлхүү татан оролцуулж байжээ.

Төгс хууль гэж байдаггүй

"Хоган Ловэллс" компанийн ажилтан Алекс Вон нь Монголын Концессын тухай хууль төр, хувийн хэвшлийн оролцоо ямар байх ёстойг гаргаж чадсан хууль болсон гэж ярилаа. Ер нь ямар ч хууль төгс төгөлдөр байдаггүй бөгөөд энэхүү баримт бичиг бол ТХХТ-ийн үйл ажиллагааны эцсийн бус, эхлэлийнх гэж ойлгож байгаагаа илэрхийлэв. Түүнийхээр Монгол Улс Концессын хуулиа хэрхэн хөгжүүлэх вэ гэдэг нь ирээдүйн эдийн засагт нөлөөтэйг тэмдэглэв.

Ч.Хашчулуун дарга Төсвийн тухай хууль ТХХТ-ийг хөгжүүлэх тал дээр дутагдалтай болсон гэж үзэж байна. Учир нь өнгөрсөн оны төгсгөлөөр баталсан тус хуулиар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хөгжлийн бодлогыг орхигдуулжээ. Бусад оролцогчдын зүгээс ч гэсэн энэхүү том Сангийн яамны оролцоо сул байгааг хэлж байлаа.

Төсөв үү, төр, хувийн хэвшлийн түншлэл үү, Хөгжлийн банк уу?

Санхүүгийн арга хэрэгслийн олон хэлбэрийг зөв ашиглавал үр дүнтэй болно. Энэ дүрэм журам ТХХТ дээр ч адил үйлчилнэ. ҮХШХ-ны дарга дараах зүйлийг онцолж байна. Нийгмийн чанартай, ашиг багатай төслийг /жишээ нь засмал зам барих/ ТХХТ-ээр хэрэгжүүлэхээр тавьдаг нь буруу юм. Ийм төслийг төсвөөр л хийх учиртай. Харин тодорхой хэмжээний ашигтай байвал ТХХТ, өндөр үр ашигтайг банкаар хийдэг байна. Тэгж байж эргэн төлөгдөх процесс зөв зүйтэй хийгдэнэ. Тэгэхгүй бол үр ашиггүй төслийг үнэтэй эх үүсвэр Хөгжлийн банк дээр тавих нь буруу юм гэж Хашчулуун дарга учирлаж байна. Хөрөнгө оруулалтын бодлого хоцрогдсоныг дугуй ширээний ярилцлагад оролцогсад хүлээн зөвшөөрч, төсвийн хөрөнгө оруулалтын хуулийг сайжруулахыг зөвлөв. Үүн дээр Сангийн яамны нягт хамтын ажиллагаа нэн түрүүнд шаардлагатай байгааг тэмдэглэсэн.

Санхүүгийн механизмыг хэрхэн яаж хэрэглэх нь

ТХХТ-ийг амжилттай хэрэгжүүлэх суурь

ТӨХ-ны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн концессын газрын мэргэжилтэн И.Батхүү нь ТХХТ-ийг амжилттай хэрэгжүүлэхэд нөлөөлөх элементүүдийг нэрлэв.

1. Ил тод байдал. Ард нийтэд ил тод байдал хэрэгтэй. Бүх зарласан төндөрийн үр дүнгийн талаар мэдээлж байх ёстой. Хөрөнгө оруулагч талдаа ийм төсөл хэрэгжинэ, төрийн зүгээс ийм оролцоотой байна гэдэг нь нээлттэй байх ёстой. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчид байгаль орчны шаардлага гэх мэт бүх зүйл ил тод байх ёстой.

2. Тэгш байдал. Дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчид бүгд тэгш эрхтэй. Ялгаварлан гадуурхахгүйгээр шалгаруулалт явагдах ёстой.


3. Үр ашигтай байдал. Эдийн засгийн үр ашигтай байх ёстой.

4. Төсөл өөрөө нийгмийн шинж чанартай байх. Төрийн тодорхой тусламж дэмжлэгээр төсөл зээлжих боломжтой.

5. Төслийн эцсийн зорилго нийтэд зориулсан байх ёстой.

6. Хувийн хэвшлийн шилдэг менежмент, технологи, нау-хауг нэвтрүүлэх.

Концессийн зүйлийн жагсаалт



гагцхүү эдийн засагчдийн шийдэх асуудал. Харин үүнтэй холбоотой нэгэн жишээ дурдъя. Германы Эдийн засгийн судалгааны төвийн захирал, шилдэг эдийн засагч, профессор Ханс-Вернер Зиннээс Английн өдөр тутмын "The Independent" сонины сэтгүүлч "Танд ертөнцийг өөрчлөх эрх мэдэл, боломж байсан бол Та ямар алхам хийх вэ" гэж асуухад "Европын бүх эдийн засаг хариуцсан сайдыг эдийн засгийн хичээлд, эдийн засгийн бодлого хариуцсан гишүүдийг харин эдийн засгийн суурь мэдлэг олгох курст явуулна" гэж хариулсан байна. ►

▶ Баталгааны сан

Хэлэлцүүлгээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдыг дэмжих Баталгааны санг үүсгэн байгуулах асуудлыг Ч.Хашчулуун дарга танилцуулсан юм. Өөрөөр хэлбэл, тухайн хувийн хөрөнгө оруулагчийн мөнгө эргээд компани, хувь хүндээ төлөгдөнө гэсэн баталгааг өгнө гэсэн үг. Жижиг, дунд үйлдвэрлэгчдийг дэмжих Зээлийн батлан даалтын сан манайд саяхан бий болсон. Харин төр, хувийн хэвшлийн түншлэлийн үйл ажиллагааны хүрээнд Баталгааны сантай болсноор хувийн хөрөнгө оруулагчдыг дэмжих бодлоготой болох аж.

Монгол Улсад төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх үйлсэд бодлого боловсруулахаас авахуулаад өнөөгийн түвшин хүртэл олон улсын байгууллагууд идэвх зүтгэлтэй хамтарч ажиллаж байгаа. Азийн хөгжлийн банк, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Европын сэргээн босголтын банк цаашид ч гэсэн ТХХТ-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах байр сууриа илэрхийлж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, Монголын төр, хувийн хэвшлийн түншлэлд туршлага дутмаг байгаа ч оролцогч талууд харилцаа холбоогоо сайжруулж, хууль хоорондын уялдаа холбоог сайжруулбал ТХХТ нь эдийн засгийн цөм болох нь гарцаагүй ажээ. ■

ГАЗРЫН ТОС

ХУВААНА, ХУВААХГҮЙ

1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуульд цаг үеэ дагасан олон чухал шинэчлэл, сайжруулалт хэрэгтэй байна. Учир нь хяналт, шаардлага сулрах тусам ашиг хонжоо хайгчдад тааламжтай орчин бүрдэж байдаг бичигдээгүй хууль манай газрын тосны салбарт цэцэглээд байгааг Газрын тосны газрын мэргэжилтнүүд сануулдаг.

Б.ЭНХМАРТ

Газрын тосны 1.6 тэрбум тонн нөөцтэй улс хамгийн түрүүнд юу хийх хэрэгтэй вэ. (Үүнээс баталгаат нөөц нь 196 сая тонн буюу жил ирэх тусам өсөж байдаг) Хайгуул, олборлолт гэж Та бодож байна уу. Үгүй ээ, зөв замаар дөтлөх эрх зүйн таатай орчин хамгийн чухал. Тэгвэл тийм орчин манайд бий юү. Энэ асуултад “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” олон улсын чуулганы үеэр ЭБЭХ-ний сайд Д.Зоригт “Газрын тосны тухай хууль бол манай улсын БНМАУ-ын гэх тодотголтой цөөхөн хуулийн нэг. Энэ утгаараа маш тогтвортой мөрдөгдөж буй сайн хууль юм” хэмээн хэлсэн.

Энэ үг танхимд багагүй шуугиан тарьж, оролцогчид “Газрын тосны арвин нөөцтэй атлаа нефтийн хувьд ОХУ-аас бүрэн хараат байгаа нь зарим талаараа хууль, эрх зүйн орчинтой шууд хамааралтай шүү дээ. Гэтэл салбарын сайд нь ингэж ярьж байх

юм. Төрд, дотоодын компаниудад, ард түмэнд ашигтай, хэрэгтэй зүйл хийхийн тулд одоо мөрдөгдөж буй Газрын тосны тухай хуулийг зайлшгүй сайжруулан, шинэчлэх шаардлага тулгараад байна” хэмээж байв.

Үнэхээр 1991 онд батлагдсан Газрын тосны тухай хуульд цаг үеэ дагасан олон чухал шинэчлэл, сайжруулалт хэрэгтэй байна. Учир нь хяналт, шаардлага сулрах тусам ашиг хонжоо хайгчдад тааламжтай орчин бүрдэж байдаг бичигдээгүй хууль манай газрын тосны салбарт цэцэглээд байгааг Газрын тосны газрын мэргэжилтнүүд сануулдаг.

Саудын Араб зэрэг орны хэдхэн цагийн дотор өлхөн олборлочихдог 300 мянган тонн газрын тосыг манайд дотоод, гадаадын хөрөнгө оруулалттай 14 компани жилийн хугацаанд хамжиж, дэмжин байж олборлож байна. Энэ нь дэндүү бага тоо мэт боловч манайх шиг хүн

ам цөөтэй, хөгжил дөнгөж соёолж буй оронд чамлах зүйл огт биш. Энэ тоог 2015 он гэхэд 1.5 сая тоннд хүргэхийг зорьж буйгаа салбарын сайд хэлж байсан. Тэгээд ч манайх өнгөрсөн оны байдлаар газрын тосны нөөцөөрөө дэлхийн 100 гаруй орноос 33 дугаар байрт жагссан нь тун догь үзүүлэлт. Энэ нь чамлахаар чанга атгаж, чулуу болгож чадвал сайхан ▶

Улсын төсөвт оруулсан орлого
(сая/төгрөг, 2011 оны 09 сарын 30-ны байдлаар)

| | Борлуулалтын орлого | Бусад Орлого |
|--------------|---------------------|--------------|
| 1997-2003 он | 2211 | 627 |
| 2004 он | 1104 | 86 |
| 2005 он | 1678 | 0 |
| 2006 он | 4906 | 90 |
| 2007 он | 10465 | 424 |
| 2008 он | 33785 | 411 |
| 2009 он | 28011 | 1733 |
| 2010 он | 54700 | 2400 |
| 2011/09 сар | 46900 | 600 |



ирээдүй биднийг тосож буйг илтгэж байгаа хэрэг бус уу.

Монголын газрын тосны салбар бол дөнгөж хөлд орж буй нялх хүүхэд. Энэ ч утгаар нь дэлхийн туршлага сууж, доль цохисон газрын тосны мангасууд манайхыг сонирхож, онилж эхэлсэн. Гэхдээ тэд одоо мөрдөгдөж буй хуульд салхи оруулахгүй хэдэн жил хав дарах Бүтээгдэхүүн хуваах гэрээг халах хүсэлтэй байна. Үүнийг манай нефть импортлогчид дэмжиж буйг олон улсын чуулганы үеэр “Петровис” ХХК-ийн ТУЗ-ийн дарга Ж.Оюунгэрэл илэрхийлж байсан. Тэрбээр “Бид өөрсдөө зардал мөнгө, хүч зориулж, гаргаж, хайгуул хийж, явж явчихаад арай ядан жаахан тос олж байна. Гэтэл түүний 70-75 хувийг Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газар авчирдаг. Манайх шиг олборлолттой гаднын орнуудад бүтээгдэхүүний 60-62 хувийг нь л Засгийн газар нь авч байна шүү дээ. Гэтэл манайх нефть импортлогч хэдэн компаниа боомилж, шахаж байгаа юм шиг 75 хүртэлх хувийг нь хэнэг ч үгүй халааслачихаж байна. Бид эрх зүйн тогтвортой байдлыг хүсэж байна. Хуулиа шинэчлэх гэж байгаа бол бидний санал хүсэлтийг баллаж, баллуурдалгүйгээр тусгахыг хүсэж байна. Хуулийн засаж сайжруулахтай холбоотой санал авч байна гэж баахан ажил удчихаад, батлагдаад гараад ирэхээрээ танигдах аргагүй болчихсон байдаг. Шууд хэлэхэд зовж олсон бүтээгдэхүүнээ хуваамааргүй байна” гэсэн юм.

Хэн ч өөрийн гар, хүч, хөдөлмөрөөр хийсэн ажлынхаа ашгийг бусдад зүгээр өгөхийг хүсэхгүй. Гэхдээ газрын тосны салбар бол арай өөр асуудал юм. Учир нь, Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа байгалийн болоод газрын баялаг нь нийт

ард түмний өмч. “Тавантолгой” ХК-иас иргэн бүрт хувьцаа тарааж буй шиг хүн бүхэн баялаг болгоноос ашиг хүртэхийг хүснэ. Энэ зарчмын дагуу Засгийн газар Бүтээгдэхүүн хуваах зарчмыг халахгүй байхаар Ерөнхийлөгчийн санаачлан найруулж буй Газрын тосны тухай хуульд тусгаад байгаа аж. Хуваана. Хуваахгүй. Хэн нь дийлэх бол.

Нефтийн импортыг атгах, газрын тосны олборлолтын ашиг шимийг бүтээгдэхүүн хуваах зарчмаар өөртөө төвлөрүүлэх нь хэнд ашигтай, ямар үр дагавартай вэ. Нефть импортлогчдын нүдээр бол төр бүгдийг гартаа авах нь тэдний ач холбогдол, ашгийн урсгалыг хаах, цаашлаад мөхөөх бодлого агуулж байгаа гэх. Цаашилбал, үндэсний хэмжээний хэдэн жижиг компанийнхаа амыг барьчихаад, гаднаас том хөрөнгө оруулагч урьж, бидэнтэй бус тэдэнтэй ашгаа хуваах гэж байгаа гэх хардлагын үгийг ч цухуйлгаж буй.

Харин төрийн санаагаар бол байгалийн баялгийн үр ашгийг улс орны эдийн засагт төвлөрүүлэх, олдсон даруйд түүхийгээр нь зарахгүй, нефтийн бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх, шатахуун, түлшний үнийг дуртай цагтаа үгсэн хуйвалдаж, нэмж байгааг таслан зогсоож, тогтвортой болгох аж.

Жирийн иргэний хувьд тэдний хэн дийлэх нь хамаагүй. Дотооддоо жаахан ч гэсэн шатахуун үйлдвэрлэж, ганц орноос хэт хараат нефтийн бүтээгдэхүүний импортыг багасгах нь л чухал. Эцсийн үр дүнд шатахууны үнэ нэмэгдэхгүй, болж өгвөл бууж байх нь л ашигтай. Гэхдээ үүний цаана төр төмөр нүүрээ үзүүлж байна гээд энэ салбарт хөлс хөдөлмөрөө зориулж ирсэн бизнес эрхлэгчдийг хөсөр хаяж болохгүй юм. Хамгийн наад зах нь хайгуулын тусгай зөвшөөрлийг ямар шат дарааллаар

олгох, бусдад шилжүүлэхэд яах ёстой гээд одоо үгүйлэгдэж байгаа, өмнө нь хаалт тушаа болсоор ирсэн заалтуудыг Засгийн газар шийдвэрлэж, тодорхой болгох хэрэгтэй аж.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний зарчмыг дэлхийн олон орон хэрэглэдэг ч танай улстай адил маргаан гарсаар л байна хэмээн “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” чуулганд оролцогч Их Британи Умард Ирландын нэгдсэн вант улсын Элчин сайд Кристофер Стюарт хэлсэн. Тэрбээр “Аль болох тэнцвэртэй байдлыг хангах хэрэгтэй. Төр эрсдэлтэй салбарыг хувьд шилжүүлж орлогоос нь ашиг авахыг чухалчилдаг. Үүнд татварын болоод төсвийн зөв бодлого маш чухал. Шинэ хуульдаа яг хэдэн төгрөгийн татвар авахыгаа сайн хэлэлцсэний дүнд тусгах хэрэгтэй. Гаднын ижил түвшинд байгаа улсуудын энэ салбарын бизнестэй харьцуулж, төлөвлөх нь ирээдүйд хэрэгтэй юм. Танайх шиг сайн хөгжөөгүй ийм салбарт гаднын томоохон хөрөнгө оруулалт, дадлага туршлага зайлшгүй шаардлагатай. Тиймээс томоохон хөрөнгө оруулагчдыг татах бодлого боловсруулсан нь илүү үр дүнд хүрнэ. Эрсдэл ихтэй салбар учраас татвар өндөр байх тусам гаднын хөрөнгө оруулагчид сонирхохгүй байх талтай. Өнөөдөр Индонези бүтээгдэхүүний 85 хувийг авна гэж байгаа. Гэтэл уг асуудлыг Гүйцэтгэгчид зөвшөөрөхгүй, хөрөнгө оруулалтын хандалт буурсан үзүүлэлттэй байна. Хууль баталснаар бүх асуудал шийдэгдэхгүй. Хэрэгжүүлэх, улам сайжруулах нь аль ч салбарыг өөд нь татах гарц байдаг” гэсэн юм.

Гаднын улсуудад ялангуяа манайх шиг цөөн хүн амтай орнуудад Засгийн газар, хувийн хэвшлийн Бүтээгдэхүүн хуваах гэрээ 30:70, 35:65 гэх маягаар явж буйг чуулганд оролцогчид тэмдэглэж байсан.

Байгалийн баялагт түшиглэсэн салбарууд хөгжиж буй энэ үед энэ мэт цоорхой үлдээхгүй байх нь монголчуудад л хэрэгтэй. Ялангуяа чанга хатуу хууль, зохицуулалтын дор, ирээдүйдээ хувь үлдээх зарчмаар ажиллах нь бидний үүрэг юм. ■

ӨРСӨЛДӨӨН

ӨӨРЧЛӨЛТ ҮГҮЙЛСЭЭР

Үндэсний бөхийн барилдаанд найраа орвол Улсын наадам сонирхолгүй боллоо гэлцдэг манайхан. Тиймээс бизнест ч спортод ч найрах, хуйвалдахыг таслан зогсоож, шударга өрсөлдөөнийг дэмжвэл хөгжил ирнэ.

Б.УУГАНБАЯР

Өрсөлдөөний тухай асуудлыг бичихийн өмнө эхлээд нэг онигоо сонирхуулъя л даа. Нэг эрхэм шинээр бизнес эхэлж буй дүүдээ зах зээлд хэрхэн өрсөлдөх гурван алтан зөвлөгөө өгч байна гэнэ ээ. Нэгдүгээрт, Сайдынхаа компанитай бүү өрсөлд, эс бөгөөс хэзээ ч өөдлөхгүй. Хоёрдугаарт, сайдын эхнэр, хүүхдүүдийн компанийг мэдэж ажилла. Гуравдугаарт, сайдын найз нарын компаниудыг сайн таньж байж ярь. Тэгээд орон зай үлдвэл бизнесээ эхлэ гэжээ. Энэ нь хэдийгээр явган шог ч зах зээлийн зарчимд төр хэтэрхий гар дүрж, иргэдийг тусгай зөвшөөрөл, дүрэм журмаараа төөрөлдүүлж, авлигын сүлжээг үүсгэж буйн тод илрэл юм. “Сайн компани, чанартай бүтээгдэхүүнийг өрсөлдөөн л тодруулж гаргадаг. Спортын их аваргууд ч өрсөлдөөн дундаас төрдөг. Үндэсний бөхийн барилдаанд найраа орвол Улсын наадам сонирхолгүй боллоо гэлцдэг манайхан. Тиймээс бизнест ч спортод ч найрах, хуйвалдахыг таслан зогсоож, шударга өрсөлдөөнийг дэмжвэл хөгжил ирнэ” гэдгийг УИХ-ын гишүүн Д.Энхбат онцолсон удаатай.

Тэгвэл Монгол Улс шударга өрсөлдөөнийг зохицуулах үүрэгтэй биедаасан агентлаг, Өрсөлдөөний тухай хуультай. Гэвч холбогдох газрууд шударга бус өрсөлдөөнийг хянаж, зохицуулж чадахгүй өдий хүрч байна. Үүнийг “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” чуулганы “Өрсөлдөөний бодлого ба зохицуулалт” салбар хуралдааны үеэр оролцогчид хатуухан шүүмжилж, ширүүхэн ярилцсан. Уг нь шударга өрсөлдөөн нь улсын эдийн засгийг эрүүлжүүлэн, өрсөлдөх чадварыг сайжруулж, сайн хөгжлийн зам руу хөтөлдөг.

Хэрэглэгчид эвлэлдэн нэгдэж эрхээ хамгаалах гарц бий

Дэлхий нийтийн жишигт шударга бус өрсөлдөөнийг хянаж, зохицуулах байгууллага нь холбогдох шүүх цагдаагийн байгууллагатай хамтарч ажилладаг хүчирхэг институт байдаг аж. Харин хэрэглэгчийн эрх ашгийг

хамгаалах байгууллага нь иргэдийн өөрсдийн санаачилгаар бий болсон иргэний нийгмийн томоохон төлөөлөл юм байна. Гэтэл манайд шударга өрсөлдөөнийг зохицуулж, хянах байгууллага нь хэт ахадсан ачааг үүрчээ. Аж, ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнийг зохицуулах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зар сурталчилгааны болон тендерийн хуулийн хэрэгжилтийг хангах гээд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагааны хамрах хүрээ өргөн. Тийм олон салбарт хүрч үйлчилж хяналт, зохицуулалт хийх өргөн бүтэц бүрэлдэхүүнтэй байгууллага юм уу гээд харвал огт тийм биш. 40-өөд хүнтэй Засгийн газрын тохируулагч агентлаг. Бусдаас гавьж шалих, онцгойрч ялгарах зүйл огт байхгүй. Харин онолоороо бол чиг үүрэг нь бусдаас том, өөр байх ёстой. Тэгэхлээр тэд олон хуульдаа төөрөлдөөд гаргаж буй шийдвэр нь үр дүнгүй байдаг.

Дээр нь манайд Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбоогдох сүржин нэртэй төрийн бус байгууллага ерээд оны эхээр байгуулагдсан нь сайн оролдлого. Гэвч тус байгууллага дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай адил иргэдийнхээ эрхийг хамгаалахаар хүчтэй дуугарах чадамжтай байгууллага болж зөв төлөвшөөгүй, хэрэглэгчдэд үйлчилгээ нь хүрдэггүй амьгүй газар хэвээр байсаар. Жишээ нь, Японд Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага нь хэрэглэгчдийнхээ гомдлыг хүлээж авах 600 орчим орон нутгийн төвтэй бөгөөд ирсэн бүх гомдлыг хэрэглэгчийн мэдээллийн санд байршуулж, дүн шинжилгээ хийж, барагдуулдаг байна.

Австралид Шударга худалдааны хууль гэж байдаг аж. Энэ хуулиараа хэрэглэгчийн эрхийг хамгаалах, шударга өрсөлдөөн болон эдийн засгийн тогтвортой өсөлтийг баталгаажуулах чиглэлд анхаардаг аж. Гэтэл манайд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлаар ярих ч шаардлагагүй, унтаа байдалд байгааг дээрх хурлын үеэр олон хүн шүүмжилсэн. “Нэг өглөө сэрэхэд л худалдаа эрхлэгчид бензинийн үнэ нэмэгдэх эсвэл бэлэн мөнгө тараах сургаар бараа, бүтээгдэхүүний үнээ шууд нэмчихдэг тогтолцоо бүрдээд удаж байна” гэдгийг Ерөнхийлөгчийн



Шог зургийг А.Амарсайхан

зөвлөх Л.Дашдорж иргэн хүнийхээ үүднээс бухимдан хэлсэн юм. Хамгийн сүүлд өнгөрсөн хоёрдугаар сард бензинийн үнэ литр тутамд 200-260 төгрөгөөр огцом нэмэгдэж олон хүнийг сандаргасан. Дараа нь үнээ шат дараатай буулгасан. Гэтэл шатахууны үнийг дагаж өссөн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ буурахгүй улам өссөөр. Уг нь энд хяналт тавьж, хэрэглэгчдийн дуу хоолой болох ёстой дээр нэрдурдсанаас гадна Нийслэлийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг ч гэж бий. Нэрнээс цаашгүй байгууллагууд байх юм даа.

Үгсэн хуйвалдахаа зогсоовол өрсөлдөөний салбар эрүүлжинэ

Манайд үгсэн хуйвалдах буюу картелийн ашгийг аж, ахуйн нэгжүүд хүртсэн тохиолдолд хэрхэн илрүүлэх, ямар хариуцлага тооцох нь тодорхойгүй байна. Энэ нь нэг ёсондоо хариуцлага тооцох механизм алга гэдгийг харуулж байна гэж хурлын үеэр амтай бүхэн шүүмжилсэн. Ийм тохиолдолд компаниуд алга ташин аль болох ахиу ашиг олохыг бодож, хуулийн цоорхойг ашиглах гэж улайрах нь мэдээж. Дэлхий нийтийн жишигт картелийн ашиг хүртсэн /үгсэн хуйвалдаж үнээ өсгөсөн/ албан тушаалтан, аж ахуйн нэгжид өндөр торгууль ногдуулж, эрүүгийн хэрэгт татдаг байна.

Манайхтай эдийн засгийн хөгжлийн хувьд ойролцоо хөгжиж буй Чили улс гэхэд арав хүрэхгүй жилийн дотор өрсөлдөөний салбарын зохицуулалтаа өндөр түвшинд хүргэж чаджээ. Ингэхдээ төрөөс хараат бус Өрсөлдөөний шүүх гэдэг байгууллагыг бий болгон, торгуулийн хэмжээг огцом өндөрсгөж, картелийн шинжтэй хэргүүдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулан хянаж шийтгэлийн механизмыг чангаруулсан байна. Үүний зэрэгцээ Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газар гэгч мөрдөн шалгах эрхтэй төрийн бус байгууллагынхаа чадавхыг ч бэхжүүлжээ. "Чилийн энэ туршлагыг манайх хэрэгжүүлэхэд хамгийн тохиромжтой загвар" гэдгийг АНУ-

ын Олон улсын хөгжлийн агентлагийн "Бизнесийг дэмжих санаачилга" төслийн Техник болон менежментийн зөвлөх Фернандо Бертоли онцолсон. Ярьж, хэлээд өнгөрөх биш, Чилийн туршлагыг Монголд хэрэгжүүлэхээр тус Олон улсын хөгжлийн агентлагын "Эдийн засгийн бодлого шинэтгэл, өрсөлдөх чадвар" төслийн олон улсын зөвлөх Пабло Гарсия 2010 онд Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрынханд долоон сарын хугацаанд номын дуу сонсгожээ. Энэ мэтээр олон улсын байгууллагаас манайд өрсөлдөөнөө сайжруулах арга зам, туршлагыг нь заагаад байхад Засгийн газар, төрийн байгууллагууд нь нүдэн балай, чихэн дүлий байсаар байгаа нь харамсалтай. "Илжигний чихэнд алт хийсэн ч сэгсэрнэ ус хийсэн ч сэгсэрнэ" гэгчээр бэлээхэн туршлагыг хэлж, ярьж бэлэн будаа ам руу нь хийгээд байхад идэхгүй суугаад байгааг юу гэж ойлгох вэ. Өрсөлдөөнийг тийм сайн хөгжүүлчихсэн бол яая гэх вэ гэж бодохсанж. Харин бизнесийнхэн энэ хооронд картелийн ашиг хүртэж, халаасаа түнтийлгэж байгаа нь нууц биш.

Өрсөлдөөнийг боомилж буй Өрсөлдөөний тухай хууль

Өрсөлдөөний талаар УИХ-ын гишүүн Д.Энхбат хэлэхдээ "Зах зээлд өрсөлдөөнийг шударга байлгая гээд байдгийн гол зорилго нь бизнест иргэн бүрийн оролцох боломжийг тэнцүү нээж өгөх, түүнд учирч буй зохиомол болон бодит саадуудыг аль болох багасгах явдал юм. Энэ бол иргэдийн эдийн засгийн эрх чөлөөг хангах үзэл баримтлалын хамгийн чухал хэсэг юм" хэмээсэн.

Гэвч эрүүл өрсөлдөөн явагдаж, эдийн засаг хөгжих боломж манайд алга. Учир нь, Өрсөлдөөний тухай хууль нь зөрчилтэй, тодорхой бус заалт ихтэй учир өрсөлдөөнөө боомилоод буйг Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Дашдорж дурдсан. Жишээ нь, тус хуулийн гуравны нэг нь Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын үйл ажиллагаа, статусыг заасан, өрсөлдөөнд харш буюу давамгайл байдлыг ▶

► зохицуулах тал руу голлон чиглэсэн байна. Гэвч цаана нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах, жижиг, дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчийг дэмжих асуудлыг анхаарахгүй орхигдуулж буй. Мөн тус хуулийг батлахдаа хувийн хэвшлийнхэн, бизнес эрхлэгчдийн байр суурийг тусгаагүй, улсынхаа зах зээлд нийцүүлэн, судалгаанд үндэслэн гаргаагүй буюу хуулийн заалтын гуравны нэгийг нь ОХУ-ын Өрсөлдөөний тухай хуулиас шууд иш татсан тухай МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн багш Б.Тэмүүлэн сануулсан.

Бид энэ балчиг намганд шигдсэн арчаагүй байдлаасаа гарч, өрсөлдөөний үнэрийг бизнесийн салбартаа авчрахын тулд юун түрүүнд эдийн засгийн эрх зүйг түлхүү хөгжүүлж, эдийн засгийн бодлогоо хуультайгаа зайлшгүй уялдуулах шаардлагатайг Тэмүүлэн багш уриалсан. Өрсөлдөөний тухай хууль нь Иргэний ба Захиргааны хуульд үндэслэдэг байвал бизнесийн эрх зүйн орчинд илүү нийцэх юм байна. Дээр нь зах зээлийн харилцаанд оролцогч аль аль талын харилцааг зохицуулах бололцоо бүрдэнэ. Өнөөгийн практикаас харахад, бизнест тулгарч буй гол бэрхшээл нь дийлэнхдээ захиргааны шинжтэйгээр илэрч буй аж. Энэ эрх картелийн ашиг

хүртэж буй компаниудын хариуцлагаас мултрах гэсэн эрх ашгийн сонирхлоос үүдэлтэй гэсэн хардалт байгаа юм. Энэ мэт шил, шилээ дагасан ширүүхэн шүүмжлэл өрсөлдөөний салбарт бугшиж, цаг үе өөрийн эрхгүй өөрчлөлт, шинэчлэлтийг шаардаж байна. Тэгэхээр бизнесийн салбарын гол хууль болох өрсөлдөөний тухай “халтар” хуулиа засаж, өөд нь татаж зөв замд оруулахгүй бол энэ салбар тогтоол ус шиг зогсонги байдалтай илжирч муудах нь ээ. Ингэх юм бол манай улс хий хоосон эдийн засгийн өндөр өсөлт, бизнесийн орчны шинэчлэл ярьж, дотроосоо авлига, хээл хахуульд идэгдэн, гадна талд нь иргэд нь ядарч туйлдах нигууртай гэдэгт хуралд оролцогчид санал нэгдэж, санааширсан юм. Эцсийн шийдэл нь зах зээлд монополь компаниуд картелийн ашиг олсон уу, үгүй юу гэдгийг тогтоож чаддаг төрийн хүчирхэг институтыг одоо байгаа агентлагт тулгуурлан бий болгохыг хамгийн зөв гарц гэж дүгнэсэн. Ийм механизмыг бий болгосон цагт сая өрсөлдөөний салбар эрүүлжих боломж бүрдэх аж. Өрсөлдөөний тухай хуулийг эдийн засаг, бизнесийн салбарын хөгжилдөө нийцүүлэн шинэчилж, хариуцлагын тогтолцоог чангаруулах цаг хэдийнэ ирсэн шүү дээ. ■

ХУУЛЬЧИЙН БОЛОВСРОЛ

МОДОН АЛХ БАРИХЫН НУУЦ

Шинэ эдийн засаг, шинэ улс төр, шинэ үзэл баримтлалыг хөгжүүлэхийн тулд бидэнд чадварлаг эдийн засагчаас гадна сайн хуульч хэрэгтэй байна. Өнөөдөр хэчнээн сайн эдийн засгийн төсөл хөтөлбөр байсан ч гэсэн хууль эрх зүйн орчин нь тодорхойгүй бол амжилтад хүрэхгүй.

Б.ЗОЁНОО

Эдийн засгийн хөгжлийн гол асуудлын нэг бол яах аргагүй гэрээний үр дүнтэй, шударга биелэлтийг хангах байдаг. Тэр тусмаа эдийн засаг үсрэнгүй хөгжиж, гадаад, дотоодын томоохон хөрөнгө оруулагчид эдийн засаг, бизнесийн харилцан ашигтай гэрээ хэлэлцээр байгуулахын төлөө явж байгаа өнөөд үед бидэнд дээрх

асуудал хамгийн чухал юм. Харин уг асуудлын ард шударга шүүх, сайн хууль байх учиртай бол шударга шүүх, сайн хуулийг бий болгох гол хүчин зүйл нь сайн хуульч юм. Тиймээс “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” сэдэвт олон улсын хурлын үеэр “Хуульч, шүүгчдийн бизнесийн маргаан шийдвэрлэх чадавх” сэдвээр

ярилцсан юм.

Арбитр ба асуудал

Арбитрыг анх бизнес эрхлэгчид бий болгосон аж. Учир нь, олон улсад бизнесийн харилцаанд оролцогчид маргаан гарвал шүүхээр шийдвэрлүүлэх сонирхолгүй байдаг ►



МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн дэд захирал доктор, профессор Н.Лүндэндорж

Фотог Э.Зоригт

► аж. Учир нь, шүүхийн шийдвэрийг хүлээх нь цаг хугацаа алдах, эцсийн шийдвэр гарсан ч давж заалдах, тухайн орны хууль зүйн зарчим өөр хоорондоо зөрчилдөх гэх мэт шат дамжлага ихтэй байдаг учраас ихэнх оронд арбитр маргаан шийдвэрлэх оновчтой арга гэдгийг хвлээн зөвшөөрдөг бөгөөд олон улсын шинжтэй томоохон бизнесийн гэрээндүүдэд арбитрын заалтыг заавал оруулж өгдөг байна. Үүний зэрэгцээ дотоодын бизнес эрхлэгчид ч мөн адил арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх сонирхолтой байдаг аж. Тухайлбал, Шведэд худалдааны маргааны 85 хувь нь арбитраар шийдвэрлэгддэг. Харин манайд эсэргээрээ. “Монголын үндэсний Арбитр”-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Ч.Гүнждагва “Хэдийгээр манайд Арбитрын тухай хууль 2003

онд батлагдсан ч бизнес эрхлэгчдийн дунд энэ талын ойлголт тааруу байна. Нэг жишээ дурдахад 2010 онд 12 мянган худалдааны маргаан шүүхээр шийдвэрлэгдсэн бол 2011 онд 13 мянга болж өсчээ. Харин арбитраар ердөө 2010 онд 39, дараа онд нь 45 хэрэг шийдвэрлэгдсэн байна. Уг нь олон улсын жишгээс харахад нийт маргааны 60-70 хувийг арбитраар шийдүүлдэг” гэв.

Манайд гарсан ихэнх маргаан шүүхээр шийдвэрлэгддэг. Тэгвэл манай хуульчдын мэдлэг чадвар чухам ямар байдаг бол. Үнэхээр хуульчид чадвартай учраас иргэд шүүхээр яваад байна уу гэдэг дээр тус хуралд оролцогчид санаа зовж буйгаа нугаагүй юм. Тиймээс уг хуралд уригдсан МУИС-ийн Хууль зүйн дээд сургуулийн дэд захирал доктор, профессор Н.Лүндэндоржтой

ярилцлаа.

-Эдийн засгийн огцом өсөлтийн энэ үед бид хууль эрх зүйн бүрэн үйлчилгээ үзүүлэхэд бэлэн байна уу?

-Хууль зүйн шинжлэх ухаанд өөрийн гэсэн дэд бүтэц байдаг. Түүний нэг гол элемент нь хууль зүйн боловсролын асуудал юм. 1990-ээд онд АНУ-ын нэрт эрдэмтэн Карл Попперны “Нээлттэй нийгэм ба түүний дайснууд” ном орос хэл дээр орчуулагдсан. Тэр номны оршилд Карл Поппер Оросын уншигчдад зориулж бичсэн байдаг. Тэр дундаас миний ишлэх дуртай үг бий. Тэр нь оросууд зах зээлийн эдийн засгийг тогтооё гэж хүсэж байгаа бол хуульчдаа цоо шинээр бэлтгэхээс л эхлэх ёстой гэсэн байдаг.

Тиймээс шинэ эдийн засаг, шинэ улс төр, шинэ үзэл баримтлалыг хөгжүүлэхийн тулд бидэнд чадварлаг эдийн засагчаас гадна сайн хуульч хэрэгтэй байна. Өнөөдөр хэчнээн сайн эдийн засгийн төсөл хөтөлбөр байсан ч гэсэн хууль эрх зүйн орчин нь тодорхойгүй бол амжилтад хүрэхгүй. Учир нь, эдийн засаг ч гэсэн нийгмийн нэг төрлийн харилцаа учраас хуулиар зохицуулагдах шаардлага зайлшгүй бий. Харин хуульч үгүй бол хууль хөгжихгүй. Тиймээс бид хамгийн түрүүнд хуульчаа хөгжүүлэх хэрэгтэй байна. Мэдлэг, дадлага, туршлага гээд бүгдийг суулгаж өгөх учиртай. Монголын хуульчдын арми яаж бүрдсэн гэхээр амьдралын хар ухаан, дадлагаар бий болсон гэж хэлж болно. Муухайгаар хэлэхэд хүн, хүний эрх чөлөөн дээр туршилт хийж өдий зэрэгт хүрсэн гэсэн үг. Нэг ийм үг байдаг даа. Буурай орны эмч яагаад хөгжингүй орны эмч нараас илүү чадварлаг байдаг гэхээр олон хүн дээр бодит туршилт хийсээр байгаад туршлагатай болчихдог гэдэг шиг Монголын хуульчид тийм л байна. Баклавраар ерөнхий эрдэм л сураад гардаг. Нарийн мэргэшдэггүй.

-Хуулийн нэрийн өмнөөс шийдвэр гаргадаг, хуулийг ашиглах эрх бүхий хүн бол яах аргагүй хуульчид. Тэгвэл төрөөс хуульчдаа дэмжих тал дээр ер нь хэр анхаардаг вэ?

-Зах зээлийн эдийн засагт шилжих, нийгэм улс төр, эдийн ►

▶ засгийн шинэтгэлийн үйл явцыг авч явдаг хуульчдыг бэлтгэх тал дээр төр засаг юу хийсэн гээд бодохоор хэлчих зүйл үнэхээр олддоггүй юм. “Эрх зүйн шинэтгэлийн мөрийн хөтөлбөр”-ийг 1998 онд баталсан. Уг мөрийн хөтөлбөр дотор хуульч бэлтгэх талаар нэлээд олон зүйл тусгасан байдаг. Тэгээд уг хөтөлбөрийг Хууль зүй, дотоод хэргийн яам одоогоос хэдэн жилийн өмнө нэгтгэн дүгнэсэн. Тэр дүгнэлтээр төр, засаг яг ийм зүйл хийчихлээ гэсэн дүн гараагүй. Тухайлбал, МУИС-ийн нэг ч хуулийн багшийг Засгийн газрын тэтгэлгээр гаднын сургуульд явуулаагүй байдаг юм. Төсвийн хөрөнгө оруулалтаар энэ талын сургалтын баазыг сайжруулах чиглэлд нэг ч төгрөг тавьдаггүй.

Монголын төр хуульчдаа бэлдэхийн тулд хуруугаач хөдөлгөөгүй гэхэд хэтрүүлэг болохгүй байх. Гэхдээ төр юм хийгээгүй ч МУИС-ийн багш нар болон мэргэжил нэгт нөхөд маань хамтраад олон улсын дэмжлэгтэйгээр багагүй шинэтгэл хийсэн. Тэр дундаа сургалтын арга барилын хувьд өөрчлөлт, шинэчлэл хийсэн. Тухайлбал, МУИС-ийн хуулийн ангид нийт 150 кредит цагийн хичээл ордог. Үүний 25 орчим цагт нь чадваржуулах сургалт орж байна. Энэ нь тохиолдол шийдвэрлэх буюу дадлагаар олж авах ёстой сургалт юм. Гаднын оронд энэ мэт сургалтыг бакалавраар төгссөний дараа нь 2-5 жил тодорхой нэг чиглэлээр мэргэшүүлж сургадаг.

-Монголын эдийн засаг хөгжихийн хэрээр бизнесийн маргаан их гарах болжээ. Тэгвэл олон улсын шинж чанартай бизнесийн маргааныг шийдэх хуульчдын мэдлэг, туршлага хэр байдаг бол. Хуралдаанд оролцогчид энэ талаар их ярьж байна. Та юу хэлэх вэ?

-Үнэхээр эдийн засаг хөгжихийн хэрээр олон улсын болоод нарийн мэдлэг шаардсан маргаанууд гарч байгаа нь үнэн. Тиймээс энэ талын тусгай мэргэшсэн хуульч манайд байхгүй. Гэхдээ бизнесийн маргааныг шийдвэрлэдэг хуульчдын асуудал бакалаврын мэдлэг олгодог бидэнд хамаагүй гэж хэлмээр санагдаж байна. Учир нь, бакалаврын түвшинд сургалт

явуулдаг оронд энэ талын туршлага хуульчдад суулгах боломж байхгүй. Бакалаврын сургалт нь сонгодог утгаараа цаашдаа хуульч болох хүний цагаан толгойг л тавьж өгөх учиртай. Харин бакалавр төгссөн хүн дараа нь тодорхой чиглэлээр сурч боловсрох зайлшгүй шаардлага байдаг. Манайд тэр сургалтын тогтолцоо нь алга. Гэхдээ бидний хэдэн багш өөрсдөдөө хамаарахгүй гээд хаячихалгүй бизнесийн хууль эрх зүйн талаар хичээл заадаг. 150 кредит цагийнхаа 20 орчим цагийг энэ чиглэлд зарцуулж байгаа. Гэхдээ орчин цагийн шаардлагад бол хүрэхгүй. Тиймээс төр, засаг гараа сунгах хэрэгтэй байна. Бид бор зүрхээрээ хол явж чадахгүй.

Гаднын өндөр хөгжилтэй оронд шүүгчдийг сонгохдоо мэдлэг боловсролынх нь хувьд шалгаад зогсохгүй төрөлх мөн чанарын хувьд нь авч үздэг болжээ.

-Төр, засаг хэрхэн туслах хэрэгтэй байна вэ?

-Энэ онд батлагдсан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль гэж бий. Энэ хуулиар анх удаагаа Монгол Улсад тодорхой чиглэлээр хуульчийг мэргэшүүлэх асуудал хөндөгдсөн. Тиймээс үүн дээрээ дөрөөлөөд мэргэшсэн хуульч бэлдэх тогтолцоо бий болгох хэрэгтэй. Бидний тавиад өгсөн энэ хөрсөн дээр үр цацах л хэрэгтэй байгаа юм. Энэ тогтолцоог бүрдүүлж чадахгүй байж хуульчдын чадварын талаар ярих боломжгүй. Өнөөдөр манай шүүгчид шүүхийн шийдвэр бичих гээд барьц алддаг нь нууц биш. Яг ном журмынх нь дагуу бичдэг нь хуруу дарам цөөхөн. Энэ нь юутай холбоотой вэ. Мэргэшээгүй учраас л тэр. Төр хуульчдаа хөгжүүлэх гэсэн юм яах вэ, ийх вэ гээд эрж сураад байх хэрэггүй. Дэлхий нийт нэгэнт мэргэшсэн хуульч бэлтгэх

зайлшгүй шаардлага байна гээд энэ тал дээр аль эрт хуульчдаа бэлдээд эхэлсэн. Тиймээс учиргүй шинэ юм бий болгох биш өмнө нь Өрнө, Дорногүй алдаж оноод өнөөдрийн түвшинд хүргэсэн тэр олон аргын аль нэгийг л сонгох хэрэгтэй.

-Сая Та шүүгчийн талаар цухас дурдлаа. Хүмүүсийн хэлдгээр шүүгчид ёс зүйн хувьд асуудалтай гэдэг. Энэ нь таны бодлоор юутай холбоотой вэ?

-Гаднын өндөр хөгжилтэй оронд шүүгчдийг сонгохдоо мэдлэг боловсролынх нь хувьд шалгаад зогсохгүй төрөлх мөн чанарын хувьд нь авч үздэг болжээ. Тухайлбал, хэн нэгэн төрөлхийн даруу, дөлгөөн барагтай бол уурлаж бухимддаггүй хүн байлаа. Харин нөгөө талд нь юмны цаад учрыг олохоос нааш санаа нь амардаггүй, цовоо сэргэлэн хүн байж болох юм. Тэгвэл энэ хоёр хүний алийг нь шүүгч болгох вэ. Угаас дөлгөөн, тайван хүнийг шүүгч болговол яах вэ. Шүүгч болчихоод тухайн хувь хүний төрөлх мөн чанар нь өөрчлөгдөхгүй шүү дээ.

Харин нөгөө юмны учир олох гээд байдаг нөхрийг шүүгч болговол хэргийн цаад учрыг олох гээд зүтгэнэ. Тиймээс бурханаас заяасан байдлаараа шүүгч болж таарахгүй хүнд шүүгчийн модон алх бариулчихвал юу болох вэ. Тиймээс хүнийг төрөлх мөн чанарынх нь хувьд шилж, сонгож шүүгчийн модон алхыг бариулах нь чухал. Эндээс харахад л хуульч гэдэг хүнийг ямар олон шалгуур хүлээж байгаа нь харагдана. Харин манайд эдгээрийн аль нь ч алга. Ёс зүй гэдэг бол хүний төрөлх мөн чанартай шууд холбоотой асуудал.

-Хурлын үеэр зарим хуульчдын ярьж байгаагаар дагаж мөрдөх хууль нь тодорхойгүй болохоор бидний ажил тодорхойгүй болж байна гэж байсан. Энэ талаар Та юу хэлэх вэ?

-Хамгийн энгийн ганц жишээ дурдаж болох юм. Шүүгч өнөөдөр ямар нэг шийдвэр гаргажээ. Гэтэл тухайн шийдвэрээ чухам юун дээр тулгуурлаж гаргасан бэ гэдгийг дүгнэх, тогтоох хууль эрх зүйн орчин өнөөдөр байхгүй нь бидний бодит байдал. Энэ мэт жишээ олон бий л дээ. ■



ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХОЁР ТӨРИЙН ЭРГЭЛТЭД ХЭЛМЭГДСЭН ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ХУУЛЬ

Б.ЭНХЦЭЦЭГ

Нэгэн цагт хөрөнгө мөнгөний булш хэмээн муугаар хэлүүлдэг байсан Монголын хөрөнгийн бирж хөдөлгөөнд орж, нэрээ сайнаар дуудуулах болжээ.

Нэгэн цагт хөрөнгө мөнгөний булш хэмээн муугаар хэлүүлдэг байсан хөрөнгийн бирж хөдөлгөөнд орж нэрээ сайнаар дуудуулах болжээ. Манай улс олон улсын жишигт нийцсэн үнэт цаасны зах зээлтэй болохгүй аваас хөрөнгийн бирж хөгжинө гэдэг харганы ноос түүж, эсгий хийхтэй адил бүтэхгүй ажил гэдгийг хэн хүнгүй ойлгож, хийж эхэлсэн. Лондоны хөрөнгийн биржийн удирдлага дор Монголын хөрөнгийн бирж хөгжлийн шинэ гараанд хөл тавихаар шийдэн, хоёр талаас “Мастер гэрээ”-г үзэглэсэн нь саяхан буюу түрүү оны дөрөвдүгээр сард. Тиймээс ч Лондоны хөрөнгийн биржид мөрдөгддөг дүрэм журмууд автоматаар Монголын хөрсөн дээр бууж ирж байна. Санхүүгийн зохицуулах хороо уг журамд нийцүүлсэн дүрэм журмуудыг боловсруулаад явж байгаа билээ. Гэсэн хэдий ч 2013 он гэхэд эрх зүйн зохицуулалтаа боловсронгуй болгож хуулиа яаралтай батлах хэрэгтэй байна гэдгийг СЗХ-ны дарга Д.Баярсайхан “Эдийн засгийн өсөлтийн өгөөж ба эрх зүйн шинэтгэл” сэдэвт чуулганы “Хөрөнгийн зах зээлийн зохицуулалт” сэдэвт хэлэлцүүлэг дээр учирлаж байлаа. Энэ нь өөрөөр хэлбэл, хуулиар зохицуулагдах томоохон асуудлуудыг нэг тийш болгохгүй бол “Үүнээс цааш газар үгүй” гэдэг шиг хөрөнгийн зах зээл цаашид өсөн дэвжих бололцоо нь хаагдмал зогсонги болох аж.

Тус ажлын хүрээнд хөрөнгийн биржийнхэн болоод холбогдох байгууллагууд эрвийж дэрвийхээрээ өдийг хүртэл ажилласан ч өнөөдрийн байдлаар хуулийн талаас шинэчлэгдэх ёстой асуудлууд сонгуулийн сүүдэрт халхлагдаж бодлого тодорхойлогчдын гарт гацчихаад байна. Хөрөнгийн биржийн шинэчлэл үндсэндээ цэгцэрч, IT системээ ашиглалтад оруулахад бэлэн болоод байгаа хэдий ч хөрөнгийн зах зээлд оролцогч зарим брокер дилерүүдийн хувьд шинээр үүсч буй үүрэг хариуцлага буюу дүрэм журамтай өөрсдийн үйл ажиллагааг нийцүүлэн, тоглолтод ороход багагүй хугацаа шаардаж байгаа нь ийнхүү хөрөнгийн биржийг хүлээлгийн өрөөнд суулгаад байна гэдгийг МХБ-ийн дэд захирал Г.Саруул хэлж байсан юм.

Монголын хөрөнгийн бирж түмний төлөө байлдахад бэлэн байталилд бамбайг нь өгөх төрийн түшээд яасан их луу унжиж байна вэ. Аль өнгөрсөн хаврын УИХ-ын чуулганаар батлуулна хэмээн төлөвлөсөн “Үнэт ▶

► цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга"-ыг тавдугаар сард хэлэлцэхээ шахсан авч Наадмын дараа болгож хойшлуулжээ. "Бараг сар гаруйн хугацааны өмнө УИХ-д өргөн барьсан дээрх хуулийг хэлэлцэх боломж, хугацаа байсан ч тэгсэнгүй" хэмээн Хууль, зүй дотоод хэргийн дэд сайд В.Удвал дээрх хурал дээр хэлж байсан юм. МХБ, СЗХ гэх мэт холбогдох байгууллагуудын зүгээс энэ оны долдугаар сард буюу сонгуулийн дараа УИХ-ын хаалтын хурал дээр тус хуулийг хэлэлцэх болов уу гэсэн горгдлого тээн, харж байна.

Тухайн хуульд 50-иас дээш хувийн өөрчлөлт орвол шинэчилсэн найруулга гэж нэрийддэг учиртай. Тиймээс 2009 оноос эхтэй Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон бусад холбогдох хууль, журмуудын тусламжтайгаар Монголын хөрөнгийн зах зээл үндсэндээ төрөл арилжиж байгаа гэж хэлж болох нь. Тухайлбал, Монголын компани давхар компани байгуулахгүйгээр олон улсын биржид хувьцаагаа гаргах, кастодиан, депозитари банк гээд өнөөгийн хуульд байхгүй олон шинэ зохицуулалт орж байна.

Түүнчлэн энэ завшааныг ашиглан "Эрдэнэс Тавантолгой" компани олон улсын бирждээр IPO гаргах боломжтой болох юм. "Бид зөвхөн гадаадын томоохон хөрөнгө оруулагчдад зориулж үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх талаар яриагүй. Монголын үнэт цаасны зах зээлийг үндэсний томоохон хөрөнгө оруулагчид бий болгох ёстой. Тэд хэн байх вэ гэвэл хувийн тэтгэврийн сангийн тогтолцоо буюу сүлжээ юм" хэмээн МХБ-ийн ТУЗ-ын дарга М.Болд хэлсэн. Ингээд ирэхээр Үнэт цаасны тухай хуулийн зэрэгцээ ирээдүйн хувийн тэтгэврийн сангийн зохицуулалт мөн бусад аж ахуйн нэгжүүдийг ямар хэлбэрээр үнэт цаасны зах зээлд оролцуулж болох талаарх шинэ зохицуулалтууд гарч ирэх ёстой болж байгаа юм.

Мөн Үнэт цаасны тухай хуульд олон том зарчмын өөрчлөлт орсны нэг нь дотоод мэдээллийг ашиглаж зах зээлд хохирол учруулсан нь тогтоогдвол иргэний хуулийн дагуу тухайн брокер дилерт хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хэдэн зуу

дахин нэмэгдүүлсэн хэмжээгээр торгууль ногдуулж бүр цаашлаад эрүүгийн хуулиар шийдэгдэх дээрээ ч тулах гэнэ.

Харин тус хурал дээр урилгаар хүрэлцэн ирсэн "Хоган Ловэллс" олон улсын хуулийн фирмийн Хонконг дахь салбарын хуульч Жэми Барр "Дэлхийн жишигт нийцсэн зах зээлтэй болохыг чармайж байгаа нь тун зөв чиг хандлага хэдий ч нэг талаар Лондоны хөрөнгийн бирж дээр мөрдөгдөж буй дүрэм журмууд хөгжлийн өнөөгийн түвшинд явж байгаа Монголын хөрөнгийн биржид яв цав тохирох уу эсвэл хэтэрхий хэцүү төвөгтэй болгох уу гэдэг асуудал байна" хэмээн хөндлөнгийн хүний хувьд өөрийн саналаа хэлсэн билээ.

Энэ 1.5 сая хавтгай дөрвөлжин талбай дээр зөвхөн Монголын гурван сая иргэн бус долоон тэрбум хүн өрсөлдөхөөр зэхэж байна. Хоёр төрийн эргэлтэд хэлмэгдсэн хөрөнгийн зах зээлийн

эрх зүйн шинэчлэл бол хөрөнгийн зах зээл хэмээх байшингийн суурь нь билээ. Оюутолгой, Тавантолгой, Төмөртэй гэх мэт 15 стратегийн орд ар араасаа гарч ирнэ. Энэ бол олон нийтийнх болохоос төрийн өмч биш. Хувьцааны зах зээл дэх өмчлөлийн соёлыг иргэдийн дунд анхнаас нь зөв хэвшүүлэх үүднээс энэхүү олон улсын стандартыг хэрэгжүүлэхээр хичээж байна" хэмээн М.Болд дарга онцлон хэлж байлаа.

Олон улсын хөрөнгө оруулагчдад танил дүрэм журамтай байхаас гадна энгийн хялбар байх нь чухал юм гэдгийг дээрх хурлын оролцогчид онцолсон. Дутуу хөтүү, мэдэхгүй чадахгүй зүйл цөөнгүй байгаа ч техник, технологи болон төлбөр тооцооны систем бусад холбогдох дүрэм журмуудыг шат шатандаа чадахаараа өөрчилжээ. Одоо хууль тогтоогчдын зүгээс хөрөнгийн зах зээлийн шинэ хөгжилд оруулах хувь нэмэр их аж. ■

ДААТГАЛЫН БИЗНЕС

ЭРСДЭЛД БАРИХ "ИД ШИД"

Амьдралын болоод урт хугацааны даатгал нь хүний амь нас эрүүл мэндийг тав ба түүнээс дээш жилээр хамгаалалтад авах буюу санхүүгийн эрсдэлийг даатгах явдал юм. Магадгүй бидэнд хөдөлмөрийн чадвараа алдах, хүнд өвчин тусах эрсдэл тохиолдож болно. Энэ үед танд болон танай гэр бүлд санхүүгийн эрсдэлийг дагуулах нь гарцаагүй.

Э.ЗОРИГТ

Хүний амьдрал тааварлашгүй сонин содон зүйлээр дүүрэн. Аз жаргал, гуниг гутралын аль нь хэзээ, хаана тохиолдохыг хэн мэдэх билээ. Гэхдээ хүн бүр тайван тав тухтай амьдрахыг л хүсдэг. Жаргалтай амьдрахын тулд л хүн төрөлхтөн олон төрлийн арга зам хайсаар ирсэн. Гэхдээ амьдралд тохиолдох эрсдэлүүд буураагүйгээр зогсохгүй зарим талаар нэмэгдсэн ч гэж хэлж болох юм. Тэгвэл эрсдэл гэж юу вэ? ►►

► Ингэх гээд байсан юм аа

Эрсдэл гэдгийг хүн бүр өөр өөрийнхөөрөө хэдэн арван янзаар тайлбарлах байх. Гэхдээ бүгдээрээ шинжлэх ухааны үндэслэлтэй илүү олон хүн хүлээн зөвшөөрсөн ганц тайлбарыг энд авч үзье. Эрсдэл гэдгийг эдийн засгийн болоод бусад холбогдох шинжлэх ухаанд гэнэтийн хохирол учруулж болзошгүй үйл явдал гэдэг байна. Угаас гэнэт учирсан үйл явдлууд л бидний амьдралд тааварлашгүй нөхцөл байдлыг авчирдаг. Энэ үед бид биеийн болон сэтгэлийн, хөрөнгийн болоод эд материалын хохирол амсдаг. Харин дараа нь “Яг ингэх гээд байсан юм аа” гээд харамсдаг нь нууц биш...

Өнгөрсөн үед хүмүүс эрсдэл гэгч хэцүү асуудлаас зугтахын тулд бурхан гэгч биегүй орон зайд шүтэж, залбирдаг байсан. Одоо ч гэсэн бурханд бүх эрсдэлийг даатгадаг хүмүүс бий. Хэдийгээр бурхан гэгч биегүй орон зай бидний сэтгэлийг амирлуулах хэдий ч амьдралд тохиолдох асуудал мундахгүй. Тиймээс хүн төрөлхтөн эрсдэл хэзээ ч алга болохгүй гэдэгтэй санал нийлсэн. Харин эрсдэл хэзээ нэгэн цагт учирвал өөрийгөө хамгаалж, хариу үйлдэл үзүүлж болдог гэдгийг ухаарчээ. Яг л бороонд шүхэр барьдаг шиг.

Бурхад ба эдийн засагчид

Эрсдэл хэзээ ч алга болохгүй харин нэг эрсдэлийг нөгөөгөөр сольж, учирвал гарз хохирол багатай өнгөрч болох юм гэдгийг “сэргэлэн толгойтой” эдийн засагчид олж харжээ. Тэр тусмаа өвчин, зовлон, осол аваараас эхлээд бүх л зүйл мөнгөтэй холбоотой болсон өнөө үед эрсдэлээс зугатах, хүлээх, бууруулах, шилжүүлэх гэх мэт аргаар удирдаж болно гэдгийг ч тодорхойлсон байна. Гэхдээ энэ олон арга, шинжлэх ухааны тайлбарыг хүн бүр цээжилж, цаашлаад амьдралдаа хэрэгжүүлж чадах бил үү. Тэгвэл яах вэ. Хариулт нь маш энгийн. Та зүгээр л даатгуулчих. Танд тохиолдох түмэн янзын эрсдэлийг даатгалын компаниуд тооцоолж, судлаад авах арга хэмжээг нь олчихсон байгаа. Энгийнээр хэлэхэд өнөө үед эрсдэлийг бурхад биш, эдийн засагчид тэр дундаа даатгалын компаниуд бууруулдаг болсон. Гэхдээ Та өөрт хэрэгтэй зөв даатгалыг сонгох нь чухал талаар мэрэгжилтнүүд анхааруулж байна.

Даатгал гэж юу вэ

Даатгал бол эрсдэлийг үнэлж, эрсдэлийг өөртөө шилжүүлэн авдаг үйлчилгээ. Дээр хэлсэнчлэн бүх зүйл мөнгөөр хэмжигддэг болсон энэ ертөнцөд Та даатгуулснаар аливаа эрсдэл учирахад бий болох санхүүгийн алдагдлыг бүрэн эсвэл томоохон хувийг даатгалын компаниар барагдуулах боломжтой болох юм. Энэ салбар дэлхий дахинаа хэр зэрэг хөгжсөн гэдгийг харуулах энгийн жишээ дурдъя. Холливудын жүжигчин, дуучин Jennifer Lopez-ыг танихгүй хүн ховор. Мөн түүнийг өгзгөө 300 сая ам.доллараар даатгуулсан гэдэг мэдээлэл

бий. Тэр яагаад даатгуулсан бэ?

Гаднын ихэнх оронд хүмүүс үнэ цэнэтэй бүхнээ даатгуулдаг учиртай. Өөрийн амь наснаас эхлээд, үр хүүхдийнхээ ирээдүйн боловсрол, эрүүл мэнд гээд юу дуртайгаа Та даатгуулж болно. Учир нь, хүний хорвоод зовлон жаргал ээлжилдгээс хойш ирээдүйд Та ямар ч байдалд ороо билээ. Тиймээс өөрийн хамгийн үнэ цэнэтэй гэж бодсон зүйлээ хамгаалах хэрэгтэй. Энэ л шаардлагын дагуу гаднынхан даатгуулдаг.

Яг одоо

Харин өдгөө Монголд даатгалын салбарын хөгжил хэр байна вэ. Энэ салбарт ажилладаг мэрэгжилтнүүдийн олонх нь даатгалын салбарын хөгжлийг тааруу гэж дүгнэдэг. Тухайбал, ард иргэдийн даатгалд итгэх итгэл хомс, өрсөлдөөн бага, хууль эрх зүйн орчин тааруу гээд дурьдаад байвал муу зүйл олон. Гэхдээ л манайд ердийн даатгалын 16, урт хугацааны даатгалын “Нэйшнл лайф” гэх ганц компани тус тус үйл ажиллагаа явуулж байна. Ердийн даатгал болон урт хугацааны даатгалын ялгааг доорх хүснэгтээс харна уу.

| Урт хугацаат /амьдралын/ даатгал | Ердийн даатгал |
|---|---|
| Хүний амь насыг өвчин болон гэнэтийн ослоос даатгадаг | Зөвхөн гэнэтийн ослоос даатгадаг |
| Хамгаалалт нь тодорхой байдаг | Урьдчилан тааварлах боломжгүй |
| Гэрээг урт хугацаагаар байгуулдаг | Гэрээг 12 сараас хэтрэхгүй хугацаагаар байгуулдаг |
| Нөхөн төлбөрийг даатгалын үнэлгээгээр олгодог | Нөхөн төлбөрийг учирсан хохирлын хэмжээгээр олгодог |
| Хөрөнгө оруулалтын хэрэгсэл болдог | Ашгийн оролцоогүй |
| Нэмэгдэл шагнал олгодог | Шагнал, бонус олгодоггүй |
| Хамгаалалт дэлхий дахинд үйлчилдэг | Зөвхөн Монгол Улсад |
| 24 цагийн турш байнгын хамгаалалттай | Зөвхөн ажлын цагаар, аяллаар явахад гэх мэтээр хязгаарладаг |

Эндээс харахад манай улсын хувьд ердийн даатгал бага зэрэг ч хөгжсөн байна. Харин урт хугацааны даатгалын төрөлд ганцхан компани ажиллаж байгаагаас харахад хөгжөөгүй гэхэд хилсдэхгүй юм. Тиймээс урт хугацааны даатгалын талаар цухас дурдъя. Амьдралын болоод урт хугацааны даатгал нь хүний амь нас эрүүл мэндийг тав ба түүнээс дээш жилээр хамгаалалтад авах буюу санхүүгийн эрсдэлийг даатгах явдал юм. Магадгүй бидэнд хөдөлмөрийн чадвараа алдах, хүнд өвчин тусах эрсдэл тохиолдож болзошгүй. Энэ үед танд болон танай гэр бүлд санхүүгийн эрсдэлийг дагуулах нь гарцаагүй. Тэгвэл тэр эрсдэлийг Та хэрхэн даван туулах вэ. Магадгүй хэн нэгнээс мөнгө зээлэх, ахан дүүсээсээ хандив цуглуулах гэх мэт арга хэмжээ авч магадгүй. Магадгүй ч биш, манай ►

▶ монголчуудын өнөөгийн төрх ийм л байгаа. Харин Та урт хугацааны даатгалд хамрагдсан бол нөхөн төлбөр авах замаар санхүүгийн бэрхшээлээ төвөггүй шийдэх юм.

Нөхөн төлбөр хийгдэх арга зам

“Нэйшнл лайф” урт хугацааны даатгалын компанийн нөхөн төлбөр хийх механизм

Даатгуулагч эрсдэл тохиолдсноос хойш 72 цагийн дотор мэдэгдэнэ

Нөхөн төлбөр хүссэн өргөдөл бичнэ

Холбогдох материалуудаа бүрдүүлнэ

Даатгагч материалыг хүлээн авсанаас хойш тав хоногийн дотор хариу мэдэгдэнэ

Даатгуулагч нөхөн төлбөр хүлээн авна

Дэлхийн томоохон даатгалын компаниуд ч мөн ялгаагүй ийм маягаар нөхөн төлбөр олгодог байна. Харин нөхөн төлбөрийн үнэлгээг янз бүрээр хийдэг. Учир нь, Та даатгалын компанитай хийсэн гэрээ, таны амь нас эрүүл мэндээ хэрхэн үнэлсэн зэргээс шалтгаалж учирсан хохирлыг барагдуулна. Мөн сар тутам даатгалын компанид төлөх ёстой хураамжаа тогтмол төлж байсан бол танд нөхөн төлбөр ямар нэг бэрхшээлгүй олгогдох. Тухайлбал, даатгуулагч нь 23 настай бөгөөд өөрийн амь насаа 50 сая төгрөгөөр даатгуулсан бол жилд 350,000 төгрөгийг даатгалын компанид төлнө. Ингэснээр даатгуулагчийн амь насанд эрсдэл учирвал гэр бүлийнхэнд нь нөхөн олговрыг олгодог байна. Төлбөрийг хохирол учирсан талд гэрээнд заасан хугацаанд тогтмол олгодог аж. Урт хугацааны даатгалын нэг төрөл болох тэтгэврийн даатгалыг хүмүүс ихэд сонирхдог. Өмнөх 23 настай иргэний жишээн дээр тайлбарлахад даатгуулагч өтөл насандаа 700 мянган төгрөгийн тэтгэвэр авахыг хүсвэл сард 25,000 төгрөгийн хураамж төлөх юм. Та даатгуулсан хугацаандаа ямар нэг нөхөн төлбөр аваагүй бол таны даатгалын компанид төлсөн мөнгөн дүнг гэрээ дуусах үед буцаан өгнө. Энэ бол урт хугацааны даатгалын нэг том давуу тал ажээ.

Хүн өөрийн аз жаргалтай амьдралын төлөөх сонголтыг мөнгөнөөс хамаарах дарамтгүйгээр хийхийг зорьдог. Үүний тулд бид их хэмжээний мөнгө хуримтлуулах хэрэгтэй боловч ингэх боломж хүн бүрт олдоод байдаггүй. Харин даатгалын систем нь бага зардлаар амьдралд тохиолдох эрсдэлийг бууруулж, сэтгэл тайван байх боломжийг олгодог талаар “Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн дэд захирал Д.Ганбаатар хэлсэн юм. Тиймээс Та санхүүгийн асуудлаа шийдвэрлэх гэж цаг алдахыг хүсэхгүй байгаа бол даатгалыг чухалчлах хэрэгтэй. Угаас даатгал гэдэг даатгуулагч дээр тогтдог бизнес учир Та даатгалд хэр итгэнэ тэр чинээгээр “ид шидтэй” болдог зах зээлийн жамтай.

Ч.ОТГОЧУЛУУГИЙН БУЛАН

КАПИТАЛИЗМ БА ТҮҮНИЙ ТУЛГЫН ГУРВАН ЧУЛУУ

Коммунист, социалист, феодал болон боолын нийгмүүдэд дундаж давхаргаар овоглогчдын хувьд хувийн өмч, түүний баталгаа гэж байсангүй. Боолын нийгэмд боолууд үхтэлээ ажиллаад юу ч олж долоохгүй, амьд явах баталгаагүй. Феодалын нийгэмд хамжлага ард эзэн ноёныхоо газрыг хагалж, малыг нь хариулж өгнө. Үүнийхээ хариуд өөрсдөө өлбөрөхгүй байхад л хангалттай байв. Социализмын үед хувийн өмчийг хориглох бөгөөд хариуцаж буй улсын өмчөө дутаавал хариуцлага хүлээнэ. Харин капитализмд онолын хувьд бүгд тэгш эрхтэй. Баяжих, шударгаар хөрөнгө хуримтлуулах эрх нь ч нээлттэй. Хувийн өмч капитализмын хөдөлгөгч хүч билээ. Хувийн өмч гэж юу вэ? Эдийн засагчдын хувьд Газар, Хөдөлмөр, Капитал гурав юм. Эдгээрийг онолын хэлээр үйлдвэрлэлийн хүчин зүйлс гэдэг. Эдгээр үйлдвэрлэлийн хүчин зүйлс нь л капитализмыг капитализм болгожээ. Капитализмын өмнөх үед үйлдвэрлэлийн хүчин зүйлс байсангүй. Мэдээж тэр үед хүн, газар, эд хэрэгсэл байсан. Гэхдээ тэднийг худалдаж болдоггүй байв. Газар, хөдөлмөр, капитал нь албадлага, эрх мэдлийн илэрхийлэл байв. Үнэлгээгүй ажил, хөлслүүлээгүй газар, ашиг авчирдаггүй капитал, эдгээр нь хэрхэн үйлдвэрлэлийн хүчин зүйлс болж хувирав.

1420-иод он буюу Европын сэргэн мандлын үед “мөнгө хүүтэй зээлэх нь нүгэл” гэж үздэг байсан шашны нөлөөнөөс ангижирч эхэлсэн цагаас мөнгө өөрөө капитал болж хувирчээ. Орчин үеийн банк санхүүгийн байгууллагын үүсэл Италиас гаралтай гэж үздэг.

1530-аад он хүртэл Францын газрын эзэд, феодал анги тун чиг баян тансаг амьдарч байлаа. Гэвч Америкийг нээснээс хойш алтны наймаачид хязгааргүй хурдан баяжиж эхлэв. Алт ихсэхийн хэрээр юмны үнэ өсч байлаа. Феодалуудын хувьд албатуудаас авах татвар нь 10 кг будаа, 20 ширхэг өндөг гэх зэргээр хатуу заагдсан байж. Гэтэл бусад тансаг хэрэглээний зүйлс үнэд орж эхэлжээ. Ингээд феодалууд олноороо ядуурч, газраа худалдаж эхлэв. Баян наймаачид газрыг ▶

Монголчуудын хувьд бид нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг байгуулна гэдгээ үндсэн хуульдаа тунхагласан улс. Эдийн засгийн хэлээр нийгмийн халамж сайтай капиталист тогтолцоо гэж бууна.



Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн захирал Ч.Отгочулуу

► өмчлөх болсноор газар хэмээх үйлдвэрлэлийн хүчин зүйл үүсчээ.

1820-иод оны үед олноороо дампуурах болсон Английн феодал, газрын эзэд нь хамжлага ард, тариачдаа хөөж явуулжээ. Газар тариалан эрхлэхийн оронд малын бэлчээр байгуулж, хонь үржүүлж ноосоор нь баяжих хөдөлгөөн өрнөөд байв. Амьжиргааны эх үүсвэрээ алдсан тариачид өлбөрөхгүйн эрхэнд хот газар бараадан өөрсдийнхөө ажил хийх чадвараа “худалдах”-аас өөр арга үлдсэнгүй. Ингэж Хөдөлмөр хэмээх үйлдвэрлэлийн хүчин зүйл буюу капитализмын нэг тулгын чулуу болсон. Капитализмын товч түүх гэвэл энэ. Харин капитализмыг судлах, ойлгох талаар Адам Смит, Карл Маркс, Жон Майнард Кейнс нар онцгой хувь нэмэр оруулсан байдаг.

1770-аад онд Ижил мөрнөөс хөдөлсөн Торгууд тэргүүтэй монголчууд уугуул нутагтаа ирж байсан тэр цагт, Адам Смит хэмээх гарамгай сэтгэгч тухайн үедээ ноёлж байсан төрийн хүчтэй зохицуулалт бүхий худалдаанд түшиглэсэн Меркантилизмын үзлийг шүүмжилж “чөлөөт зах зээл бол үндэсний баялгийн үндэс” гэж тунхаглаж байлаа. Зах зээл өөрийн дотоод жам ёсоор хөгжих ёстой. Иймд төрийн оролцоог аль болох бага байлгах учиртай гэж үзжээ.

1870-аад онд Манжийн тусгаарлах бодлого хийгээд Түвдийн шашны бүүвэйлэлд монголчуудыг нойрсож байх үед Маркс хэмээх Герман эр капитализм нь ажилчин ангийг сорж мөлжиж байгаагийнхаа хүчинд л тогтож байна, гэвч энэ нь яваандаа хямарсаар мөхөх тавилантай гэж үзжээ. Иймд, Капитализм нь нийгмийг мөхөөхөөс өмнө ажилчин анги санаачлагийг гартаа авч, хувийн өмчгүй коммунист нийгэм байгуулах учиртай байв.

1930-аад онд монголчууд Коминтерний удирдлага дор Марксист улс байгуулах гэж байсан тэр цагт Кейнс “төрийн зохицуулалт бүхий” капитализмын тухай бүтээлээ туурвиж байж. Өмнөх хоёроосоо ялгаатай нь тэрбээр капитализмыг хэт гоёчлон магтсангүй, бас хэт

харлуулан шүүмжилсэнгүй. Харин гол согогыг нь олж харж засах талаас нь анхаарсан байна.

Капитализмд ирээдүй бий юү? Энэ нь хүн төрөлхтний ирээдүй болж чадах уу? Энэ асуулт өнөөгийн эдийн засагчид, улстөрчид, сэтгэгчдийн толгойг зовоосон хэвээр. Ямартаа ч үндэстэн дамнасан том компаниуд олшрох төлөвтэй. Үүний хажуугаар экологийн хямрал, баян хоосны ялгаа гэх мэт сөрөг үзэгдлүүд ч бий болов. Капитализм нь хүн төрөлхтний төгс ирээдүй биш. Гэхдээ амь зуух гол арга хэвээр байх нь ойлгомжтой.

Монголчуудын хувьд бид нийгмийн баримжаатай зах зээлийн эдийн засаг байгуулна гэдгээ үндсэн хуульдаа тунхагласан улс. Эдийн засгийн хэлээр нийгмийн халамж сайтай капиталист тогтолцоо гэж бууна. Гэвч Монголд газар, хөдөлмөр, капитал гурав чөлөөтэй арилжаалагдаж, бас иргэдийн өмчлөх эрх бүрэн хамгаалагдаж чадаж байна уу? Жирийн иргэдийн хувьд капитализмын тулгын гурван чулуу бий болж чадсан уу? Монголд айлчлаад буцсан Эрнандо де Сотогийн илтгэлийг сонссоны дараа би “Үгүй юм байна” гэж хариулсан билээ. Газар өмчлөх нь жирийн иргэдийн хувьд хол хөндий бөгөөд, эдийн засгийн эргэлтэд орох тухайд зөвхөн эрх мэдэлтэн, баячуудын хооронд үүсдэг харилцаа гэж ойлгодог болж. Засгийн газар жил бүр олон мянган ажлын байр бий болголоо гэдэг ч залуус Хөдөлмөр гэдэг капиталаа энд биш харин Солонгос эвсэл Америкт борлуулах хүсэлтэй. Дундаж иргэний хувьд капитал (хашаа, байр, жижиг бизнес)-ийг бүртгэх, баталгаажуулах, зээлийн барьцаа болгох замаар санхүүгийн эргэлтэд оруулах эрх чөлөө хомс хэвээр байна.

Монгол маягийн капиталист нийгэмд хүрэх замд дундаж иргэдээ өмчтэй болгодог, тэрнийг нь хамгаалдаг, эргэлтэд оруулахад нь дэмждэг, арилждаг худалддаг зах зээлийг шударга бус өрсөлдөөнөөс хамгаалж чаддаг Төрийн тогтолцоо хэрэгтэй. Ийм төрийн төлөө зүтгэж чаддаг улстөрчид ч энэ цаг үеийн гол шаардлага билээ. ■



АЗИЙН ХӨГЖИЖ БУЙ ОРНУУД ДАХЬ ӨСӨН НЭМЭГДЭЖ БАЙГАА ТЭГШ БУС БАЙДАЛТАЙ ТЭМЦЭХ НЬ

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь олон талт олон улсын хөгжлийн банк бөгөөд 67 гишүүнтэйгээс 48 нь тус бүсийнх, 19 нь дэлхийн бусад бүс нутгийнх юм.



ЯАН ХАНСЭН
/АХБ-ны Суурин
төлөөлөгчийн газрын
ахлах эдийн засагч/

Энэ нийтлэл нь Азийн хөгжиж буй орнууд дахь тэгш бус байдлын хандлагыг судлан, дүн шинжилгээ хийсэн хоёр нийтлэлийн эхнийх нь болно. Энэхүү нийтлэлд тэгш бус байдлын талаарх зарим тоон үзүүлэлт болон тэгш бус байдал, институц, эдийн засгийн өсөлт гэсэн гурван хүчин зүйлийн харилцан хамаарал, Азийн хөгжиж буй орнууд дахь өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлын эх үүсвэр, арга хэлбэрт хийсэн дүн шинжилгээ орсон юм. Харин хоёр дахь нийтлэлд бүх иргэдэд ашиг тус нь хүртсэн, хүртээмжтэй өсөлтийг дэмжих бодлогыг боловсруулан санал болгоно¹.

Азийн² хөгжиж буй орнууд өнгөрсөн хорин жилийн хугацаанд бусад бүс нутгийн оронтой харьцуулахад эдийн засаг нь илүү хурдан өсөлттэй, ядуурлыг ихээхэн бууруулж чадсан билээ. 1990-ээс 2010 оны хооронд Азийн хөгжиж буй орнуудын ДНБ-ий жилийн дундаж өсөлт 2005 оны худалдан авах чадварын паритетаар долоон хувьд хүрчээ. Ядуурлын босго болох өдрийн 1.25 ам.доллараар амь зуудаг хүн амын тоо 1990 онд 51.8 хувь байсан бол 2008 онд 20.8 хувь хүртэл буурч, нийт 714 сая хүн ядуурлаас гарсан байна.

Гэвч эдийн засаг ийнхүү өссөн, ядуурал буурсан зэрэг амжилтыг даган олон оронд орлогын тэгш бус байдал нэмэгдсэн байна. Статистик мэдээллийг нь 1990-2000 оны хооронд харьцуулах боломжтой 28 улс байгаагаас 11 нь буюу 2010 оны байдлаар Азийн хөгжиж буй орнуудын нийт хүн амын 82 хувь нь амьдарч байсан улсуудад нэг хүнд ногдох орлого, зарлагын тэгш бус байдал Жини коэффициентийн³ дагуу нэмэгдсэн байна. Тухайлбал, Жини коэффициент БНХАУ-д 32-43, Энэтхэг улсад 33-37, Индонезид 29-39 болж тус тус үзүүлэлт нь буурсан байна. Тус коэффициент 40 ба түүнээс дээш байвал “тэгш бус байдал өндөр” хэмээн үздэг.

Түүхэн замналаас харахад хөгжиж буй Ази нь бусад бүс нутаг тухайлбал, Латин Америктай харьцуулахад, тэгш бус байдлын түвшин харьцангуй доогуур байсаар ирсэн юм. Нөгөө талаас, Латин Америк дахь тэгш бус байдал хөгжиж буй Азийнхаас өндөр хэвээр байгаа хэдий ч, өнгөрсөн хорин жилийн хугацаанд Латин Америкийн ихэнх онд орлогын тэгш бус байдал буурсан байна.

Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлт, хүртээмжтэй өсөлт болон тэгш боломж

Ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлт ба хүртээмжтэй өсөлт нь хоорондоо зарчмын хувьд томоохон ялгаатай юм. Эдийн засгийн өсөлт нь ядуурлыг бууруулж чадсан бол ядуурлыг бууруулахад чиглэсэн өсөлт хэмээн тодорхойлдог. Гэтэл хүртээмжтэй өсөлтийн үр шим, орлого нь нийгмийн бүхий л бүлгүүдэд жигд хүрч, тэгш бус байдлыг бий болгодоггүй юм.

Тэгш бус боломжийг орлогын тэгш бус байдлаас ялгах хэрэгтэй юм. Тэгш бус боломж гэдэг нь бүх хүмүүс эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, ашиг шимийг нь тэгш хүртэх боломжтой байхыг хэлнэ. Тэгш бус боломж нь хүйс, яс үндэс, төрсөн газар эсвэл эцэг эхийн орлого, боловсрол гэх мэт тухайн хүний хувийн нөхцөл байдал буюу түүний өөрөө хянах боломжгүй нөхцөлөөс үүдэн бий болдог. Бага орлоготой цөөнгүй оронд хүн амын олонхийн хувьд боломж, бололцоо ихээхэн хязгаарлагдмал байдалтай байх нь олонтаа тохиолддог. Нэн ялангуяа хүүхдүүдийн хувьд, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж нь тэдний хяналтаас гадуур байдаг учир энэ тал дээр тэгш бус боломжтой байдаг. Нөгөө талаас, хөдөлмөрийн зах зээлд эсвэл боловсролын

¹ Энэхүү хоёр нийтлэлд Азийн Хөгжлийн Төлөв (АХТ) 2012 тайлангийн тусгай сэдвийг хураангуйлсан юм. (<http://www.adb.org/publications/asian-development-outlook-2012-confronting-rising-inequality-asia>).

АХБ-ны тэргүүлэх судалгаа, эдийн засгийн жил тутмын хэвлэл болох АХТ тайлан нь өнгөрсөн жилийн эдийн засгийн гүйцэтгэлд цогц дүн шинжилгээ хийж, ирэх хоёр жилийн төсөөллийг Азийн хөгжиж буй орнууд болох Ази, Номхон далайн 45 улс орны хувьд гаргадаг юм.

² “Азийн хөгжиж буй орнууд” бүлэгт АХБ-ны гишүүн Зүүн, Зүүн өмнөд, Өмнөд, Төв, Баруун Азийн болон Номхон далайн 44 улс орныг хамруулж байгаа болно.

³ Жини коэффициент нь тэгш бус байдлыг тэг буюу туйлын тэгш байдлаас нэг буюу (эсвэл 100) туйлын тэгш бус байдал хүртэл тэгш бус байдлыг хэмждэг түгээмэл хэмжүүр юм.

▶ ямар сонголт хийх нь хувь хүнээс өөрөөс нь шалтгаалах бөгөөд мөн л ирээдүйд нь нөлөөлнө. Тэгш бус боломж нь хөгжиж буй Азийн орнуудад орлогын тэгш бус байдлыг нэмэгдүүлж буй томоохон хүчин зүйл болоод байна. Үүгээр ч барахгүй, тэгш бус байдлын эдгээр хоёр төрөл нь тэгш бус боломж, орлогын ялгаатай байдал, хувь хүн, өрхүүдийн боломж, бололцооны ялгаатай байдал нь нэг нэгнийгээ бий болгох битүү цагираг үүсгэх нь ч бий.

Нөхцөл байдлаас үүдэн бий болсон тэгш бус байдлыг тухайн хувь хүн хянаж чадахгүй учир ёс зүйн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй. Харин эсрэгээрээ ямар нэгэн хүчин чармайлт гаргасны үр дүнд бий болсон тэгш бус байдал нь ёс зүйн хувьд хүлээн зөвшөөрөх боломжтой бөгөөд тэр ч бүү хэл тухайн аж ахуйн нэгжийг урамшуулснаар бүтээмж, өсөлтийг өдөөдөг. Ийм учраас тэгш бус боломжийг бууруулах чиглэлээр бодлогын арга хэмжээ авах нь илүү чухал байна. Тухайлбал, эцэг эхийн орлогын тэгш бус байдал нь хүүхдүүдийнх нь хувьд тэгш бус боломжийг бий болгодог тул үүнийг нийгмийн бүх давхаргад боловсрол, эрүүл мэнд зэрэг төрийн үйлчилгээ, зах зээлд нэвтрэх тэгш боломжоор хангахад чиглэсэн тодорхой арга хэмжээ аван шийдвэрлэх шаардлагатай юм. Энэ утгаараа тэгш бус боломж, орлогын ялгаатай байдал нэмэгдэж буйтай тэмцэхэд төрийн оролцоо чухлыг онцолж байна.

Тэгш бус байдал, институт ба эдийн засгийн өсөлт

Тэгш бус байдал нь өөрөө хөгжлийн үйл явцын нэгэн чухал асуудал болдгийн дээр ирээдүйн өсөлт, ядуурлыг бууруулахад нөлөөлдөг билээ. Нэгт, баялаг, орлогын тэгш бус байдал нь хүний нөөцийн зохисгүй хуваарилалтыг бий болгодог. Учир нь хөрөнгө, орлого багатай хүмүүс хүний капиталд хөрөнгө оруулах, мөн хөрөнгө, орлогыг бий болгох үйл ажиллагаанд оролцож чаддаггүйн улмаас ядуу хэвээр үлдэнэ. Хоёрт, тэгш бус байдал нь нийгмийн цогц байдалд сөрөг нөлөө үзүүлнэ. Өөрөөр хэлбэл, өсөн нэмэгдэх тэгш бус байдал нь орлогын хоёр туйлд буй хүн амын тоог нэмэгдүүлснээр тогтвортой байдал, өсөлтийн үндэс хэмээн тооцогддог нийгмийн дундаж давхаргыг үгүй болгоно. Нийгмийн дундаж анги өсөлтөд оролцож, ашиг тусыг нь хүртсэнээр уг өсөлт илүү тогтвортой байхын зэрэгцээ хялбар аргаар хөлжих, авлига зэргээр өсөлтийн үр шим цөөн хүний гарт төвлөрөхөөс сэргийлэх боломжтой юм. Гуравт, тэгш бус байдал нь институцийн үйл ажиллагааны чанар чансаатай холбоотой гэдэгтэй судлаачид санал нийлээд байгаа бөгөөд, үүнд, улс төр, институцийн тогтвортой ажиллагаа, өмчийн эрхийн асуудал зэрэг багтсан болно. Мөн тэгш бус байдал нь гэмт хэргийн нөхцөл байдал, нийгэм дэх хүчирхийлэлд нөлөөлж, улс орны хөрөнгө оруулалтын орчинд нөлөө үзүүлдэг билээ.

Эцэст нь тэгш бус байдал өсөн нэмэгдсэнээр нийгмээс популист бодлого шаардах, дэмжих нь ихсэж, улс төрийн тавцанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Улс төрийн ийм үйл явц нь богино хугацаанд орлого багатай нийгмийн бүлэгт дэмжлэг үзүүлж байгаа мэт боловч урт хугацаандаа үр ашигтай үйл ажиллагаа, өсөлтөд сөргөөр нөлөөлдөг. Мөн нийгмийн эмзэг бүлгээс популист бодлого хэрэгжүүлэх

шахалт шаардлагыг үзүүлснээр нийгмийн элит хэсэг нь авлигыг өөхшүүлэх талтай болох бөгөөд энэ нь мөн л өсөлтөд сөргөөр нөлөөлнө.

Өсөн нэмэгдэж буй тэгш бус байдлын эх үүсвэр, арга барил

Технологийн дэвшил, даярчлал, зах зээлийг дэмжсэн шинэчлэл зэрэг нь өнгөрсөн хорин жилийн Азийн хөгжиж буй орнуудын түргэн өсөлтийн эх үүсвэр байсан юм. Эдгээр хүчин зүйл нь эдийн засгийг хөгжин цэцэглүүлэхийн зэрэгцээ хөрөнгө, ажиллах хүчний үр өгөөжийн өөрчлөлт, ур чадвартай, чадваргүй ажиллагсдын орлогын хуваарилалт, хот, далайн эрэг болон хөдөө, далайгаас алслагдсан бүс дэх орлогын ялгааг нэмэгдүүлэх зэргээр тэгш бус байдал нэмэгдэхэд хүргэсэн болно. Энэ бүх өөрчлөлтүүд нь бүс нутгийн олон орны тэгш бус байдал нэмэгдсэн учир шалтгааныг тайлбарлаж байгаа юм.

Технологийн өөрчлөлт, ялангуяа мэдээлэл харилцаа холбоонд гарсан хөгжил дэвшилтэй уялдан капиталын бүтээмж хөдөлмөрийнхөөс, түүний дотор ур чадвар, боловсрол багатай ажиллагсдын бүтээмжээс харьцангуй нэмэгдсэн юм. Үүний үр дүнд эдийн засгийн өсөлт нь хөдөлмөрт гэхээс илүү капиталд суурилах болсон бөгөөд үйлдвэрлэлийн өсөлтийн хувь хэмжээ бүрт харьцах хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийн хувь хэмжээ урьдынхаас буурч ирсэн юм. Энэ үзэгдлийг “ажилгүй өсөлт” хэмээн тодорхойлох болсон. Өсөлт дэх хөдөлмөрийн хувь буурснаар үндэсний орлого дахь хөдөлмөрөөс үүссэн орлогын хувь буурч харин хөрөнгө эзэмшигчдийн орлогын хэмжээ нэмэгдсэн юм. Азийн хөгжиж буй хэд хэдэн оронд 1990 оны дунд үеэс 2000 оны дунд үе хүртэл хөдөлмөрөөс үүссэн орлогын хувь хэмжээ буурсан юм. Ажиллагсдын орлогын хэмжээ буурч, хөрөнгөтний орлогын хэмжээ нэмэгдэх нь тэгш бус байдлыг нэмэгдүүлж байгаа юм. Учир нь хөрөнгийн орлогын хуваарилалт нь хөдөлмөрчдийн цалин хөлсний хуваарилалтаас илүү жигд бус байдаг байгаа юм. Ядуу болон дундаж орлоготой нийгмийн бүлэг орлогын үлэмж хэмжээг хөдөлмөрөөрөө бүрдүүлдэг билээ.

Үүнтэй адил технологийн өөрчлөлт нь ур чадвартай ажиллах хүчний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлж, дээд боловсрол, ур чадвартай хүний нөөцийн үр өгөөж нэмэгдэхэд хүргэсэн юм. Эцэст нь дэд бүтэц сайтай, том зах зээлтэй, бусад зах зээлд ойр зэрэг давуу талтай хот суурин газар болон далайн эргийн бүс нь шинэ боломж ашиг тусыг чадвар илүү байдаг. Мөн хот хөдөөд орлогын ялгаа нэмэгдэж байгаа нь Азийн хөгжиж буй зарим оронд тэгш бус байдал нэмэгдэхэд ихээхэн нөлөө үзүүлж байна.

Азийн Хөгжлийн Банк (АХБ) нь олон талт олон улсын хөгжлийн банк бөгөөд 67 гишүүнтэйгээс 48 нь тус бүсийнх, 19 нь дэлхийн бусад бүс нутгийнх юм. Өнгөрсөн 20 жилийн хугацаанд АХБ нь Монгол улсын хөгжлийн хамгийн том санхүүжүүлэгч байж ирсэн бөгөөд хөдөө аж ахуй, боловсрол, эрчим хүч, эрүүл мэнд, аж үйлдвэр, харилцаа холбоо, тээвэр болон хотын хөгжил зэрэг салбарт санхүүгийн болон техникийн тусалцаа үзүүлсэн болно. ■

ОЮУТОЛГОЙН БУЛАН

СТАНДАРТ

“Оюутолгой” төсөл 168 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь шинэ стандарт аж.

Б.АЛТАЙ

“Оюутолгой” төслийн галт тэрэг хөдөлчихсөн. Илчит тэрэг саатах зүйлгүй, торох асуудалгүй холын замдаа гарчээ. Галт тэргэнд амжиж суусан нэгэн нь суудлаа олж, түүнд суух гэсэн нь өртөөний зүг хөвөрсөөр байна. Ийм л хөгжлийн галт тэргэнд гараа өргөсөн монголчууд үр шимийг нь хүртээд эхэлчихлээ. Гараа даллаж, галт тэрэг хөдөлж байсан цаг хэдийнэ бидний ард үлдсэн. Тиймээс илчит тэрэг эцсийн буудалдаа очих үед олон зүйл хувьсан өөрчлөгдөж, ахуй амьдралд маань том шинэтгэл гарч, эдийн засаг одоогийн эрчимтэй өсөлтөө алдахгүй гэдэгт мөрийцөхөд ч бэлэн. Галт тэрэг ч хурдаа нэмсээр очих газар наашилж, холын хөгжил ойртох нь гэсэн итгэл үнэмшилтэй боллоо. Ийм хөгжлийн тасалбартай монголчууд тэр хөгжлийн галт тэрэгнээс хоцрох хүсэлгүй, түүнд сууж “Азийн бар” болохоор тэмүүлж байна. Монгол Улс хөгжих гэж яарч байна.

Гадаадын хөрөнгө оруулалттай хамт санхүүгийн эрх чөлөө, менежментийн болон технологийн ноу-хау (know-how) ирдэг гэж үздэг. Тэгвэл, дэлхийн энтэй хөрөнгө оруулалтыг дагаж, Монголын мэргэжлийн боловсролын салбарт сургалтын шинэ технологи, арга барил, санхүүгийн эрх чөлөө нэвтэрлээ. Тодруулбал, “Оюутолгой” төсөл 168 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалттай сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нь шинэ стандарт аж. Нийгэм, эдийн засгийн салбарт “Оюутолгой” гэсэн менежментийн мөр тодорч, аясын салхи сэвэлзээд эхэлснийг тус салбарын сайд онцлов. Тодорч буй мөр нь шинэ стандартыг уул уурхайгаас гадна улс орны амьдралд тогтоох боллоо. Эдийн засгийн өсөлтийг үйлдвэржүүлэлтийн өгөөжөөр дархлах стандартын үр дүнг зах зээл ч амтлах болов. Дэлхийн хэмжээний өндөр цалинг монголчууд “Оюутолгой” төслөөс авдаг болчихлоо.

Мэргэжилтэй, ажилтай аз жаргалтай амьдрах нь иргэн бүрийн хүсэл мөрөөдлийн нэг хэсэг нь байдаг. Тэгвэл, бүтээлч эрин үеийг төрүүлэх суурь капитал хөрсөө бэлдэж байгааг дуулгахад таатай. Хариуцлагатай уул уурхайн стандарт Монголд нутагшиж, боловсролын хөрсөнд дэлхийн хэмжээний боловсон хүчинг бэлтгэх ажил шуударчээ. Тодруулбал, удахгүй Монголын 30 багш



Австралид мэргэжил дээшлүүлэхээр мордох гэж байна. Тус салбарын ачааны хүндийг үүрэх төлөөлөл бүхий 13 менежер мөн л тус тивийг зорихоор болжээ. “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдэм өвөртөлж ирнэ” гэдэг. Монголын нөхцөлд тохирсон сургалтын хөтөлбөрийн дүнд гадаадад 30, дотоодод 200 залуу “Оюутолгой” төслийн тэтгэлэгт хамрагдан суралцаж байна. Дэлхийн хэл болсон англи хэлийг төгс эзэмших 1200 багшийг бэлтгэх, монголчууд нэг бус хоёр хэлтэй болох аян эрчимжлээ. Зөвхөн сургаж бэлтгээд зогсохгүй 47 сургуульд 36 тэрбум төгрөгийн санхүүгийн хөшүүргийг “Оюутолгой” үзүүлсэн байна.

Эрдэнэт, Дархан, Налайх, Говьсүмбэр, Өмнөговьд ч “Оюутолгой” төслийн өгөөж хэдийнэ хүрчээ. Дээрх газруудад шинэ Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв барьж, өргөтгөн шинэчлэх бүтээн байгуулалтын ▶▶



► ажил өрнөж, ирэх намартай уралдан хүлээлгэн өгөхөөр яаравчилжээ. Мэргэжлийн боловсролыг эзэмшүүлэх, уул уурхайн хүмүүн капиталыг бэлтгэх нь “Оюутолгой” төслийн ажил үүргийн нэг хэсэг гэж үзвэл үүргээ амжилттай хэрэгжүүлсэн гэж тооцож болох нь. Гэхдээ дөнгөж л галт тэрэг хөдөлчихсөн байна.

Орд газрын нөөцөөрөө ч, оруулж буй хувь нэмрээрээ ч дэлхийн хэмжээнд тооцогдох “Оюутолгой” –гоос хариуцлагын тогтолцоо, тогтвортой хөгжил ханглах болов. Үүнийг батлах, дахин нотлох баримт бий. Тэр нь оюун толгойг Оюутолгой бэлтгэхээр шуурхайлан буй дүр зураг. Хамгийн сүүлийн мэдээ гэхэд л Өмнөговь аймгийн Ханбогд суманд нэг ээлжиндээ 150 мэргэжилтэй ажилтан бэлтгэх

техникийн сургалтын төв нээлтээ хийсэн тухай чихэнд чимэгтэй мэдээ сонслоо. Сумын хөгжил ч урагшаа нэг алхлаа. Орон нутгийнхан төслийг шимийг зах зухаас нь хүртээд эхлэв. Тэнд ажлын байрны орон тоо олноор гарч буй. Төв бараадаж хотод сургуульд сурдаг байсан үе ч ард хоцорлоо. Ажлын байрынхаа дэргэд сурч мэдэх, дадлагаших боломж Ханбогдод сая бүрдэв.

Товчхондоо “Оюутолгой” компани Монголын эдийн засагт хөрөнгө оруулахын зэрэгцээ оюуны салбарт ч шинэ стандарт тогтоохоор ажиллаж байгааг тэмдэглэхэд таатай. Цаашдаа уул уурхайн салбарт Оюутолгойн оюуны стандарт гэсэн шинэ ойлголт ч гараад ирэхийг үгүйсгэх аргагүй юм. ■